



TUSS
Tailored Unified System Solution



ЗАЛУУ СУДЛААЧДЫГ
ДЭМЖИХ САН
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА



“АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОДОГ ТОГТОЛЦООГ ӨӨРЧЛӨН
ШИНЭЧЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА”

СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2021 он

ГАРЧИГ

- 1. ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**
- 2. ЗУРГИЙН ЖАГСААЛТ**
- 3. ГРАФИКИЙН ЖАГСААЛТ**
- 4. ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**
- 5. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ**
- 6. СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ**
- 7. САНАЛ ЗӨВЛӨМЖҮҮД**
- 8. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО**
- 9. СУДАЛГААНЫ ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН СУУРЬ ЗАРЧМУУД**
 1. Үндсэн хуулийн үзэл баримтлал
 2. Хүний эрх төвтэй нийгмийн загвар
 3. Системийн онол
- 10. СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ**
 1. Тулгуур ойлголт тодорхойлсон аргачлал
 2. Тодорхой зорилго болон зарчмуудыг тодорхойлох аргачлал
- 11. СУДАЛГААНЫ АЖЛЫН БҮТЭЦ, ҮР ДҮН**
 1. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд холбогдох тулгуур ойлголтууд
 2. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааны онцлог хэв шинжүүд
 3. Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгоход ашигладаг шалгуур, нөхцөл, болзлуудын тогтолцооны хэлбэр, олон улсын практик
 4. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааны зорилгыг Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх хэрэгцээ, шаардлага
 5. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааг зохицуулж буй хууль, эрх зүйн баримт бичиг стандартуудын нэгтгэл
 6. Үндсэн хуулиар тодорхойлсон нийгмийн тогтолцооны нийтлэг тулгуур хэм хэмжээ ба ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд оролцогч талуудын хоорондын харилцааны хэв шинжүүдийн нийцлийн шинжилгээ
 7. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд оролцогч талуудын хоорондын харилцаанд хэлбэрэлтгүй мөрдвөл зохих Үндсэн хуулийн тулгуур зарчмууд
 8. Монгол Улсын Үндсэн хуулийн тулгуур зарчмуудын хоорондын учир шалтгааны шүтэлцээ
 9. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын тулгуур зорилтуудад ҮЗАМ-51 зарчмуудыг ашиглан хийсэн шүүлт
 10. 1994, 1997 оны болон одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулинд Ашигт малтмалын тухай хуулиуд тогтоосон ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагаанд хэрэглэдэг шалгуур, нөхцөл, болзлуудын хэв шинжүүдэд ҮЗАМ-51 зарчмуудыг шалгуур болгон хийсэн шүүлт
 11. ОХУ, Австрали, Канадад мөрдөгддөг Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг зохицуулдаг ижил төстэй хуулиудаар тогтоосон шалгуур нөхцөл болзлуудын хэв шинжүүдэд ҮЗАМ-51-ийг шалгуур болгон хийсэн шүүлт
 12. Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааны онцлогууд ба ҮЗАМ-51 хоорондын харилцан уялдааг хангах хэрэгцээ шаардлага.
 13. Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгоход хэрэглэдэг шалгуур, нөхцөл,

болзлуудыг ҮЗАМ-51 болон төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын тулгуур зорилтуудад нийцүүлэх шийдлүүдийн ерөнхий санаа

12. АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

13. ХАВСРАЛТУУД

- Хавсралт 1. Хөрөнгө оруулагчийн зүгээс тавих шаардлага, нөхцөл, болзол
- Хавсралт 2. Оролцогч талуудын харилцан шүтэлцээний матриц
- Хавсралт 3. Монгол Улсын Үндсэн хуулийн тулгуур зарчмуудын хоорондын учир шалтгааны шүтэлцээ
- Хавсралт 4. ОХУ-ын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох зохицуулалт
- Хавсралт 5. Канад Улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох зохицуулалт
- Хавсралт 6. 1994 оны Ашигт малтмалын тухай хуулийг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн шүүлт
- Хавсралт 7. 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн шүүлт
- Хавсралт 8. 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн шүүлт

1. ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Хүний суурь хэрэгцээний ангилал ба Монгол улсын “Үндсэн хууль”-д заасан иргэний эрхийн харьцуулалт
- Хүснэгт 2. Эрх зүйн баримт бичгийн нэгтгэл
- Хүснэгт 3. ҮЗАМ-51
- Хүснэгт 4. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын шүүлт
- Хүснэгт 5. 1994 оны АМТХ-д ҮЗАМ-51 зарчмуудын нийцлийн дүгнэлт
- Хүснэгт 6. 1997 оны АМТХ-д ҮЗАМ-51 зарчмуудын нийцлийн дүгнэлт
- Хүснэгт 7. 2006 оны АМТХ-д ҮЗАМ-51 зарчмуудын нийцлийн дүгнэлт
- Хүснэгт 8. ТЗОСШЖ-ыг ҮЗАМ-51 зарчмуудын нийцлийн дүгнэлт
- Хүснэгт 9. ОХУ-ын Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тогтолцооны хэв шинжүүдэд хийсэн дүгнэлт
- Хүснэгт 10. Австралийн Викториа мужийн дүгнэлт
- Хүснэгт 11. Баруун Австрали мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тогтолцооны хэв шинжүүдэд хийсэн дүгнэлт
- Хүснэгт 12. Канад улсын Саскачеван мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тогтолцооны хэв шинжүүдэд хийсэн дүгнэлт

2. ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Монголын Улсын нэгдмэл зорилго
- Зураг 2. Хүний суурь хэрэгцээний ангилал, тэдгээрийн уялдаа
- Зураг 3. “ХЭТ-16” загварын логик дүрслэл
- Зураг 4. Нийгэмд өгөөжтэй олборлох үйлдвэрийн үйл ажиллагааны загвар
- Зураг 5. Нэгдмэл зорилгын томьёоллын ойлголтын хавтгай
- Зураг 6. Нийгэмд өгөөжтэй олборлох үйлдвэрийн нөөцийг бий болгох үе шатууд
- Зураг 7. 1994 оны Ашигт малтмалын тухай хуулийг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн шүүлт
- Зураг 8. 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн шүүлт
- Зураг 9. 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн шүүлт
- Зураг 10. ТЗОСШЖ-ыг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн шүүлт
- Зураг 11. ОХУ-ын дуудлага худалдаа явуулах үйл ажиллагаанд хэрэглэдэг шалгуур, нөхцөл болзлуудыг ҮЗАМ51 зарчмуудаар шүүсэн шүүлт
- Зураг 12. Австралийн Викториа мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тогтолцооны хэв шинжүүдэд хийсэн шүүлт
- Зураг 13. Баруун Австрали мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тогтолцооны хэв шинжүүдэд хийсэн шүүлт
- Зураг 14. Канад улсын Саскачеван мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тогтолцооны хэв шинжүүдэд хийсэн шүүлт

3. ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

- График 1. Уул уурхайн үйлдвэрүүдэд ажиллаж байгаа хүний тоо
- График 2. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хийсэн хөрөнгө оруулалт
- График 3. Хайгуулын үйл ажиллагааны идэвхжилтийн динамик
- График 4. Хайгуулын талбайн хэмжээ
- График 5. Хайгуулын ажилд зарцуулсан хөрөнгийн хэмжээ
- График 6. Хайгуулын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн

4. ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ОХУ	Оросын Холбооны Улс
ЗСДС	Залуу судлаачдыг дэмжих сан
ТББ	Төрийн бус байгууллага
ТУС	Тохируулгатай угсардаг систем
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭТ	Хүний эрх төвтэй
АМТХ	Ашигт малтмалын тухай хууль
ҮЗАМ	Үндсэн зарчим ашигт малтмал
СИ	Системийн инженерчлэл
НХХЗГ	Нийгмийн хариуцлагын харилцан зөвшилцлийн гэрээ
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МБЧ	Мэргэжлийн болон бусад чадвар
ДҮХ	Дуудлагаар үнэ хаялцах
ӨЦХ	Өргөдөл цаг хугацаа

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Ерөнхий зүйл.


Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг үр дүнтэй зохицуулахын тулд хувь хүний болон хүн төрөлхтний амьдралд ашигт малтмалын гүйцэтгэдэг үүргийг сайтар ойлгох, нэгдсэн ойлголттой болох шаардлагатай. Өглөө босоод бие засах, шүдээ угаах, цай, хоол хүнсээ бэлтгэхэд цайгаа уух, нүүр нүдээ гоёх, гоодох, халуун ус хэрэглэх, орон байраа дулаацуулах гээд хүн бүр алхам тутамдаа газрын хэвлийгээс ямар нэг аргаар ялган авсан бүтээгдэхүүн хэрэглэдэг. Халбага, сэрээ, оо энгэсэг, машин тоног, төхөөрөмж, гар утас, талх тариаг үйлдвэрлэх, хэрэглэхийг ашигт малтмалгүйгээр төсөөлөхийн ч аргагүй. Ашигт малтмалыг хайх, ашиглах талаар хуримтлуулсан мэдлэг нь тухайн орны хөгжлийн нэг чухал үзүүлэлт ч мөн. Улс орны эдийн засагт уул уурхайн үйлдвэрлэл мөн л чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, ажлын байр бий болгох, экспортыг нэмэгдүүлэх, нийгэм эдийн засгийн бүхий л салбарт бизнесийг дэмжсэн нэмэлт эрэлт хэрэгцээг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх гээд олон чиглэлээр уул уурхайн үйлдвэрлэлийн эерэг нөлөө их.

Манай улсын хувьд уул уурхайн салбар нь ДНБ-ний 25 хувийг дангаар бүрдүүлдэг томоохон салбар юм. Эдийн засгийг хөгжүүлэхэд шаардлагатай гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь манай улсын уул уурхайн салбарт хийгддэг.

Нийгэм эдийн засагт үр өгөөжтэй уул уурхайн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх суурь нөхцөл нь ашигт малтмалын нөөцийг хайж илрүүлэх, улмаар түүний нөөцийн чанар болон хэмжээг тогтоох үйл ажиллагааг тогтвортой эрхлэх явдал юм.

Хайгуулын үйл ажиллагаа нь маш өндөр эрсдэлтэй, хөрөнгө оруулалт болон олон жилийн тасралтгүй тууштай хүчин чармайлт шаарддаг онцлогтой. Ийм онцлогт нь тохирсон оновчтой бодлогыг хэрэгжүүлж чадвал нийгэмд өгөөжтэй уул уурхайн үйлдвэрлэлийг хөхүүлэн дэмжих боломжтой. Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагаанд гадаадаас хөрөнгө оруулалтыг татах бодлогыг хэрэгжүүлэхэд зонхилох үүрэг гүйцэтгэсэн Ашигт малтмалын хуулийг 1997 онд баталж мөрдүүлсэн нь цаг үеэ олсон, шийдвэртэй, оновчтой арга хэмжээ нь бодит үр дүнд хүргэж чаддагийн тод жишээ мөн. Энэ хууль нь ил тод байдал, хэрэгжүүлэхэд хялбар байдлаараа хөрөнгө оруулагчдын талархлыг хүлээсэн төдийгүй лицензийн төлбөрөөр улсын төсөвт ихээхэн орлого оруулсан юм.

Уул уурхайн үйлдвэрүүдэд ажиллаж байгаа хүний
ТОО



Эх сурвалж: АМГТГ

График 1. Уул уурхайн үйлдвэрүүдэд ажиллаж байгаа хүний тоо /Хавсралтаас том зургийг харна уу/

1990 оноос хойш төр, засгаас хайгуулын ажилд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг хэрэгжүүлж ирсэний үр дүнд ашигт малтмалын хэдэн арван орд газруудыг нээн илрүүлж нөөцийг нь тогтоосон төдийгүй өдгөө олон үйлдвэрүүд байгуулагдаж нийгэм, эдийн засагт дорвитой хувь нэмэр болж байна. Гэвч сүүлийн жилүүдэд янз бүрийн шалтаг, шалтгаануудаар хөрөнгө оруулалтыг дэмжиж чадаж байсан хууль эрх зүйн орчныг олон удаа өөрчилж эрчимтэй өргөжин тэлж, хөгжиж байсан хайгуулын үйл ажиллагаа хумигдлаа.

Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдийн арга барилд оршиж байсан олон доголдлууд /байгаль орчны талаар хүлээсэн үүргээ дутуу ухамсарласан, үйл ажиллагааныхаа онцлогийг ойлгуулах, танин мэдүүлэх арга барил дутагдсан гэх мэт/, улс төрчдийн популист амлалтууд, нийгмийн сэтгэл зүйн хуучинсаг байдал, ашигт малтмалын эрэл хайгуулын чиглэлээр улсын төсвөөс санхүүжилт гаргадаг хуучин уламжлалт практик зэрэг олон шалтгаануудын улмаас хуулиудад цэгцгүй, харалган өөрчлөлтүүдийг оруулснаар хөрөнгө оруулалтын орчин эрс өөрчлөгдсөн. 1994 онд баталсан хуулийг 3 жилийн дараа, 1997 онд баталсан хуулийг 9 жилийн дараа бүхлээр нь өөрчилж, 2006 онд баталсан хуулиндаа 2019 он хүртэлх хугацаанд нийт 34 удаа нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулсан байна. Ингэж огцом олон өөрчлөлтүүдийг богино хугацаанд хийж байгаа нь энэхүү салбарыг зохицуулагч хууль, эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулахдаа чанартай өгөгдөл дээр суурилсан судалгаа шинжилгээн дээр үндэслэдэггүй, Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлдэггүй, уул уурхайн салбарын үйл ажиллагаа улс төрчдийн хувийн үзэл баримтлалаас шууд хамааралтай зэрэг олон хүчин зүйлүүдээс хамааралтай байгааг харуулж байна. Цаашид эдгээр хүчин зүйл бүрийн нөлөөллийг нарийвчлан судалж шинжилж байж ямар нэг өөрчлөлтийг хуулинд оруулах эсэхийг шийдвэрлэдэг арга, нөхцөлийг бүрдүүлэхгүй бол уул уурхайн салбар нь нийгмийг дэмжиж өгөөжөө хүртээдэг үйл ажиллагаа биш харин ч нийгмийг талцуулдаг, тогтворгүй байдал үүсгэдэг тоглоомын талбар болон хувирч байна.

Үндсэн хууль нь аль ч улсын нийгмийн бүхий л салбарт үйл ажиллагаа явуулдаг бүх оролцогчдын үйл ажиллагааг нэгдмэл зорилго руу чиглүүлдэг, тэдгээрийн үйл ажиллагааг хооронд нь уялдуулдаг, оролцогч талуудын үйл ажиллагааг нэгдмэл зорилгод нийцүүлэх замаар нийгэмд тогтвортой орчинг бүрдүүлдэг байх учиртай. Монгол улсын Үндсэн хууль нь нийгэмд ийм үүрэг гүйцэтгэх, нийгэмд зөвшилцөл үүсгэх, зохицуулах чадвартай эрх зүйн үндэслэл болж чадахыг судлаачдын хийсэн олон судалгаанууд нотолдог. Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг ч энэхүү зохицуулалтын гадна үлдээх учиргүй.

Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааг зохицуулдаг хуулинд ойрхон ойрхон давтамжтайгаар олон өөрчлөлтүүдийг оруулаад байгаа бодит байдал нь хууль санаачилах эрх бүхий этгээдүүд тухайн хуулинд оруулах аливаа өөрчлөлтийг санаачилах, боловсруулахдаа Үндсэн хуулиар тодорхойлсон үзэл баримтлал, зарчмуудтай нийцүүлэх, уялдуулах ажлыг орхигдуулаад байна гэдэг дүгнэлтийг хийхэд хүргэж байна.

Энэхүү судалгаагаар Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулиар тогтоосон ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тогтолцооны хэв шинжүүдийг буюу тусгай зөвшөөрөл олгоход тавигддаг шалгуур, нөхцөл, болзлуудыг Үндсэн хуулиар тогтоосон суурь зарчмуудтай

харьцуулах, Австрали, Канад, ОХУ зэрэг орнуудаар төлөөлүүлэн олон улсад ашигладаг тусгай зөвшөөрлийн шалгуур, нөхцөл, болзлуудтай мөн харьцуулан дүгнэлт гаргах, улмаар ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрөл олгоход тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн санал, зөвлөмжийг боловсруулах, дэвшүүлэх зорилго тавьсан.


Ашигт малтмалын тухай хуулийн үүсэл, өөрчлөлт, доголдлууд

Ардчилсан хувьсгал гарснаас хойш 2021 он хүртэл хугацаанд Монгол улсад Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаатай холбоотой хэд хэдэн хуулиудыг батлан мөрдүүлж байсан түүхтэй. Эдгээр хуулиудаас 1997 оны хуулийг хэрэгжүүлснээр хамгийн өндөр эрсдэлтэй бизнесийн үйл ажиллагаануудын төрөлд зүй ёсоор багтдаг ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаанд хөрөнгө оруулалтыг дэмжих орчинг бүрдүүлж улмаар 1997 оноос өмнө Монголд хайгуулын үйл ажиллагаа эрхэлж байсан компаниудын тоо эрс нэмэгдэж үйл ажиллагаа нь эрс идэвхэжсэн. Улмаар Монгол улсад хайгуулын үйл ажиллагаа эрхэлж байсан компаниудын хайгуулын ажилд зарцуулсан хөрөнгийн хэмжээ тогтвортой өсөж 2004 онд дэлхийн хэмжээнд хайгуулын ажилд хувийн хэвшлийн компаниудын зарцуулсан нийт зарцуулсан хөрөнгийн 4 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг Монгол улсын нутаг дэвсгэр дээр явуулсан хайгуулын ажилд зарцуулсан нь олон улсад Монгол улс хайгуулын салбарт ихээхэн өрсөлдөх чадвартай эрх зүйн орчинг бүрдүүлж чадсаны нотолгоо болж байлаа. Гадаад, дотоодын компаниуд хайгуулын ажилд их хэмжээний хөрөнгө зарцуулснаас гадна хайгуулын лицензийн төлбөрийн хэлбэрээр улсын төсөвт жил бүр олон тэрбум төгрөгийн орлого оруулдаг болсон. Гадаад, дотоодын хайгуулын компаниуд олон тооны иргэдийг ажлын байраар хангаж, геологийн судалгаа шинжилгээний мэргэжилтэн, материаллаг бааз бэхжиж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн. Ирээдүйд Монгол улсын эдийн засгийн тулгуур болох хэдэн арван орд газруудыг шинээр нээн илрүүлсний хамгийн том нь Оюу Толгойн зэсийн орд газар юм. Уг орд газрыг нээн илрүүлэх, уг ордын нөөцийн цар хүрээ, бүтэц, тогтоц, агуулгыг танин мэдэхэд шаардлагатай тоон өгөгдлийг бий болгохын тулд 2005 оны байдлаар нийт 500 гаруй мянган тууш өрөмдлөгийн ажил хийж, хайгуулын ажилд нийтдээ 500 сая доллар зарцуулсан тоо баримт байдаг.

Монгол улсын гадаад харилцаанд ч дорвитой эерэг өөрчлөлтийг бий болгох суурь тавигдаж эдийн засгийн тулгуур болсон уул уурхайн салбарт, түүний дотор хайгуулын салбарт хөрш хоёр орноосоо гадна гуравдагч хөрш орнуудаас ч хөрөнгө оруулалтыг амжилттай татаж чадсан.

Ийнхүү хөрөнгө оруулалтыг татсанаар Монгол улсын Үндсэн хуулиар тогтоосон суурь зарчмууд амжилттай хэрэгжиж нийгмийн олон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, түүний дотор ажлын байр, экспортын орлого, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, нийгмийн болон үйлдвэрлэлийн дэд бүтцийг хөгжүүлэх үндэс суурь бодитой тавигдсан.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хийсэн хөрөнгө оруулалт /тэрбум төгрөг/



Эх сурвалж: АМГТГ

График 2. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хийсэн хөрөнгө оруулалт /Хавсралтаас том зургийг харна уу/

Нэгэн цагт хайгуулын салбарт хөрөнгө оруулалтыг ихээр татаж нийгэм эдийн засгийн дорвитой эерэг өөрчлөлтүүдийг авчрах эхлэлийг тавьсан хууль тогтоомждоо алсын хараагүй популист өөрчлөлтүүдийг хийснээр хайгуулын үйл ажиллагаа эрс татарч зогсонги байдалд орсон төдийгүй хайгуулын лицензтэй холбоотой маргааны тоо эрс нэмэгдэж нийгэмд хайгуулын ажлын талаар ихээхэн сөрөг ойлголтуудыг бий болсон. Нөгөө талаар уул уурхайн үйлдвэрүүд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хуулиар болон ёс зүйн хувьд хүлээсэн үүргээ биелүүлэхэд хөшүүн хойрго хандсан, уул уурхайн үйлдвэрлэлээс нийгэмд үзүүлдэг үр нөлөөний талаар нэгдмэл ойлголтыг үүсгэхэд шаардлагатай хэмжүүр, шалгуур, загварыг боловсруулан гаргаагүйгээс нийгэмд уул уурхайн үйлдвэрлэл, салбарын талаар ихээхэн зөрүүтэй ойлголтууд үүссэн зэрэг хүчин зүйлүүд мөн сөрөг нөлөө үзүүлсэн.

Мөн түүнчлэн 1994, 1997, 2006 онуудын Ашигт малтмалын тухай хуулиудад салбарын онцлогтой тулгуур ойлголтуудыг илэрхийлдэг нэр томъёонуудыг нарийн мэргэжлийн хэв шинжүүдээр тодорхойлноос уг хуулийн хэрэгжилтийг бусад хуулиудтай, ялангуяа Үндсэн хуультай нийцүүлэн зохион байгуулахад ойлголтын зөрүүнүүд их үүсч ийм зөрчилдөөнүүд нь популист амлалт, бодлогыг төрүүлэн гаргах хөрс суурь нь болсон.

Ашигт малтмалын тухай хуулиар тодорхойлсон оролцогч талуудын эрх үүргүүдийг Үндсэн хуулийн суурь зарчмууд болон бусад салбар хуулиудын холбогдох заалтуудтай нийцүүлэх шийдлүүдийг дутуу дулимаг боловсруулсан, геологийн шинжлэх ухаанд хандах нийгмийн хандлага, ойлголт нь зөвхөн ашигт малтмалын эрэл хайгуулын тухайн ойлголтоор хязгаарлагдсан, түүнийг нь залруулах цэгцтэй бодлого хэрэгжүүлээгүй зэрэг доголдлууд салбарын асуудал хариуцсан яам болон

салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд байсныг энд дурьдах нь зүйтэй. Хуучин нийгмийн үед улсын болон гадаадын зээлийн хөрөнгөөр ашигт малтмалын хайгуулын ажил гүйцэтгэдэг байсан төсөөлөл, оюуны загвар нийгмийн дунд зонхилсоор олон олон асуудал үүсгэсээр байхад хувийн хөрөнгө оруулалтаар уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх болсон бодит шалтгаан, давуу сул талууд, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлөх үүргийг ногдуулах болсон шалтгаан, үзэл баримтлалыг иргэдэд ойлгон таниулах ажлыг уул уурхайн салбарынхан ч, боловсролын салбарынхан ч хийгээгүй учраас иргэдийн дунд ашигт малтмалын нөөцийг ашиглуулах нь зөвхөн бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдад ашигтай, өгөөжтэй, иргэдэд хүртээлгүй, өгөөжгүй байна гэсэн өрөөсгөл ойлголт зонхилсоор байна.

Хайгуулын үйл ажиллагааны идэвхжилтийн динамик





График 3. Хайгуулын үйл ажиллагааны идэвхжилтийн динамик /Хавсралтаас том зургийг харна уу/


Хайгуулын талбайн хэмжээ /га/



Эх сурвалж: АМГТГ

График 4. Хайгуулын талбайн хэмжээ /Хавсралтаас том зургийг харна уу/


Хайгуулын ажилд зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/



Эх сурвалж: АМГТГ

График 5. Хайгуулын ажилд зарцуулсан хөрөнгийн хэмжээ /Хавсралтаас том зургийг харна уу/

Хайгуулын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн



Эх сурвалж: АМГТГ

График 6. Хайгуулын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн /Хавсралтаас том зургийг харна уу/

СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх хэрэгцээ шаардлага

1. Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагаа, түүнд зарцуулж байгаа хөрөнгийн хэмжээ байнга буурсаар 2020 оноос зогсонги байдалд орсны улмаас улсын бүртгэлд бүртгэгдсэн ашигт малтмалын нөөцийн хэмжээ үлэмж хэмжээгээр тогтвортой буурч Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд зонхилох үүрэг гүйцэтгэдэг уул уурхайн салбарын үйл ажиллагаанд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх хэмжээнд хүрчээ. Ялангуяа, ийм сөрөг нөлөө ажлын байр, төсвийн болон экспортын орлого, улсын валютын нөөц зэрэг макро үзүүлэлтүүдэд үзүүлэх нөлөөнүүд нь гинжин урвал маягаар тархах магадлалтай.
2. Уул уурхайн салбараас нийгэмд үзүүлдэг нөлөөллийг хэмждэг хэмжүүр үзүүлэлтүүд тодорхойгүй, улс төрийн тогтолцоо нь сонгуулийн мөчлөгт захирагддаг, иргэд социализмын үеийн хэвшмэл ойлголтуудаасаа салаагүй байгаа, уул уурхайн үйлдвэрлэл эрхлэхэд тавигдах стандарт шаардлагууд нь тодорхойгүй, чанартай хууль боловсруулах ур чадваргүй, уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдийн нийгмийн хариуцлага, ур чадвар нь сул зэрэг олон хүчин зүйлүүд дээрх байдлыг үүсгэхэд нөлөөлжээ.
3. Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх үр дүнтэй, дорвитой арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэхгүй бол нийгэм, эдийн засгийн олон тулгамдсан асуудлууд улам хурцдаж, түүгээр барахгүй олон асуудлууд шинээр үүсэх болно.
4. Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх арга хэрэгслийг төлөвлөх, боловсруулахдаа уламжлалт сэтгэлгээний хэв маягаасаа татгалзаж байнга өөрчлөгдөж буй орчиндоо тохирсон арга хэрэгслийг шинэ сэтгэлгээгээр хөгжүүлж хэрэгжүүлэх

шаардлагатайг 1990 оноос хойш батлан гаргасан хуулиуд, тэдгээр хуулиудыг хэрэгжүүлсэн туршлага, сургамжууд нотолж байна.

Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааны тулгуур ойлголтуудыг тодорхойлох, уялдуулах чиглэлээр:

1. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааг зохицуулах зориулалттай хууль эрх зүйн баримт бичгүүдэд түгээмэл хэрэглэгддэг боловч тухайн үйл ажиллагаанд оролцогч талууд өөр өөрийнхөө үзэмжээр тайлбарладаг, хэвшмэл болсон 43 ойлголтуудыг ялгаж тогтоов.
2. Энэхүү жагсаалтауд хамрагдсан ойлголт бүрийн зонхилох хэв шинжүүдийг СИ аргачлалыг ашиглан системийн суурь шаардлагад нийцүүлэн /хэмжих, шалгах боломжтой байх/ тодорхойлж, улмаар тухайн ойлголтын хэв шинжүүдийг энэхүү жагсаалтанд хамрагдсан бусад ойлголтуудын хэв шинжүүдтэй зөрчилдөхгүй байхаар уялдуулан цэгцлэв.

Үндсэн хуулиар тогтоосон тулгуур зарчмуудыг ялгах, тэдгээрт Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нийцүүлэх чиглэлээр

1. Судалгааны ажлын үр дүнд Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын тулгуур зарчмуудын үүргийг гүйцэтгэдэг, ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд шууд оролцогч талуудын үйл ажиллагаанд хэлбэрэлтгүй мөрдөгдөх ёстой 51 тулгуур зарчмуудыг ялгаж тогтоов. /ҮЗАМ-51 хэмээн товчлон нэрлэв/
2. Эдгээрээс 9 зарчим нь иргэдийн үйл ажиллагаанд, 1 зарчим нь улс төрийн намуудын үйл ажиллагаанд, 41 зарчмууд нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөгдөх ёстой зарчмууд байна.
3. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд оролцогч талуудын гүйцэтгэх үүргүүдийг тодорхойлдог хууль эрх зүйн актууд /хууль, дүрэм, журмууд/ -аар тогтоодог үүрэг/үйлдлийн заалт бүр нь дээрх ҮЗАМ-51 зарчмуудад бүрэн нийцэж байвал тухайн эрх зүйн акт нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд бүрэн нийцэж байна гэж дүгнэж болохоор байна.
4. ҮЗАМ-51 зарчмуудыг шалгуур болгон 1994, 1997, 2006 оны Ашигт малтмалын тухай хуулиудын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг зохицуулдаг бүлэгт тодорхой заалтуудаар тогтоосон үүрэг бүрийн хэв шинжүүдэд шүүлт хийж үзэхэд 1997 оны Ашигт малтмалын тухай хууль нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд хамгийн илүүтэй нийцсэн байжээ гэдэг дүгнэлтэд хүрэв.
5. Мөн ҮЗАМ-51 зарчмуудыг шүүлтүүр болгон Австрали, Канад, ОХУ-д мөрдөгддөг ижил төстэй хуулиудаар тогтоосон үүргүүд/үйлдлүүдийн хэв шинжүүдэд мөн шүүлт хийв.
6. ОХУ-ын хууль, дүрмүүд нь холбооны улсын суурь хэв шинжүүдэд суурилсан байдгаас тэдний ашигт малтмал хайгуулын зөвшөөрөл олгодог процесс нь олон шат дамжлагатай байдаг, мөн шалгуурууд нь ҮЗАМ-51 зарчмуудын заримд нь харшилж байгаа учраас ОХУ-д ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгодог тогтолцооны загвар нь Монголын нөхцөлд тохирохгүй гэж үзлээ.
7. Ашигт малтмалын хайгуулын ажилд ихээхэн хөрөнгө оруулалтыг тогтвортой татаж чадаж байгаа Австрали, Канад улсуудын зарим мужуудын First come- first serve зарчимд суурилсан ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход тавигддаг шалгуур, нөхцөл, болзлууд нь ҮЗАМ-51 зарчмуудад харшлахгүй, хувийн хөрөнгө оруулалтыг татах чадвартай нь нотлогдсон, бас 1997-2006 онуудад Монгол улсын уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татаж чадсан 1997 оны Ашигт малтмалын тухай хуультай үзэл баримтлалаараа төстэй байгааг үндэслэн цаашид Австралийн Баруун Австрали мужийн загварыг илүү нарийвчилан судлах нь зүйтэй гэж үзэв.

Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааны онцлогууд ба ҮЗАМ-51 зарчмуудын хоорондын харилцан уялдааг хангах чиглэлээр:

1. Хайгуулын ажлын улмаас байгаль орчин болон, нийгмийн гишүүдийн эрх ашигт сөрөг нөлөө үзүүлсэн тохиолдолд нэгэнт олгосон хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцалдаг аргаас татгалзаж, харин хайгуулын ажлыг түдгэлзүүлэх, зогсоох, торгох зэрэг арга хэлбэрүүдийг уян хатан хослуулж хэрэглэдэг болох
2. Татвар төлөгчдийн хөрөнгийг ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаа шиг өндөр эрсдэлтэй, үнийн хэлбэлзлээс хамаарал ихтэй бизнесийн төслүүдэд зарцуулдаг практикийг эцэслэх.
3. Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг тухайн талбайд геологийн суурь судалгааны ажлуудыг заавал гүйцэтгэдэг, түүний үр дүнд хуримтлуулсан өгөгдөл, мэдээллийг үнэ төлбөргүйгээр Улсын Геологийн мэдээллийн санд хүлээлгэн өгдөг болзолтойгоор олгодог болох.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүч, хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнд ашигт малтмалын ордын талаар бий болгосон өгөгдөл, мэдлэг нь тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувийн өмч гэдгийг хүлээн зөвшөөрч уг өмчөө тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ҮЗАМ-51 зарчимд нийцсэн арга, хэлбэрээр бусдад чөлөөтэй шилжүүлэх боломжийг хуульчлан тогтоох
5. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааны бүхий л шат дамжлагад ҮЗАМ-51 зарчмуудыг хэлбэрэлтгүй мөрдүүлэхэд шаардлагатай хэмжүүр, шалгуур, стандартуудыг нарийвчлан тодорхойлж албажуулах

Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг идэвхжүүлж нийгэмд өгөөжтэй олборлох үйлдвэрүүдийг Монголд хөгжүүлэх зорилгыг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа асуудлуудыг үүсгэж байгаа суурь шалтгаануудыг тогтоох, засах чиглэлээр

1. 1994, 1997, 2006 онуудын Ашигт малтмалын тухай хуулиудаар ашигт малтмалын нөөцийг хайх ажлыг идэвхжүүлэх ажлын эцсийн зорилгыг албан ёсоор тодорхойлоогүйн улмаас хайгуулын ажилд хөрөнгө оруулалтыг дэмжих, идэвхжүүлэх талаар нэгдсэн ойлголтыг нийгэмд бий болгож чадаагүй гэж үзэж байна. Ийм учраас судалгааны баг нийгэмд өгөөжтэй олборлох үйлдвэрлэлийг бий болгох нь ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааны эцсийн зорилго нь байх ёстой гэдэг концепци, түүний томъёоллыг боловсруулан санал болгож байна.
1. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааг дэмжих бодлогыг Монгол улсын Үндсэн хуулиар тодорхойлсон иргэдийн эрх, эрх чөлөөний ойлголтуудтай нийцүүлэх оюуны шийдлийг гаргаагүй байгаагаас боловсруулсан бодлого нь зорьсон үр дүнд хүргэж чадахгүй байна. Жишээлбэл, 2021 оны 3 дугаар сарын байдлаар хүчин төгөлдөр байгаа Ашигт малтмалын тухай хуулиар тодорхойлсон ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрөл олгоход баримталдаг шалгуур нь Монгол улсын Үндсэн хуулиар тогтоосон тулгуур зарим зарчмуудад нийцэхгүй байна.
2. Хуулиудыг боловсруулах, хэлэлцүүлэх, батлах үйл ажиллагаанд заавал мөрдөгдвөл зохих тухайн хуулиудын үзэл баримтлал, тулгуур ойлголтуудыг Үндсэн хуулийн үзэл баримтлал, зарчмуудад нийцүүлдэг, шалгадаг нэгдсэн арга аргачлалыг боловсруулж гаргаагүйгээс Ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагааг зохицуулдаг багц хуулиуд хоорондоо үзэл баримтлал болон логикийн хувьд зөрчилддөг.
3. Үндсэн хуулийн үзэл баримтлал, суурь зарчмууд болон тэдгээрийн хоорондын шүтэлцээг

нийтээрээ ойлгож танин мэдэх, нэгдсэн ойлголттой болоход чиглэгдсэн цэгцтэй арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлээгүй улмаас иргэд Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаа эрхлэгчдэд зөвхөн өөрийн үзэмж, шалгуураар ханддаг.

4. Гадаадын сайн туршлагыг Монголд нэвтрүүлэхдээ түүнийг Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх, тохируулах шалгуур болон бусад харьцуулалтын шийдлүүдийг хөгжүүлж гаргаагүй, хэрэглэж дадаагүй учраас Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааны үр ашиг, өгөөж, хүртээмжийг сайжруулах чиглэлээр гадаад орнуудтай хамтран хэрэгжүүлдэг төслүүдийн өгөөж нь чамлалттай, зарим тохиолдолд хоорондоо зөрчилддөг.

Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгоход баримтлах шалгуур, нөхцөл, болзлыг харьцуулсан үр дүнгийн талаар:

1. Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгоход баримталдаг шалгуур нь олон улсын хэмжээнд олон янз байдаг боловч тэдгээрийг үндсэн гурван бүлэгт ангилж авч үзлээ.
 - Мэргэжлийн болон бусад чадамжаар нь харьцуулан сонгож тусгай зөвшөөрөл олгох /МБЧ/
 - Дуудлагаар үнэ хаялцуулж өндөр үнэ санал болгосныг нь сонгож тусгай зөвшөөрөл олгох / ДҮХ/
 - Хуулийн шаардлага хангасан өргөдөл /хүсэлтийг гаргасан цаг хугацааны хувьд анхдагчийг нь сонгож тусгай зөвшөөрлийг олгох/ ӨЦХ/
2. Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах шалгуурын үүргийг гүйцэтгэж байгаа, хүчин төгөлдөр Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалтуудаар тогтоосон МБЧ шалгуурыг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүж үзэхэд ийм шалгуур нь Монгол улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлээр тогтоосон зарчимтай зөрчилдөж байна гэж дүгнэв.
3. Мөн ДҮХ шалгуураар ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгодог практикийн жишээ болгож ОХУ-ын зарим субъектүүдэд мөрдөгддөг хууль, дүрмийн холбогдох заалтуудаар тогтоосон шалгуур буюу ДҮХ-д суурилсан шалгуурыг ҮЗАМ-51 зарчмуудтай харьцуулж үзэхэд Монгол улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйл болон 16 дугаар зүйлээр тогтоосон зарчмуудтай нийцэхгүй байна гэж дүгнэв.
4. Түүнчлэн, ӨЦХ шалгуураар ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгодог практикийн жишээ болгож Австрали, Канад улсуудын зарим мужуудын хууль тогтоомжууд, Монгол улсын 1997 оны ашигт малтмалын тухай хуулиар тогтоосон оролцогч талуудын үүрэг бүрийн хэв шинжүүдийг ҮЗАМ-51 зарчимтай харьцуулж үзэхэд уг шалгуур нь ҮЗАМ-51 зарчмуудтай зөрчилдөхгүй байна гэж дүгнэв.
5. ҮЗАМ-51 зарчимтай харьцуулсан дээрх шүүлтүүдийг зөвхөн ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулдаг заалтуудаар тодорхойлсон үүргүүдийн хүрээнд л хийсэн бөгөөд цаашид ашигт малтмалын нөөцийг хайх ашиглах үйл ажиллагааг шууд болон шууд бусаар зохицуулдаг бүх хууль, дүрэм, журмуудын бүх заалтуудад нэгдсэн журмаар хийх шаардлагатай.
6. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааг шууд болон шууд бусаар зохицуулдаг багц хуулиудад хийсэн системийн шинжилгээгээр тэдгээр хуулиудын заалтууд нь хоорондоо зөрчилтэй, давхцалтай, хэмжих шалгах боломжгүй, хувь хүний үзэл бодол, үзэмжээс ихээхэн хамааралтай заалтуудыг агуулсан зэрэг олон төрлийн системийн доголдолтой нь тогтоогдлоо.

Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгоход тавигдах шалгуур, нөхцөл,

болзлын өөрчилж тогтолцоог сайжруулах чиглэлээр

1. Хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагаа/процессыг илүү нарийвчилсан, тодорхой зорилготой үе шатуудад задлан зохион байгуулснаар уг үйл ажиллагааг дорвитой сайжруулах боломж бүрдэнэ гэж үзэж дараах ерөнхий санааг нарийвчлан судалж үзэхийг санал болгож байна. Үүнд:
 2. Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгох процессыг дараах 3 үе шатуудад задлан хуваарилах нь оновчтой байна:
 - Тодорхой талбайд ашигт малтмалын нөөцийг хайх хүсэлт гарсан өргөдлийг үндэслэн эрхийг үүсгэж бүртгэх, баталгаажуулах үе шат
 - Ашигт малтмалын нөөцийг хайх эрх эзэмшигчийг нийгмийн хариуцлага хүлээх чадамжтай болгох үе шат
 - Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийг үүсгэх, баталгаажуулах үе шат
 3. Ашигт малтмалын нөөцийг хайх эрх үүсгэх, баталгаажуулах үе шатыг тусад нь ангилж үүсгэснээр Үндсэн хуулийн 16-р зүйлд заасан эрхийг баталгаатай үүсгэх, бүртгэх, баталгаажуулах боломжтой бүрдэж, процесс нь энгийн хялбар ойлгомжтой болох давуу талтай.
 4. Нийгмийн хариуцлагын чадамжийг бүрдүүлэх үе шат нь Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг авахаар хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийг нийгмийн хариуцлага хүлээх буюу Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд заасан нийтлэг үүргүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай чадамжтай болгох, түүнийг хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэх юм.
 5. Төрөлжсөн үүргүүдийг үүсгэх, баталгаажуулах үе шат нь тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн/хуулийн этгээдэд ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг эрхлэх болсонтой холбогдуулан үүсэх төрөлжсөн үүргүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн мэдлэг, санхүү болон бусад хөрөнгийн нөөц, дагаж мөрдөх стандартуудын талаар сургалтанд хамруулах, нэгдсэн ойлголтуудыг оролцогч талуудын дунд бий болгох, түүнийг баталгаажуулахад чиглэнэ. Энэ үе шатанд мөн тухайн иргэн/хуулийн этгээд болон Засгийн газрын байгууллагын хооронд тодорхой талбайд ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг эрхлэхэд тавигдах шалгуур, нөхцөл, болзлуудын талаар нэгдсэн ойлголтонд буюу харилцан тохиролцоонд хүрснийг баталгаажуулах ажил хийгддэг байхаар зохион байгуулна.

САНАЛ ЗӨВЛӨМЖҮҮД

1. Энэ ажил нь Монголд анх удаагаа нийгмийн системийн инженерчлэлийн аргыг ашиглан тодорхой хууль эрх зүйн актууд, бодлого, хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа холбоог үнэлэх, нийцүүлэхэд чиглэсэн судалгааны ажил болсон тул энэхүү судалгааны дараах дүгнэлт, санаануудыг олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэх нь зүйтэй. Үүнд:
 - Тулгуур ойлголтууд
 - ҮЗАМ-51 зарчмууд
 - Нийгэмд өгөөжтэй олборлох үйлдвэрийн тодорхойлолт
2. Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгох тогтолцоо нь Монгол улсын нийгэм эдийн засгийн тогтолцооны нэгээхэн хэсэг нь мөн тул тусгай зөвшөөрлийн тогтолцооны хэв шинжүүдийг өөрчлөх, сайжруулахдаа тийм өөрчлөлт, сайжруулалтууд нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэж буй эсэхийг шалгадаг тодорхой албан ёсны шалгуур, аргачлалыг хөгжүүлэн гаргах шаардлагатай байна.

3. Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагаа нь Ашигт малтмалын тухай болон бусад багц хуулиудаар зохицуулагддаг тул мөн тэдгээр багц хуулиуд / Байгаль орчин, Газрын хэвлий, Стандарт хэмжил зүй хууль, Хөгжлийн төлөвлөлт гэх мэт / Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэж байгаа эсэхийг шинжлэх.


СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү судалгааны зорилго нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоход тавигдах шалгуур, нөхцөл, болзлуудыг Үндсэн хуулийн суурь зарчмуудтай харьцуулан шинжих, Үндсэн хуулийн суурь зарчмуудтай харшилдаггүй, олон улсад хэрэглэгддэг шалгуур, нөхцөл, болзлуудыг эрэлхийлэх, Монголын нөхцөлд тохирсон шалгуур, нөхцөл, болзлуудын ерөнхий санааг боловсруулан гаргахад оршино.

СУДАЛГААНЫ СУУРЬ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

1. Үндсэн хуулийн үзэл баримтлал

Нэгдмэл нэгэн үзэл баримтлалтай аливаа нийгэм нь урт хугацаанд тогтвортой оршин тогтнож улмаар цэцэглэн хөгждөгийг бид олон орнуудын жишээн дээрээс харж болно. Тэдгээр орнууд тухайн нийгмийнхээ нэгдмэл үзэл баримтлалыг албан ёсоор тодорхойлон томъёолж бүх нийтээрээ дагаж мөрдвөл зохих эрх зүйн баримт бичиг болгон мөрдүүлэх замаар уг үзэл баримтлалыг тууштай хэрэгжүүлж чаддаг. Тийнхүү тодорхойлсон үзэл баримтлалыг Үндсэн хууль гэдэг нэрээр олон хүмүүс мэддэг. Системийн онолын үүднээс авч үзвэл Үндсэн хуулийн үзэл баримтлалын тулгын гурван чулуу нь тухайн нийгмийн нэгдмэл зорилго, уг зорилгыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын гүйцэтгэх нийтлэг үүргүүд болон оролцогч талуудын хоорондын харилцаанд мөрдвөл зохих нийтлэг хэв хэмжээнүүд юм. Нийгмийн нэгдмэл зорилгын үндэс суурийг тухайн нийгмийн гишүүдийн нийтлэг хэрэгцээ шаардлага бүрдүүлдэг бөгөөд энэхүү нийтлэг хэрэгцээ шаардлагыг хэрхэн ойлгож төсөөлж байгаагаас тухайн зорилгын хэв шинжүүд ихээхэн олон янзаар томъёологдсон байдаг тул хүний нийтлэг хэрэгцээний талаар тухайн нийгмийн гишүүдийн ойлголт нэгдмэл байх нь нэн чухал ач холбогдолтой. Хүний суурь хэрэгцээний талаар олон арван онолууд байдаг боловч хүн төрөлхтний хөгжлийн үрээр эдгээр онолуудын зарим нь хуучирч зарим нь хувьсан өөрчлөгдөж байна. Нийгмийн нэгж системийн онолын үзэл баримтлалтай олон талаараа нийцтэй нэгэн онол сүүлийн үед олон улсын хэмжээнд ихээхэн өргөн хэрэглэгдэж байгаа нь Мах Нееф гэдэг хүний боловсруулан гаргасан онол юм.



Зураг 1. Монголын Улсын нэгдмэл зорилго /Хавсралтаас том зургийг харна уу/

Монгол улсын нийгмийн нэгдмэл зорилгыг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд нарийвчлан тодорхойлсон бөгөөд энэ зүйлд заасан иргэний эрх, эрх чөлөөнүүд нь Макс Неефийн ангилалтай логикийн хувьд нийцэж байгаа нь өмнө хийгдсэн судалгаануудаар тогтоогдсон.

Макс Неефийн боловсруулсан хүний суурь хэрэгцээний ангилал:

Хүн амьд байх, амьдрахад зайлшгүй шаардагдах хүчин зүйлсийг **хэрэгцээ** гэж нэрлэдэг. Энэхүү ангиллын дагуу нас, хүйс, мэрэгжил, яс үндэс, нийгэмд эзэлдэг байр сууринаас нь үл хамааран хүн бүрд байдаг нийтлэг суурь хэрэгцээг

1. Амьжиргаа
2. Аюулгүй байдал, баталгаа
3. Ойр дотно байх
4. Ойлгох танин мэдэх
5. Нийгмийн амьдралд оролцох
6. Чөлөөтэй бодох, сэтгэх, өөрийгөө сорих
7. Бүтээх
8. Өөрийгөө илэрхийлэх, хүлээн зөвшөөрүүлэх
9. Эрх чөлөөтэй байх гэсэн 9 төрлийн суурь хэрэгцээнд ангилдаг.

Макс Нееф-ийн онолын дагуу аливаа хүнд дээрх 9 суурь хэрэгцээ нэгэн зэрэг оршдог бөгөөд бусад хэрэгцээгээ хангахгүйгээр аль нэг хэрэгцээгээ дангаар нь хангах боломжгүй гэж үздэгээрээ Маслоу-гийн тодорхойлсон “хүний хэрэгцээний шатлал” гэгдэх загвараас зарчмын ялгаатай.



Зураг 2. Хүний суурь хэрэгцээний ангилал, тэдгээрийн уялдаа

Уг ангиллаар тодорхойлсон хүний нийтлэг суурь хэрэгцээнүүдийн хэв шинжүүдийг Монгол улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний эрх, эрх чөлөөнүүдийн хэв шинжүүдтэй дүйцүүлэн нягталж үзэхэд Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн заалтуудаар тогтоосон иргэний эрх эрх чөлөөнүүд нь хүний суурь хэрэгцээнүүдийг хангахад чиглэсэн эрхүүд мөн бөгөөд Монголын нийгмийн нэгдмэл зорилгын суурь логик үндэслэл нь болж байгааг тогтоосон.

№	Хүний суурь хэрэгцээний ангилал	Монгол улсын Үндсэн хуульд заасан иргэний эрх, эрх чөлөөний ангилал
1	Амьжиргаа	16.1 Амьд явах, 16.3 Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өвчлөх, өв залгамжлуулах эрхтэй
2	Аюулгүй байдал, баталгаа	16.2 Эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй. 16.5 өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй. 16.6 Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй.
3	Ойр дотно байх мэдрэмж	16.11 Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална
4	Ойлгох танин мэдэх	16.7 сурч боловсрох эрхтэй 16.8 соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. 16.5 шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй; 16.17 төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.

5	Нийгмийн харилцаанд оролцох	16.9 шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. 16.10 нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. 16.17 төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.
6	Чөлөөтэй бодох, сэтгэх	16.8 соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй.
7	Бүтээх	16.4 ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. 16.8 соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй.
8	Өөрийгөө илэрхийлэх, хүлээн зөвшөөрүүлэх	16.12 төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. 16.16 итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй
9	Эрх чөлөөтэй байх	16.11 улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. 16.13 халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. 16.18 улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй.


Хүснэгт 1. Хүний суурь хэрэгцээний ангилал ба Монгол улсын “Үндсэн хууль”-д заасан иргэний эрхийн харьцуулалт

2. Хүний эрх төвтэй нийгмийн загвар

“Залуу судлаачдыг дэмжих сан” ТББ болон “ТУС Солюшн” ХХК хамтран 2018 онд гүйцэтгэсэн **“Үндсэн хуулийн үзэл баримтлалыг системийн загвараар шинжилж, дүрслэх нь”** судалгааны үр дүнд Монгол улсын Үндсэн хуулиар тодорхойлсон үзэл баримтлалд суурилсан нийгэм маань зорилгоо хэрэгжүүлэх чадвартай, системийн суурь хэв шинжүүдийг бүрдүүлсэн байна гэсэн дүгнэлт хийсэн. Мөн Үндсэн хуулийн үзэл баримтлалыг дээр дурдсан нийгмийн нэгж системийн логик загварыг ашиглан нийгмийн суурь хэв шинжүүдийг загвараар дүрсэлж, түүнийгээ **“ХЭТ-16”** гэж нэрлэсэн.


ХЭТ гэдэг нь хүний эрх төвтэй гэдэг үгсийн товчлол, 16 гэдэг нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд баталгаажуулсан Монгол улсын иргэний 18 бүлэг эрхийг илэрхийлж буй.

Үндсэн хуулиар баталгаажуулсан эдгээр эрхүүд нь аливаа хүн амьд байх, амьдрахад зайлшгүй шаардлагатай байгалиас заяагдсан бодит хэрэгцээнүүдийг илэрхийлсэн байдаг. Өөрөөр хэлбэл “ХЭТ-16” буюу хүний эрх төвтэй нийгмийн загвар гэдэг нь иргэд эрхээ бүрэн баталгаатай эдлэх боломжтой нийгмийн үзэл баримтлалын загвар юм.



Зураг 3. “ХЭТ-16” загварын логик дүрслэл /Хавсралтаас том зургийг харна уу/

“ХЭТ-16” загварыг ашиглан Нийгэмд өгөөжтэй олборлох үйлдвэрийн үйл ажиллагааны загварыг боловсруулан гаргав. Энэхүү загвар нь ерөнхий суурь хэв шинжүүдийг тодорхойлж байгаа бөгөөд цаашид эдгээр хэв шинжүүдийг нарийвчилан задалж уг үйлдвэр барьж ажиллуулахад шаардлагатай нөөцийг хайх, тогтоох, үйлдвэр барих, ажиллуулах гээд олон үе шатуудад оролцогч талууд болон тэдгээрийн хүлээх үүргүүдийг тогтоох шаардлагатай.



Зураг 4. Нийгэмд өгөөжтэй олборлох үйлдвэрийн үйл ажиллагааны загвар /Хавсралтаас том зургийг харна уу/

3. Системийн онол, системийн шинжилгээний тухай

Системийн инженерчлэлийн ухаан нь 1940 онд үүсэж өнөөг хүртэл хэрэглэгдэж, хөгжиж ирсэн инженерчлэлийн ухаан юм. Олон улсын системийн инженерүүдийн зөвлөл /INCOSE-International council on system engineering/ системийн инженерчлэл гэх ойлголтыг “нарийн төвөгтэй системүүдийг зохион бүтээх, уялдуулах, зохион байгуулахад төвлөрсөн салбар хоорондын инженерчлэлийн ухаан” гэж тодорхойлсон байдаг.

Янз бүрийн түвшиний биет болон нийгмийн тогтолцооны олон хэв шинжүүдийг цогцоор нь шинжилж, сайжруулах хэрэгцээ шаардлагаар хувь хүн, байгууллагууд уг аргачлалыг хэрэглэдэг ба ялангуяа АНУ-ын батлан хамгаалахын салбарт түгээмэл нэвтэрсэн байна.

Харин “Нийгмийн нэгж системийн инженерчлэл” гэх ойлголт нь харьцангуй сүүлд бий болсон ба нийгмийн системийн нарийвчилсан хэв шинжүүд болоод хэрэглээний цар хүрээний тухай дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрсөн нэгдсэн ойлголт хараахан бий болоогүй, хөгжил, төлөвшлийнхөө шатанд байна. Гэсэн хэдий боловч нийгэм эдийн засгийн олон талт харилцааг төлөвлөх, үүсгэх, зохицуулахад нэгэнт үүсч бий болсон системийн инженерчлэлийн шийдлүүдийг улам бүр өргөн ашигладаг болжээ.

Үүний нэг илрэл нь 2019 онд Олон улсын системийн инженерүүдийн зөвлөл /INCOSE-International council on system engineering/-ийн дэргэд Нийгмийн нэгж системийн инженерчлэлийн ажлын хэсэг албан ёсоор байгуулагдсан явдал юм. Мөн түүнчлэн INCOSE-ийн дэргэд Ухаалаг хотын жишиг загварыг боловсруулан гаргах төслийн ажлыг 2019 онд эхлүүлсэн бөгөөд энэхүү төслийн хүрээнд “ТУССолюшн” компанийн зохион бүтээсэн нийгмийн нэгж системийн загвар болон системийн инженерчлэлийн аргуудыг ашиглан Ухаалаг хотын жишиг загварыг боловсруулаад байна.

Энэхүү судалгаанд ашиглагдаж буй нийгмийн системийн инженерчлэлийн шийдлүүдийг ашиглан 2016 оноос жижиг болон дунд хэмжээтэй 50 гаруй нийгмийн нэгж систем /компани, төрийн ба төрийн байгууллага г.м/-д оношилгоо хийж зарим байгууллагуудад үйл ажиллагааг нь системжүүлэх үйлчилгээг үзүүлсэн. Менежментийн уламжлалт арга, аргачлалуудтай харьцуулахад нийгмийн системийн инженерчлэлийн аргачлал нь тухайн системд тулгарч буй асуудлуудыг цогцоор уялдаатай шийдвэрлэх шийдлийг санал болгодоггоороо онцлогтой. Нийгмийн системийн инженерчлэлийн шийдлүүд нь “Системийн зорилгыг албадан хэрэгжүүлэхэд мөрдөгддөг 5 аксиом /ЗАХА-5/” дээр суурилдаг. Тухайлбал:

1. Оролцогч талууд нэгдмэл зорилготой байснаар систем оршин тогтноно.
2. Оролцогч талууд бүгд заавал гүйцэтгэх үүргүүдээ гүйцэтгэснээр системийн нэгдмэл зорилго хэрэгжинэ.
3. Үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай чанартай өгөгдлүүдийг цуглуулж, боловсруулж, түгээдэг байснаар нэгдмэл зорилго хэрэгжинэ.
4. Зорилгын хэрэгжилтийн гүйцэтгэл болон үр дүнг байнга хэмждэг байснаар нэгдмэл зорилго хэрэгжинэ.
5. Зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь байнга төгөлдөрждөг байснаар нэгдмэл зорилго урт хугацаанд, тогтвортой хэрэгжинэ.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ

1. Тулгуур ойлголт тодорхойлсон аргачлал

Аливаа оюуны загвар нь тэдгээрийг үүсгэгч элементүүд буюу ойлголтуудаас бүрддэг. Ойлголт гэдэг нь хүн аливаа юмс, үзэгдлийг бусад юмс, үзэгдлээс ялгарах зонхилох хэв шинжүүдээр нь танин мэдсэнээр хүний оюун ухаанд тухайн юмс, үзэгдлийн бүрэлдэн, хадгалагддаг тусгал юм. Өөрөөр

хэлбэл хүний тодорхой хэрэгцээг хангах зайлшгүй шаардлагаар хүний оюун санаанд бий болсон, оноосон нэртэй цогц хэв шинжүүдийн цогц юм.

Харин тулгуур ойлголт гэдэг нь аливаа зорилгыг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлон илэрхийлэхийн тулд зайлшгүй тодорхой болгох шаардлагатай, тухайн зорилгыг тодорхойлоход хэлний болон утгын хувьд гарцаагүй шаардлагаар ордог ойлголтууд юм. Ийм тулгуур ойлголтыг бусад ойлголтуудаас ялгахад зайлшгүй шаардлагатай хэв шинжүүдээр нь тодорхойлж, тэдгээр хэв шинжүүдийг хооронд нь уялдуулан логик эрэмбэд оруулах замаар тодорхойлдог. Манай судалгааны баг энэхүү судалгаанд хэрэглэгдэж буй тулгуур ойлголтуудыг “ТУС Солюшн” ХХК-аас боловсруулсан “**Тулгуур ойлголтыг тодорхойлох**”-д ашиглагддаг алгоритмын дагуу тодорхойлсон.

Энэхүү судалгаанд хамрагдсан тулгуур ойлголтын тодорхойлолтыг доорх дарааллаар гүйцэтгэв. Үүнд:

1. Тухайн тулгуур ойлголтын тодорхойлолтыг 12-оос доошгүй эх сурвалжаас цуглуулах
2. Тулгуур ойлголт тодорхойлох алгоритмын дагуу ойлголтын хэв шинжүүдийг ангилж, уялдуулах
3. Ангилж, уялдуулсан хэв шинжүүдэд үндэслэн ойлголтын тодорхойлолтыг 3 хувилбараар боловсруулах
4. Уг хувилбаруудаа судлаачдын багаар хэлэлцүүлж, багийн бүх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хувилбарыг нь сонгох
5. Тодорхойлсон тулгуур ойлголтуудыгаа бусад хөндлөнгийн хүнээр хэлэлцүүлэн санал авах зэрэг болно.

2. Тодорхой зорилго болон зарчмуудыг тодорхойлох аргачлал

Нийгмийн нэгж системийн логикийн загвар болон хэвийн үйл ажиллагаатай системийн суурь хэв шинжүүдийг ашиглаж Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тодорхойлдог олон тулгуур зарчмуудаас ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд оролцогч талуудын харилцаанд хэлбэрэлтгүй мөрдөгдөх ёстой зарчмуудыг ялгав. Системийн загвараас гадна логик сэтгэлгээний дараах аргуудыг мөн ашигласан болно.

1. Аливаа юмс үзэгдлийн харилцан хамаарал, шүтэлцээг илт шинж тэмдэг болон далд мөн чанарыг нь хослуулан таньж мэддэг арга.
2. Хэрэв нөхцөл үнэн бол дүгнэлт үнэн байх логикийн дедукцийн арга
3. Уг шалтгаан болон нөхцөлөөс үр дагавар үүсдэгийг нотолдог аксиом

Мөн түүнчлэн нийгмийн нэгж системийн зорилгыг тодорхойлох, шинжлэхэд зориулан “ТУССолюшн” компаниас боловсруулан гаргасан зорилгыг шинжлэх аргачлалыг ашиглан

1. Нийгэмд өгөөжтэй олборлох үйлдвэрийг бий болгох нийгмийн хэрэгцээ зорилгыг тодорхойлсон.
2. Зорилгыг хэрэгжүүлэх оролцогчдыг тодорхойлж, оролцогчдын хүлээх үүрэг, үүргээс нь өөрт бий болох үр шим болон бусад оролцогчдод бий болгох өгөөжийг Үндсэн хуулийн гол заалтуудаас тодорхойлон гаргасан.

СУДАЛГААНЫ ҮЕ ШАТНЫ АЖЛУУДЫН ҮР ДҮН

1. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд холбогдох тулгуур ойлголтууд, жишиг загварыг тодорхойлох

Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааг зохицуулах зориулалттай хууль эрх зүйн баримт бичгүүдэд түгээмэл хэрэглэгддэг боловч тухайн үйл ажиллагаанд оролцогч талууд өөр өөрийнхөө үзэмжээр эсвэл олон янзын утгаар тайлбарладаг ойлголтууд олон байдгийн улмаас аливаа хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь үзэмжээс их хамааралтай, маргаан их дагуулдаг.

Нөгөө талаас эдгээр ойлголтуудыг нэгдмэл нэг утгатай болгох ажлууд хийгдээгүй байгаагаас дээрхи эрх зүйн баримт бичгүүдээр тогтоосон дүрэм журмуудад шинжилгээ, оношилгоо хийхэд ихээхэн хүндрэлтэй байна. Ийм учраас ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг зохицуулдаг эрхзүйн баримт бичгүүдэд түгээмэл хэрэглэгддэг 40 суурь ойлголтуудыг ялган улмаар тэдгээрийг нэгдмэл утгаар ойлгож хэрэглэж болохуйцаар томъёолон тодорхойлов.

Энэхүү жагсаалтанд хамрагдсан ойлголт бүрийн зонхилох хэв шинжүүдийг СИ аргачлалыг ашиглан системийн суурь шаардлагад нийцүүлэн /хэмжих, шалгах боломжтой байх/ тодорхойлж, улмаар тухайн ойлголтын хэв шинжүүдийг энэхүү жагсаалтанд хамрагдсан бусад ойлголтуудын хэв шинжүүдтэй зөрчилдөхгүй байхаар уялдуулан цэгцлэв.

Доорх 43 тулгуур ойлголтыг УУХҮЯ, ҮГА, АМГТГ-т тус тус санал авахаар илгээсэн. Тэдгээрээс ирүүлсэн /АМГТГ/ санал бүрийг хэлэлцэж холбогдох өөрчлөлтүүдийг тусгасан болно.

1. **Ашиг-** Зорилгыг хэрэгжүүлэхэд өөрийн санхүүгийн нөөцийг оруулах үүрэг хүлээсэн оролцогчийн тухайн зорилгыг хэрэгжүүлснээр хүртэх санхүүгийн үр шим;
2. **Ашигтай-** Зорилгыг хэрэгжүүлэхэд тулгардаг саад, бэрхшээлийг даван туулахад шаардлагатай зүйлийн харьцангуй давуу тал үүсгэдэг хэв шинж;
3. **Ашиглах-** Тодорхой зорилгыг хэрэгжүүлэхэд тулгардаг саад, бэрхшээлийг даван туулахад шаардлагатай зүйлийн харьцангуй давуу талыг үүсгэдэг хэв шинжийг хэрэглэх үйл ажиллагаа;
4. **Ашиглуулах** -Тодорхой зорилгыг хэрэгжүүлэхэд тулгардаг саад, бэрхшээлийг даван туулахад шаардлагатай зүйлийн харьцангуй давуу талыг үүсгэдэг хэв шинжийг хэрэглэх үйл ажиллагаа;
5. **Ашигт малтмал-** Газрын гадаргуу, түүний хэвлийд байгалийн тодорхой үзэгдэл өөрчлөлтийн үр дүнд хуримтлагдсан, санхүүгийн хувьд ашигтай аргаар газрын хэвлийгээс ялган авах боломжтой эрдэс бодис;
6. **Ашигт малтмалын нөөцийг хайх-** Газрын гадаргуу түүний хэвлийд явагдсан байгалийн тодорхой үзэгдэл, өөрчлөлтүүдийг болон түүний үр дүнд үүссэн эрдсийн хуримтлалын хэв шинжүүдийг танин мэдэхэд шаардлагатай чанартай өгөгдөл болон түүнд суурилсан иж бүрэн мэдлэгийг бий болгоход чиглэсэн судлах үйл ажиллагаа;
7. **Ашигт малтмалын орд-** Газрын гадаргуу, түүний хэвлийд явагдсан байгалийн тодорхой үзэгдэл, өөрчлөлтийн үр дүнд үүсч хуримтлагдсан, тодорхой хөрөнгө, хүчин чармайлт зарцуулж хайгуулын ажил хийж гүйцэтгэсний үр дүнд тархалтын зүй тогтол, хэмжээ, далайцыг нь танин мэдсэн, санхүүгийн хувьд ашигтай аргаар газрын хэвлийгээс ялган авах боломжтой эрдсийн хуримтлал;
8. **Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрөл-** Газрын гадаргуу, түүний хэвлийд явагдсан байгалийн тодорхой үзэгдэл, өөрчлөлтүүдийг болон түүний үр дүнд үүссэн эрдсийн хуримтлалын хэв шинжүүдийг танин мэдэхэд шаардлагатай чанартай өгөгдөл болон түүнд суурилсан иж бүрэн мэдлэгийг бий болгоход чиглэсэн судлах цогц үйл ажиллагааг эрхлэхэд дагаж мөрдөх нөхцөл болзлын тохиролцоо;
9. **Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрөл олгох-** Газрын гадаргуу түүний хэвлийд явагдсан байгалийн тодорхой үзэгдэл, өөрчлөлтүүдийг болон түүний үр дүнд үүссэн эрдсийн хуримтлалын хэв шинжүүдийг танин мэдэхэд шаардлагатай чанартай өгөгдөл болон түүнд суурилсан иж бүрэн мэдлэгийг бий болгоход чиглэсэн судлах цогц үйл ажиллагааг эрхлэхэд дагаж мөрдөх нөхцөл болзлын тохиролцоог гэрчилж илэрхийлэх;
10. **Баталгаа-** Илт эсвэл баримтаар нотлогддог үр дүнг заавал үүсгэдэг нөхцөл;
11. **Баялаг-** Хүний ямар нэг хэрэгцээг хангахад давуу тал үүсгэдэг хэв шинжтэй боловч гарал үүсэл, хуримтлалын хэмжээ, цар хүрээг нь бүрэн таньж мэдээгүй нөөц;

12. **Байгалийн баялаг**- Чулуун мандал, усан мандал, шим мандал, агаар мандлын харилцан шүтэлцээг орчинд үүсч хуримтлагдсан, хүний хэрэгцээг хангахад давуутай байдлыг үүсгэдэг хэв шинжтэй, гарал үүсэл, хуримтлалын хэмжээ, цар хүрээг нь бүрэн таньж мэдээгүй нөөц;
13. **Болзол**- Зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зайлшгүй бүрдүүлэх шаардлагатай, нийтээр хүлээн зөвшөөрсөн, урьдчилан тодорхойлсон нөхцөл;
14. **Бодлого**- Зорилгыг хэрэгжүүлэх арга замын суурь хэв шинжүүдийг тодорхойлж хооронд нь уялдуулсан ерөнхий санаа;
15. **Гэрчилгээ**-Ямар нэг үйл явдал, үзэгдэл тохиосныг нотлох баримт бичиг;
16. **Журам**- Зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч талуудын гүйцэтгэх үүргүүд болон тэдгээр үүргүүдийн хоорондын уялдааг тогтоож дагаж мөрдүүлэхээр баримтжуулсан хэм хэмжээ;
17. **Зарчим**- Хүрээлэн байгаа орчины өөрчлөлтөөс үл хамааран заавал тогтвортой дагаж мөрдөх хэм хэмжээ;
18. **Зохицуулалт**-Тодорхой үйлдлүүдийг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнд захируулах үйл ажиллагаа;
19. **Зөвшөөрөл**- Тодорхой үйлдлийг гүйцэтгэх, үйл ажиллагаа эрхлэхэд заавал бүрдүүлэх естой, нэгдмэл ойлголтод хүрсэн нөхцөл, болзлын тохиролцоо
20. **Зөвшөөрөл олгох**- Тодорхой нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрхлэхэд дагаж мөрдөх нөхцөл болзлыг тохиролцсоны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах эрх эдэлж, үүрэг хүлээх болсныг илэрхийлэх ;
21. **Малтмал**- Газрын гадаргуу, түүний хэвлийд байгалийн тодорхой үзэгдэл, өөрчлөлтийн үр дүнд хуримтлагдсан тодорхой аргаар газрын хэвлийгээс ялган авах боломжтой эрдэс бодис;
22. **Нөхцөл**- Тодорхой юмс үзэгдэл үүсэж бий болоход зайлшгүй шаардлагатай орчин, нөөцийн хангалттай байх төлөв байдал;
23. **Нийгэм**- Хүмүүс суурь хэрэгцээгээ харилцан, хүртээмжтэй, тогтвортой, хангахад шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх зориулалттай, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нутаг дэвсгэрт тогтвортой оршдог, зорилгоо хэрэгжүүлэхэд шаардлагатай бие даасан эрх зүйн болон бусад суурь бүтэцтэй, иргэд нь харилцан уялдаатай нийтлэг үүрэг хүлээдэг тогтолцоо;
24. **Нөөц**- Тодорхой зорилгыг хэрэгжүүлэх хэв шинжүүдийг тогтвортой бүрдүүлэхэд шаардлагатай үүсгэл;
25. **Нийгэмд өгөөжтэй олборлох үйлдвэр** -Нийгмийн оролцогч талуудад өгөөжтэй, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд хариуцлага хүлээдэг, ашигт малтмал олборлодог үйлдвэр;
26. **Ашигт малтмалын орд** -Тодорхой нөөц зарцуулж хайгуулын ажил хийж гүйцэтгэсний үр дүнд тархалтын зүй тогтол, хэмжээ, цар хүрээ нь танин мэдсэн эрдсийн хуримтлал;
27. **Олборлох** -Газрын хэвлийд оршин буй ашигт малтмалын ордоос үнэ цэнэ бүрдүүлдэг хэсгийг ангилах, ялгах, салгах, худалдах үйл ажиллагаа;
28. **Өгөөж** -Тодорхой зорилгыг хэрэгжүүлсний үр дүнд уг зорилгыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудад үүсэж бий болсон харьцангуй давуу тал;
29. **Стратеги** -Зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг саад, бэрхшээлүүдийг давах арга зам;
30. **Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд** -Нөөцийг нь олборлох үйл ажиллагаа явуулснаар Үндсэн хуулийн 16 зүйлд заасан иргэний эрх, эрх чөлөөг эдлүүлэхэд өгөөжтэй эерэг нөлөө үзүүлдэг ашигт малтмалын орд;
31. **Сонгон шалгаруулалт** -Тодорхой зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрхлэх хувь хүн,

- хуулийн этгээдүүдийг тогтоосон шалгуураар үнэлж шилэх арга;
32. **Төр**- Монгол Улсын нийт иргэдийн өмнө Үндсэн Хуулийн 19.1-д заасан үүргийг сонгох, сонгогдох эрхийнхээ хүрээнд хүлээсэн бүлэг иргэдийн харилцан уялдаатай үйл ажиллагааны тогтолцоо;
 33. **Тулгуур**-Аливаа тогтолцоог бүрдүүлэхэд ордог, тухайн тогтолцоо оршин тогтнох хугацаанд хэв шинж нь тогтвортой хадгалагддаг бүрэлдэхүүн хэсэг;
 34. **Уурхай** -Газрын хэвлийд оршин буй ашигт малтмалын ордоос ашигт малтмалыг ялгах, салгах, ангилах, худалдах үйл ажиллагааг эрхэлдэг үйлдвэр;
 35. **Үйлдвэр** -Тодорхой үнэ цэнийг бүтээх зорилгоор эмх цэгцтэй, харилцан уялдаатай тогтвортой үйл ажиллагааг нөөц зарцуулж эрхэлдэг байгууллага;
 36. **Үр шим** -Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэхэд үүрэг гүйцэтгэснээр оролцогч тал өөртөө бий болгож буй харьцангуй давуу тал;
 37. **Хайх** -Суурь өгөгдөл болон түүнд суурилсан иж бүрэн мэдлэгийг бий болгох зорилготой судлах үйл ажиллагаа;
 38. **Хайгуул** -Юмс үзэгдлийн хэв шинж, зүй тогтлын мөн чанарыг танин мэдэх зорилгоор иж бүрэн өгөгдлийг бий болгох, цуглуулах, боловсруулах, дүгнэх үйл ажиллагаа;
 39. **Хууль** -Байгалийн эсвэл нийгмийн зүй тогтлын дагуу явагддаг харилцан үйлчлэлийн тогтолцоо;
 40. **Шаардлага**-Зорилгын тодорхой хэв шинжийг байгаль болон нийгмийн жам ёсны шүтэлцээнд нийцүүлэн бүрдүүлбэл зохих хэм хэмжээ;
 41. **Шалгуур** -Юмс үзэгдлүүдийг ангилах, хооронд нь харьцуулах зорилгоор сонгосон зонхилох хэв шинж;
 42. **Эрдэс** -Байгалийн үзэгдэл, өөрчлөлтийн үр дүнд үүсэж бий болсон, тодорхой хэрэгцээнд ашиглаж болохуйц хэв шинжийг агуулсан, байгальд дангаараа болон нийлмэл байдлаараа байгаа бодис;
 43. **Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн бүртгэл** - Ашигт малтмалын нөөцийг хайх, ашиглах эрх эзэмшигчийн болон эрхээр олгогдсон талбайн өөрчлөлт, эрхийн дагуу үйл ажиллагаа явуулах болон дуусгавар болохтой холбоотой, зайлшгүй бүртгэх шаардлагатай гэж хуулиар тогтоосон өөрчлөлтүүдийг албан есөөр бүртгэдэг бүртгэл
Эдгээр ойлголтуудыг тус бүрд нь тодорхойлсоны дараа ойлголт бүрийг бүрдүүлж байгаа хэв шинжүүдийг бусад ойлголтуудыг бүрдүүлж байгаа хэв шинжүүдтэй логикийн хувьд зөрчилдөөнгүй байхуйцаар уялдуулсан болно.

2. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааны онцлог хэв шинжүүд

Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагаа нь бусад үйл ажиллагаанаас ихээхэн ялгаатай бөгөөд ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг зохицуулахдаа эдгээр онцлогуудаас үүдэн гарах үр дагаврыг заавал харгалзан үзэх шаардлагатай. Онцлог хэв шинжүүдийг харгалзан үзээгүй аливаа зохицуулалт нь хэрэгжилтийнхээ үе шатанд олон олон асуудал, хүндрэлүүдтэй тулгардаг. Судалгааны баг аль болох хөндлөнгийн олон эх үүсвэрүүдээс мэдээлэл цуглуулж харьцуулах аргаар ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааны онцлог хэв шинжүүдийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

1. Хайгуулын ажлын үр дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд явагдсан байгалийн тодорхой

үзэгдэл, өөрчлөлтүүдийг болон түүний үр дүнд үүссэн эрдсийн хуримтлалын хэв шинжүүдийг танин мэдэхэд шаардлагатай чанартай өгөгдөл болон түүнд суурилсан иж бүрэн мэдлэг бий болдог. Өөрөөр хэлбэл хайгуулын үйл ажиллагаа нь мэдлэг үүсгэхэд чиглэсэн судалгаа, танин мэдэхүйн үйл ажиллагаа юм.

2. Хайгуулын ажил нь цаг хугацаа, хөрөнгө мөнгө, мэдлэг, хөдөлмөр /нөөцүүд/ их шаарддаг боловч эдийн засгийн хувьд үр ашигтай ашигт малтмалын орд газрыг олж тогтоох магадлал бага /1:1000 /-тай, өндөр эрсдэлтэй байдаг.
3. Санхүүгийн үлэмж их нөөц шаарддаг /MinEx consulting судалгаагаар 1980-2010 онуудад Австрали улсад хувийн хэвшлийн байгууллагууд эдийн засгийн хувьд үр ашигтай нэг ордын хайгуулын ажлыг хийж гүйцэтгэхэд дундажаар 1.5 тэрбум доллар зарцуулсан ба нөөц нь буцаан нөхөгдөх магадлал бага /1:1000/ байдаг.
4. Ашигт малтмалын нөөцийг бүрэн судалж тогтооход ихээхэн цаг хугацаа /5-18 жил/ шаарддаг.
5. Хайгуулын үе шатанд ямар нэг тогтмол орлого байдаггүй учраас орон нутгийн иргэдэд болон нийгэм, эдийн засагт бий болгох шууд өгөөж нь хязгаарлагдмал.
6. Хайгуулын үйл ажиллагааг амжилтад хүргэхэд төрөлжсөн нарийн мэргэжлийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар шаарддаг.

Судалгаа, шинжилгээний Fraser institute, Европын Сэргээн Босголтын Банк болон гадаад улс орнуудад хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг зарим уул уурхайн компаниудын хийсэн судалгааны үр дүнгээр тогтоогдсон, хөрөнгө оруулагч компаниудын зүгээс тухайн орнуудын хөрөнгө оруулалтын орчинд тавьдаг нөхцөл болзлуудыг ангилан дээрх онцлогуудтай харьцуулж үзлээ. Энэхүү харьцуулалтын үр дүнд хөрөнгө оруулагчдын зүгээс тухайн улс орны хөрөнгө оруулалтын орчны хэв шинжүүдэд тавьдаг нөхцөл болзлууд нь ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллаганы онцлогоос үүдэн гардаг нь тогтоогдов. (Хавсралт 1. Хөрөнгө оруулагчийн зүгээс тавих шаардлага, нөхцөл, болзол)

3. Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгоход ашигладаг шалгуур, нөхцөл, болзлуудын тогтолцооны хэлбэр, олон улсын практик

Аливаа зөвшөөрөл нь зорилгыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд хоорондоо харилцан зөвшөөрсөн тохиролцоо мөн гэдэг утгыг агуулдаг. Тохиролцоо нь тодорхой шалгуур, нөхцөл, болзол гэдэг ойлголтуудаар дамжин хэрэгждэг бөгөөд тохиролцоог хийхэд ашиглаж байгаа эдгээр ойлголтуудын хэв шинжүүдээс тухайн тохиролцооны чанар шууд хамаардаг. Мөн эдгээр шалгуур, нөхцөл, болзлуудын хэмжээ, хэлбэрүүдийг оновчтой тогтоох, хооронд нь уялдуулах замаар тохиролцооны хэв шинжүүдийг тодорхой зорилго руу чиглүүлэх, залах боломжтой.

Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаа нь олон оролцогч талтай, олон хүчин зүйлүүдээс хамааралтай үйл ажиллагаа мөн боловч ийм үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо ашигладаг шалгуур, нөхцөл, болзлуудыг оновчтой тогтоосноор ирээдүйд нийгэмд өгөөжтэй олборлох үйлдвэрлэлийг шинээр бий болгох, нэмэгдүүлэх чадвартай бат бэх суурийг тавих юм. Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгоход дараах шалгуур, нөхцөл, болзлуудыг нийтлэг ашигладаг. Үүнд:

- Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагаа эрхлэх эрхийг үүсгэх, баталгаажуулахад баримтлах шалгуур
- Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг эхлүүлэхийн тулд зайлшгүй бүрдүүлсэн байвал зохих нөхцөл

- Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг ирээдүйд эрхлэхдээ заавал дагаж мөрдөх хэм хэмжээнүүдээс бүрдсэн болзлууд

Эдгээр гурван ойлголтууд нь тус тусдаа бие даасан үйлдлүүдийг гүйцэтгэхэд хэрэглэгддэг ойлголтууд бөгөөд хайгуулын тусгай зөвшөөрлийг хүссэн оролцогч тал болон тусгай зөвшөөрлийг олгодог оролцогч талын хооронд харилцан зөвшөөрсөн нэгдмэл ойлголт бий болсон үед оролцогч талууд харилцан тохиролцоонд хүрдэг. Олон улсад шалгуур, нөхцөл, болзлуудыг янз бүрийн хэлбэр, хослолоор хэрэглэдэг боловч тэдгээрийг ерөнхийдөө дараах ангилалд бүлэглэж болно. Үүнд:

1. Тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох
2. Тусгай зөвшөөрлийг мэргэжлийн болон бусад чадамжийн шалгуураар сонгон шалгаруулж олгох
3. Тусгай зөвшөөрлийг дуудлагаар үнэ хаялцуулах замаар олгох

Нийгмийн нэгж системийн онолын үүднээс авч үзвэл тухайн түвшиний систем дээр ямар нэг шийдвэрийг гарахад ашигладаг шалгуур, нөхцөл, болзлуудын хэв шинжүүд нь уг системийг агуулж буй том системийн хэрэгцээ шаардлага, зорилгод нийцсэн байх ёстой гэж үздэг. Жишээлбэл, байшингийн ханыг барих гэж байгаа бол уг хананы хэмжээ, даацыг барих гэж байгаа байшингийнхаа хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх ёстой гэсэн үг. Энэ мөрдлөгөөнөөс ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгохдоо баримталдаг шалгуур, нөхцөл, болзлууд нь аль ч орны хувьд тухайн нийгмийн нийтлэг зорилго, хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх ёстой хэмээн дүгнэж болно.

Тусгай зөвшөөрлийг дуудлагаар үнэ хаялцуулж олгодог арга нь урьд өмнө ямар нэг байдлаар эрэл, хайгуулын ажил хийсний үр дүнд ашигт малтмал байгаа нь тогтоогдсон эсвэл байх магадлалтай тохиолдолд илүү тохиромжтой бөгөөд ОХУ зэрэг орнуудад хэрэглэгддэг. Хайгуулын ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээг бууруулдаг, дуудлага худалдаагаар авсан талбайд ашигт малтмалын нөөцийг олж нээн илрүүлэх баталгаа байхгүй гэх мэт шүүмжлэлүүд гардаг.

Тусгай зөвшөөрлийг мэргэжлийн болон бусад чадамжийн шалгууруудыг ашиглан олгох аргыг олон улс орнууд нэлээд өргөн ашигладаг бөгөөд түүний дотор Австрали, Канад зэрэг улсуудын зарим мужууд багтдаг. Сонгон шалгаруулалтын энэ арга нь шалгаруулах багийн гишүүдийн үзэмжээс их хамааралтай, авилгал үүсгэх магадлалтай, хөрөнгө, мэргэжлээр нь ялгаварлан гадуурхдаг гэх мэт шүүмжлэлүүдийг дагуулдаг.

Тусгай зөвшөөрлийг ашигт малтмалын нөөцийг хайх хүсэлт, өргөдлийг үндэслэн олгодог аргыг сүүлийн жилүүдэд өргөн хэрэглэх хандлагатай болсон бөгөөд тухайлбал, Австрали улсын Баруун Австрали мужид энэ аргыг хэрэглэснээр хөрөнгө оруулалтыг амжилттай татаж байна. Энэ арга нь тухайн улсын иргэдэд сайн ойлгогддоггүй, газрын тухай асуудалтай холилдож үл итгэлцэл үүсгэдэг, системийн болон технологийн нарийн шийдлүүдийг шаарддаг гэсэн шүүмжлэлд байнга өртдөг.

1994, 1997, 2006 онуудын Ашигт малтмалын тухай хуулиудыг боловсруулсан, хэлэлцүүлсэн, хэрэгжүүлсэн туршлагаас үзвэл хуулийн төслийг боловсруулсан багийн гишүүд эдгээр гурван ойлголтуудын хоорондын ялгаа, уг ойлголтуудыг хуулийн заалтад хэрэглэж байгаа учир шалтгааны талаар маш ерөнхий, зарим тохиолдолд хооронд нь хольж хутгасан ойлголтуудтай байсан. Одоо ч тийм хандлага ажиглагдсаар байна.

Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагаа эрхлэх эрх нь Монгол улсын Үндсэн хуулийн 16, 14.2 зүйлүүдээр баталгаажсан эрхэд хамаарна гэж логикийн хувьд дүгнэж болох бөгөөд бөгөөд энэхүү эрхийг эдлэхэд шаардлагатай баталгаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх байлгах үүргийг төр Монгол улсын Үндсэн хуулийн 19.1-д заасны дагуу хүлээдэг.


4. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааны зорилгыг Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх хэрэгцээ, шаардлага

Нийгмийн харилцаанд оролцогч бүх талуудын үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн хүрээнд явагддаг байх зарчим нь нийгэм тогтвортой оршин тогтнох суурь нөхцөл болдог. Үүнтэй нэгэн адил үндэслэлээр ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаа нь Монгол улсын Үндсэн хуулиар тогтоосон үзэл баримтлалын хүрээнд явагдах учиртай. 1990 оноос хойш Монгол улсын уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах, идэвхжүүлэхэд чиглэсэн хуулиуд, хөтөлбөрүүдийг Монгол улсын Засгийн газраас удаа дараа хэрэгжүүлсэн. Эдгээрийн арга хэмжээнүүд нь алдаа, оноо аль алиныг нь бий болгосон түүхтэй боловч тийм арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр нийгэмд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, тогтвортой, хүртээмжтэй үр дүнг бий болгож хараахан чадаагүй байна. Ийм дүр төрх зөвхөн ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох салбарт биш, нийгэм эдийн засгийн бүхий л салбарт ажиглагдаж байна. Энэ асуудлыг шийдвэрлэх нэгэн гарц нь Монгол улсын улс төр, нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт явагдаж байгаа үйл ажиллагааг Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн зохицуулдаг болох арга юм. 1994, 1997, 2006 оны Ашигт малтмалын тухайн хуулиудад нийтлэг байсан нэгэн доголдол бол эдгээр хуулиудыг анх боловсруулах, хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх үе шатуудад эдгээр хуулиудын зорилго, үзэл баримтлалуудыг Үндсэн хуулийн үзэл баримтлалтай нийцүүлэх ажлуудыг орхигдуулсан эсвэл дутуу хийсэн явдал юм. Монголын нийгмийн гишүүдийн сэтгэлгээ Үндсэн хуулинд захирагдахад бэлэн биш байсан, янз үзэл баримтлалуудыг хооронд нь харьцуулдаг, шинжилдэг арга, аргачлалыг боловсруулан гаргаагүй байсан зэрэг хүчин зүйлүүд ч бас нөлөөлсөн. Жишээлбэл, 1994, 1997 оны хуулиудыг боловсруулсан ажлын хэсэг нь эдгээр хуулиудын төслийг “гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар улсаа хөгжүүлэх” гэсэн цорын ганц зорилгод нийцүүлэн боловсруулсан юм. Гэтэл түүний цаана “ямар зорилгоор гадаадын хөрөнгө оруулалтыг татах бэ?”, “яагаад бид улсаа хөгжүүлэх хэрэгтэй вэ?”, “юуг хөгжил гэж хэлэх вэ?” гэдэг асуултууд тодорхой, барьцтай хариултгүй үлдэж улмаар нийгэмд уул уурхайн үйлдвэрлэл, гадаадын хөрөнгө оруулалтын талаар нэгдсэн ойлголт бүрэлдээгүй, нэгдсэн ойлголтод суурилсан бодлого байхгүй өнөөг хүрчээ. Иймд цаашид уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн аливаа арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ тухайн санал болгож буй арга хэмжээгээ Үндсэн хуулийн үзэл баримтлалтай нийцүүлдэг шийдлийг хөгжүүлж нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна. Хууль, хуулийн төслийг боловсруулах үйл ажиллагааг зохицуулдаг хууль, журмуудыг батлан гаргасан боловч эдгээр хууль, журамд “санал болгож буй хууль, журмыг Үндсэн хуулинд нийцүүлсэн байх” гэдэг ерөнхий шаардлагуудыг тусгасан байдаг боловч тухайн санал болгож буй хууль, журмыг Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулах арга, аргачлал нь тодорхойгүй байна. Ийм арга аргачлалыг нэн даруй боловсруулан гаргахгүй бол Монголын нийгмийг бүхэлд нь зохицуулж байгаа 600 гаруй хуулиуд болон шинээр батлан гаргах хуулиуд нь хоорондоо зөрчилтэй, давхцалтай, нийгмийн харилцааг зохицуулах чадваргүй улмаар нийгэмд тогтворгүй байдал үүсгэх болжээ.

2018 онд Залуу судлаачдыг дэмжих сангаас Үндсэн хуулинд хийсэн судалгаагаар Үндсэн хуулийн үзэл баримтлал нь Үндсэн хуулиар тодорхойлсон нэгдмэл зорилго болон уг хуулийн тодорхой зүйл, заалтуудаар тогтоосон, хоорондоо харилцан шүтэлцээтэй хэв хэмжээнүүд буюу зарчмуудаас бүрддэг болохыг тогтоосон.

Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагаанд огт хамааралгүй Үндсэн хуулийн нэг ч зүйл, заалт байхгүй, тэдгээр зарчмуудыг нэг бүрчлэн тодорхойлж цэгцлэх шаардлагатай боловч нөөцийн хязгаарлагдмал байдлын улмаас энэ удаагийн судалгаанд ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд шууд хамааралтай, Үндсэн хуулиар тогтоосон зарчмуудыг ялган тодорхойлов.

Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг цаашид дэмжих, идэвхжүүлэх аливаа хүчин чармайлт амжилттай болох эсэх нь ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааны зорилгыг манай нийгмийн албан ёсны нэгдмэл зорилго буюу Үндсэн хуулиар тодорхойлсон зорилготой хир оновчтой уялдуулж чадахаас ихээхэн хамаарна гэж үзэж байна. Иймд энэ судалгааны ажлын хүрээнд ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэхэд чиглэсэн төр, засгийн бодлогын зорилгыг Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн системийн инженерчлэлийн аргаар тодорхойлов.



Зураг 5. Нэгдмэл зорилгын томъёоллын ойлголтын хавтгай

Энэхүү томъёолол нь нийгмийн гишүүдэд хүртээмжтэй давуу талыг бий болгох зорилгыг илэрхийлж байгаагаараа эдийн засгийн өсөлтийг зорилго болгодог уламжлалт томъёоллоос ялгаатай. Өөрөөр хэлбэл эдийн засгийн өсөлт нь иргэдийн амьжиргаанд эерэг өөрчлөлт авчирч байх шаардлагыг агуулж байгаа юм.

5. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааг зохицуулж буй хууль, эрх зүйн баримт бичиг стандартуудын нэгтгэл

Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг 160 гаруй хууль эрхийн актуудаар зохицуулдаг бөгөөд эдгээр эрх зүйн актуудын заалтууд нь дараах шаардлагуудыг хангаж байвал ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг нийгмийн нийтлэг эрх ашигт нийцүүлэх боломж бүрддэг. Үүнд:

- Эдгээр эрх зүйн актуудын үзэл баримтлалууд нь бүгд Монгол улсын Үндсэн хуулийн Үзэл баримтлалд нийцсэн байх
- Эрх зүйн актуудын заалтууд нь хоорондоо логикийн зөрчилгүй байх
- Эрх зүйн актуудын заалтууд нь нэг нэгэнтэйгээ давхцаагүй байх

№	Эрх зүйн баримт бичиг	Нийт тоо	Үгийн тоо	Бүлгийн тоо	Зүйлийн тоо	Заалтын тоо	Өгүүлбэрийн тоо
---	-----------------------	----------	-----------	-------------	-------------	-------------	-----------------

1	Хууль	18	119527	115	658	3783	4338
2	Улсын Их Хурлын тогтоол	3	4451	0	17	202	203
3	Засгийн газрын тогтоол	4	14388	54	0	490	608
4	Салбарын сайдын тушаал	3	4552	26	18	231	159v
5	Стандартууд	140	-	-	-	-	-
Нийт		168	142918	195	693	4706	5308

Хүснэгт 2. Эрх зүйн баримт бичгийн нэгтгэл

6. Үндсэн хуулиар тодорхойлсон нийгмийн тогтолцооны нийтлэг тулгуур хэм хэмжээ ба ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд оролцогч талуудын хоорондын харилцааны хэв шинжүүдийн нийцлийн шинжилгээ.

Аливаа нэгдмэл зорилготой байхын давуу тал нь уг зорилгыг хэрэгжүүлэхэд оролцогч тал нь бусдад үнэ цэнийг бүтээх замаар өөрийн суурь хэрэгцээгээ хангадагт оршино. Түүгээр барахгүй ийм үнэ цэнэ бүтээдэг, тус тусдаа гүйцэтгэдэг үйл ажиллагаанууд нь үнэ цэнийг харилцан бүтээдэг бүтэн хэлхээг үүсгэж бусад оролцогч талуудад харьцангуй давуу байдлыг буюу өгөөжийг бий болгоно гэж нийгмийн нэгж системийн онол үздэг. Монгол улсын Үндсэн хуулиар тодорхойлсон нийгэм нь системийнхээ хувьд нийгмийн харилцаанд оролцогч иргэн бүрийн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх зорилготой нийгэм мөн бөгөөд иргэд Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ эдлэхдээ бусад иргэдийн эрх, ашиг сонирхолыг хүндэтгэн үзэх, хамгаалах үүрэгтэй байхаар Үндсэн хуулийн 17-р зүйлд тусгасан нь дээр дурьдсан системийн онолтой нийцэж байгаа юм. Судалгааны баг системийн загварыг ашиглан ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүргүүдийг Үндсэн хуулиар тодорхойлсон эрх, үүргүүдийн харилцан шүтэлцээний загварт хөрвүүлэх замаар ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд оролцогч бүрээр хүртэх үр шим болон хүлээх үүргүүдийн харилцан шүтэлцээний матрицийг гарав. Энэхүү матрицийг боловсруулан гаргаснаар нийгэмд өгөөжтэй олборлох үйлдвэрийн суурь хэв шинжүүдийг тодорхойлох боломж бүрдэж байгаа юм. (Хавсралт 2. Оролцогч талуудын харилцан шүтэлцээний матриц)

7. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд оролцогч талуудын хоорондын харилцаанд хэлбэрэлтгүй мөрдвөл зохих Үндсэн хуулийн тулгуур зарчмууд

Аливаа нийгмийн нэгж систем нь үйл ажиллагаандаа хэрэглэх арга замуудыг нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудаар шалгаж сонгохгүй бол зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь зорьсон үр дүнгээс өөр үр дүнг бий болгодог. Энгийн хэллэгээр бол нэгдмэл зорилгыг зөвхөн нийтээрээ хүлээн зөвшөөрсөн арга хэрэгслээр хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн үг. Монгол улсын Үндсэн хууль нь нийгмийн харилцаанд заавал мөрдвөл зохих нийтлэг тулгуур зарчмуудыг тодорхойлж түүн дээрээ үндэслэсэн эрх, үүргүүдээр нэгдмэл зорилгоо хэрэгжүүлдэг байхаар тогтоосон байдаг. Эдгээр нийтлэг зарчмуудаас Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд оролцогч талуудын харилцаанд хэлбэрэлтгүй мөрдөгдөх ёстой 51 тулгуур зарчмуудыг / цаашид ҮЗАМ-51 гэж нэрлэгдэх/ ялгаж тогтоов. Үндсэн хуулиар тодорхойлсон эдгээр зарчмуудад нийгмийн харилцаанд оролцогч тал

бүрийн үйл ажиллагааг бүрдүүлдэг үйлдэл/үүрэг бүрийг нийцүүлж байж Монголын нийгэм Үндсэн хуулийн үзэл баримтлалыг баттай хэрэгжүүлж иргэн бүр эрх, эрх чөлөөгөө баталгаатай эдлэх нөхцөл бүрдэх юм. Иймд эдгээр зарчмуудад нийгмийн харилцаанд оролцогч талуудад тодорхой үүрэг хүлээлгэдэг, үйл ажиллагааг нь зохицуулдаг хууль эрх зүйн бүх актуудаар тогтоох үйлдэл/үүргүүдийг нийцүүлсэн байх ёстой.

№	Үндсэн хуулийн тулгуур зарчмууд	Үндсэн хуулийн Зүйл, заалт	№	Үндсэн нэгж зарчим
1	Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.	5.2	1	1. Төр нь нийтийн өмчийг хүлээн зөвшөөрч эрхийг нь хуулиар хамгаалах ёстой.
			2	2. Төр нь хувийн өмчийг хүлээн зөвшөөрч эрхийг нь хуулиар хамгаалах ёстой.
2	Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.	5.3	3	Төр нь өмчлөгчийн эрхийг зөвхөн хуулиар хязгаарлаж болдог байх ёстой.
3	Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.	5.4	4	Төр нь зөвхөн "үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилго" -д нийцүүлэн эдийн засгийн зохицуулалтыг хийх ёстой.
4	Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.	6.2	5	Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмчлөлд байх ёстой.
5	Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.	6.2	6	1. Төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлах ёстой.
			7	2. Төр нь байгалийн баялгийн үр өгөөжийг сангаар дамжуулан иргэдэд тэгш, шударга хүртээх ёстой.
6	Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.	6.2	8	Байгалийн баялгийг ашиглах үйл ажиллагаа эрхлэгч нь байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдээллэх ёстой.

7	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.	6.2	9	Нийгэмд өгөөжтэй олборлох үйлдвэрийг байгуулах зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг саад, бэрхшээлүүдийг даван туулах, нийгэмд үзүүлэх өгөөжийг нэмэгдүүлэх стратегийг төр, иргэн, үйлдвэрлэл эрхлэгчид хамтран тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг хуулиар тогтоох ёстой.
8	Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.	6.5	10	Төр нь газрыг төлбөртэй, хугацаатай, болзолтой ашиглуулах ёстой.
9	Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн.	7.2	11	Иргэн, хуулийн этгээд өөрийн нөөцөө зарцуулан бий болгосон өгөгдөл түүнд суурилсан мэдлэг нь тухайн иргэн, хуулийн этгээдийн өмч байх ёстой.
10	Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.	11.1	12	Төр нь эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах үүргээ биелүүлснээр Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан үндсэн эрх, эрх чөлөөг хангах баталгаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.
11	Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.	14.1	13	Төр нь хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх баталгаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.
12	Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.	14.2	14	Иргэн, аж ахуйн нэгж аливаа аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төрөөс олгохдоо үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.
13	Амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;	16.1.1	15	Төр нь иргэн бүр амьд явах эрхээ эдлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.
14	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;	16.1.2	16	Төр нь иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ эдлэх баталгаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.

15	Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;	16.1.3	17	Төр нь иргэн бүр оюуны болон биеийн хөдөлмөрлөх эрхлэх замаар хөрөнгө олж авах, эзэмших, өмчлөх эрхээ эдлэх баталгаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.
16	Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;	16.1.4	18	Төр нь иргэн бүр өөрийнхөө давуу талд тулгуурлан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхээ эдлэх баталгаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.
17	Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;	16.1.5	19	Төр нь иргэн бүр нийгмийн хамгаалалтанд байх эрхээ эдлэх баталгаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.
18	Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно;	16.1.6	20	Төр нь иргэний эрүүл мэндээ хамгаалах, эмнэлэгийн тусламж авах эрхээ эдлэх баталгаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.
19	Сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;	16.1.7	21	Төр нь иргэд сурч боловсрох эрхээ эдлэхэд шаардлагатай, хүртээмжтэй, сонголттой орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.
20	Соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;	16.1.8	22	Төр нь иргэн хөдөлмөрлөх замаар бүтээсэн оюуны бүтээлийнхээ үр шимийг нь хүртэх эрхээ эдлэх баталгаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.
21	Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;	16.1.9	23	Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно. Сонгогдсон төлөөлөгч нь иргэний эрхийг эдлүүлэх талаар ажиллах ёстой.

22	<p>Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;</p>	16.1.10	24	<p>Төр нь иргэний ашиг сонирхол, үзэл бодлоороо сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх баталгаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.</p>
23	<p>Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;</p>	16.1.11	25	<p>Төр нь нийгмийн бүхий л харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй оролцох орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.</p>
24	<p>Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;</p>	16.1.12	26	<p>1. Төр нь иргэний төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхээ эдлэх баталгаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.</p>
			27	<p>2. Иргэний гаргасан өргөдөл, гомдлыг төрийн байгууллага, албан тушаалтан шийдвэрлэх ёстой.</p>
25	<p>Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар</p>	16.1.13	28	<p>Төр нь иргэний эрх чөлөө, өмч хөрөнгө халдашгүй байх эрхээ эдлэх баталагаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.</p>

	хамгаална;			
26	Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;	16.1.14	29	Төр нь иргэн зөрчигдсөн эрх, эрх чөлөөгөө хамгаалуулах эрхээ эдлэх баталагаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.
			30	Шүүх иргэний зөрчигдсөн эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх ёстой.
27	Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;	16.1.15	31	Төр нь иргэн шашин шүтэх, эс шүтэх эрхээ эдлэх баталагаатай орчин нөхцлийг бүрдүүлэх ёстой.
28	Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;	16.1.16	32	Иргэний итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөгөө эдлэх баталагаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.

29	Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;	16.1.17	33	Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхээ эдлэх баталгаатай орчин нөхцөлийг төрөөс бүрдүүлэх ёстой.
30	Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.	16.1.18	34	Төр нь улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхээ эдлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой.
31	Иргэн Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;	17.1.1	35	Иргэн Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх ёстой.
32	Иргэн хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;	17.1.2	36	Иргэн нь бусад хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх ёстой.
33	Иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх;	17.1.3	37	Иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх ёстой.
34	Иргэн бүр хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.	17.2	38	Иргэн бүр хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах ёстой.
35	Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.	19.1	39	Төр хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх ёстой.
36	Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.	19.3	40	Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулахгүй байх ёстой.

37	Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.	19.1 нэмэлт	41	Улс төрийн нам нь Монгол улсын Үндсэн хуулийн 16 зүйл заалтанд заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн намынхаа бодлогыг боловсруулж, дэвшүүлж ажиллах ёстой.
38	Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална	20.1	42	УИХ Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хангах орчин нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай хууль тогтоомж баталж, түүний хүрээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудын хэрэгжилтэд хяналт тавих ёстой.
39	Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.	30.1	43	Монгол Улсын Ерөнхийлөгч бол Монголын ард түмний эв нэгдлийг хангах ёстой.
40	Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.	38.1	44	Төр Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг хуулийн хүрээнд иргэнийхээ өмнө хариуцах ёстой.
41	Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.	47.1	45	Иргэн, хуулийн этгээд хууль зөрчсөн эсэхийг зөвхөн шүүх тогтоох ёстой.
42	Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.	56.1	46	Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох ёстой.
43	Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.	62.1	47	Тухайн орон нутгийн хэмжээнд орон нутгийн иргэд Үндсэн хуулийн 16-р зүйлд заасан эрхийг эдлэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд хууль тогтоомжийн хүрээнд иргэдийг оролцуулж, зохион байгуулах ёстой.
44	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн болон нийтийн хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт	63.2	48	Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх бөгөөд түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөх ёстой.

	нийцсэн байх бөгөөд түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.			
45	Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.	64.1	49	Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага байх ёстой.
46	Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.	1.2	50	Төрийн бүх үйл ажиллагаа Үндсэн хуулийн 14, 16, 17, 30.1 дүгээр зүйлд захирагдсан байх ёстой.
47	Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.	14.1	51	Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх ёстой.

Хүснэгт 3. ҮЗАМ-51

Дээрх 51 зарчмуудын 9 зарчим нь иргэдийн үйл ажиллагаанд, 1 зарчим нь улс төрийн намуудын үйл ажиллагаанд, 41 зарчим нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөгдөх ёстой зарчмууд байна.

Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд оролцогч талуудын гүйцэтгэх үүргүүдийг тодорхойлдог хууль эрх зүйн актууд /хууль, дүрэм, журмууд/ -аар тогтоодог үүрэг/үйлдлийн заалт бүр нь дээрх ҮЗАМ-51 зарчмуудад бүрэн нийцэж байвал тухайн эрх зүйн акт нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд бүрэн нийцэж байна гэж дүгнэж болохоор байна. Энэ дүгнэлт нь системийн онол болон логикийн ухааны онол дээр суурилсан дүгнэлт юм.

8. Монгол Улсын Үндсэн хуулийн тулгуур зарчмуудын хоорондын учир шалтгааны шүтэлцээ

Монгол улсын Үндсэн хуулийн тулгуур зарчмууд буюу заалтууд нь хоорондоо харилцан хамаарч, харилцан шүтэлцэж байж нийгмийн бүхий л харилцааны үндэс суурийг бүрдүүлдэг бөгөөд тийм учир шалтгаанаар харилцан шүтэлцсэн хэм хэмжээнүүд нь зүй тогтлыг үүсгэж, тэр нь нийгмийн тогтолцоог бүрдүүлдэг олон шийдлүүдийг нэгдмэл зорилгын хэрэгжилтэнд чиглүүлэх, захируулах логик үндэслэл болдог.

Иргэний бүлэг эрх, эрх чөлөөг баталгаажуулсан Үндсэн хуулийн 16-р зүйлийн заалт болгоныг нарийвчлан задлахад нийт 144 төрлийн эрх, эрх чөлөөний хэм хэмжээ, Төрийн үүргийг тодорхойлсон Үндсэн хуулийн 19.1 зүйлийн заалтыг утгыг нарийвчлан задлахад хүн ба иргэний эрх, эрх чөлөөг

баталгаатай хангахад шаардлагатай орчин, нөхцөл, баталгааг бий болгох төрийн 6 үүрэг, мөн иргэний нийтлэг үүргүүдийг тодорхойлсон 17-р зүйлийн заалтуудыг нарийвчлан задлахад 8 төрлийн үүргийн хэм хэмжээг агуулсан байна.

Эдгээр хэм хэмжээнүүд нь хоорондоо учир шалтгааны шүтэлцээгээр холбогдсон байдаг бөгөөд бүх зарчим болсон хэм хэмжээнүүд ийм учир шалтгааны шүтэлцээгээр холбогдон нийлж байж нэгдмэл зорилготой тогтолцоог үүсгэдэг. Ийм шүтэлцээнүүдийг нөгөө талаас ес зүйн хэм хэмжээ ч гэж нэрлэж болно. Үндсэн хуулиар тодорхойлсон олон зарчмуудын хоорондын шүтэлцээг тодорхойлох ажил энэ судалгааны ажлын агуулгад багтаагүй боловч ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд оролцогч талуудын хоорондын харилцааг зохицуулах аливаа эрх зүйн шийдлийг боловсруулахад зайлшгүй харгалзан үзэх ёстой хэв шинжүүд мөн гэж үзээд судалгааны тайланд зарим үр дүнг оруулав. Жишээлбэл, татвар төлөгч иргэн Үндсэн хуулиар ногдуулсан үүргийнхээ дагуу төлсөн татвараас бүрдэх хөрөнгийг төр ашигт малтмалын хайгуулын ажилд зарцуулах нь хэр оновчтой вэ? гэдэг асуултад дээрх шүтэлцээ буюу ес зүйн хэм хэмжээнүүд дээр л тулгуурлан нэг мөр хариулт өгөх боломжтой. (Хавсралт 3. Монгол Улсын Үндсэн хуулийн тулгуур зарчмуудын хоорондын учир шалтгааны шүтэлцээ)

9. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын тулгуур зорилтуудад ҮЗАМ-51 зарчмуудыг ашиглан хийсэн шүүлт

Үндсэн хуулиар тогтоосон зарчмууд нь нийгмийн гишүүдийн өдөр тутмын харилцаанд заавал мөрдөгдөх суурь хэм хэмжээнүүд мөн бөгөөд эдгээр хэм хэмжээнүүд нь нийгмийн харилцаанд оролцогч талуудын үйл ажиллагааг зохицуулдаг аливаа хууль эрх зүйн актаар тогтоосон үйлдэл, үүргийн заалтуудад мөн хэлбэрэлтгүй мөрдөгдөж байх учиртай. Монгол улсын хууль, тогтоомжуудад энэхүү зарчим алдагдсан байх нь олонтаа тохиодог бөгөөд үүний улмаас тухайн хууль, журам нь богино настай, улс төрчдийн үзэмжээс үлэмж хамааралтай болдог. Судалгааны баг ашигт малтмалын нөөц хайх, олборлох үйл ажиллагаанд оролцогч талуудын харилцаанд хэлбэрэлтгүй мөрдөгдвөл зохих 51 суурь зарчмуудыг Монгол улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудаас ялган цэгцэлж улмаар Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулиудаар ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг зохицуулдаг заалтууд нь тэдгээр зарчмуудад нийцэж буй эсэхийг шүүн үзэв. Шүүлтээр Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого гэдэг нэртэй баримт бичгээр тодорхойлсон зарим заалт ҮЗАМ-51 зарчмуудын заримтай нь нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

Шүүлт хийхдээ 3 өнгийн тэмдэглэгээ ашиглав. Ногоон өнгө нь ҮЗАМ-51 зарчимтай харшлаагүй, шар өнгө нь эргэлзээтэй буюу тодорхойгүй, улаан өнгө нь харшилж байгааг илэрхийлнэ. Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогоор тодорхойлсон зорилтуудад ҮЗАМ-51 зарчмуудаар мөн шүүлт хийхэд ҮЗАМ-51 зарчмуудтай нийцэхгүй байгаа 5 зорилтууд байгаа нь тогтоогдов.

№	Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого	Тухайн заалтын агуулгын ангилал	Тэмдэглэгээ	Үндсэн хуулийн зүйл, заалт	ҮЗАМ-51 зарчим
---	---	---------------------------------	-------------	----------------------------	----------------

1	2.1.8. төрийн зохицуулалтыг бүртгэл, зөвшөөрөл, хяналтын түвшинд төгөлдөржүүлж, ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд оролцохыг зохистой түвшинд байлгах.	төрийн зохицуулалтыг бүртгэл, зөвшөөрөл, хяналтын түвшинд төгөлдөржүүлж		ҮЗА М-51	Нийцэж байна.
		ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд оролцохыг зохистой түвшинд байлгах		16.1.3 -19.1	-Төр нь иргэн бүр оюуны болон биеийн хөдөлмөрлөх эрхлэх замаар хөрөнгө олж авах, эзэмших, өмчлөх эрхээ эдлэх баталгаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой. -Төр хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх ёстой.
2	3.1.1. түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын хайгуул, ашиглалтын эрх зүйн орчныг тусгайлан бүрдүүлэх;	түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын хайгуул, ашиглалтын эрх зүйн орчныг тусгайлан бүрдүүлэх		16.1.8 -19.1	-Төр нь иргэн хөдөлмөрлөх замаар бүтээсэн оюуны бүтээлийнхээ үр шимийг нь хүртэх эрхээ эдлэх орчин нөхцлийг бүрдүүлэх ёстой. -Төр хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх ёстой.
3	3.1.10. улсын болон бүс нутгийн хөгжилд нөлөө бүхий ашигт малтмалын ордыг нэгдмэл байдлаар ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх;	улсын болон бүс нутгийн хөгжилд нөлөө бүхий ашигт малтмалын ордыг нэгдмэл байдлаар ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх		16.1.8 -19.1	-Төр нь иргэн хөдөлмөрлөх замаар бүтээсэн оюуны бүтээлийнхээ үр шимийг нь хүртэх эрхээ эдлэх орчин нөхцлийг бүрдүүлэх ёстой. -Төр хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх ёстой.

4	3.2.2.2. геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизикийн ажлын хэмжээ болон улсын төсвийн санхүүжилтийг жил бүр тогтвортой өсгөж Монгол орны геологийн судалгааны хамрах хүрээг өргөтгөх, чанарыг сайжруулах;	геологийн зураглал, ерөнхий эрэл , агаарын геофизикийн ажлын хэмжээ болон улсын төсвийн санхүүжилтийг жил бүр тогтвортой өсгөж		17.1-19.1	-Төр хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд татварын орлогыг зарцуулах ёстой.
		Монгол орны геологийн судалгааны хамрах хүрээг өргөтгөх, чанарыг сайжруулах		ҮЗА М-51	Нийцэж байна
5	3.2.2.3. улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хүрээнд геофизик, геохими, уул-өрөмдлөгийн ажлыг цогцоор нь гүйцэтгэж чанарыг сайжруулах, хүдрийн дүүрэг, илрэл бүхий талбайд зарим онцгой тохиолдолд нарийвчилсан судалгааг гүйцэтгэх;	улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хүрээнд геофизик, геохими, уул-өрөмдлөгийн ажлыг цогцоор нь гүйцэтгэж чанарыг сайжруулах, хүдрийн дүүрэг, илрэл бүхий талбайд зарим онцгой тохиолдолд нарийвчилсан судалгааг гүйцэтгэх;		16.1.5-19.3	--Төр хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд төсвийн хөрөнгийг зарцуулах үйл ёстой.

Хүснэгт 4. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын шүүлт

10. 1994, 1997 оны Ашигт малтмалын хуулиуд болон одоогийн /2021/ хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулинд ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагаанд хэрэглэдэг шалгуур, нөхцөл, болзлуудын хэв шинжүүдэд ҮЗАМ-51 зарчмуудыг шалгуур болгон хийсэн шүүлт.

Энэ шүүлтийг хийж гүйцэтгэхийн тулд эхлээд ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах бэлтгэлийг хангах, нөөцийг хайх, тогтоох, үйлдвэр байгуулах, үйлдвэрлэл эрхлэх, үйлдвэрийг хаах зэрэг үе шатуудыг хамарсан уул уурхайн үйлдвэрлэлийн амьдралын мөчлөгүүдийн нийтлэг дарааллыг 8 үе шатуудаар процесслон зураглаж гаргав.




*Зураг 6. Нийгэмд өгөөжтэй олборлох үйлдвэрийн нөөцийг бий болгох үе шатууд
/Хавсралтаас том зургийг харна уу/*

Түүний дараа эдгээр үе шатуудаас хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах, хүлээн авах, олгох үе шатанд гүйцэтгэдэг үүрэг буюу үйлдлүүдийг ялгаж тэдгээр үүргийн үйлдлүүдийг ҮЗАМ-51 зарчмуудаар шалгуур болгон шүүж нягтлав. Шүүлт хийснээр хийсэн дүгнэлтүүдийг график хэлбэрт оруулж

- Тухайн заалтаар тодорхойлсон үүрэг нь ҮЗАМ51 зарчмуудын аль нэгэнтэй нь харшлаагүй бол ногоон өнгөөр;
- Тухайн заалтаар тодорхойлсон үүрэг нь ҮЗАМ51 зарчмуудын аль нэгэнтэй нь харшилж байвал улаан;
- Тухайн заалтаар тодорхойлсон үүрэг нь ҮЗАМ51 зарчмуудтай нийцсэн эсэх нь эргэлзээтэй буюу тодорхойгүй байвал шар өнгөөр тэмдэглэв.

1994 оны Ашигт малтмалын тухай хуулиар хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах, олгох үйл ажиллагааг зохицуулсан заалтуудаар тодорхойлсон 7 үүрэг/үйлдлийг шүүж үзэхэд дараах 4 заалтууд ҮЗАМ-51 зарчмуудтай нийцэхгүй эсвэл нийцэж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Энэ хуулийг ашигт малтмалын нөөцийг хайх ажилд хөрөнгө оруулалтыг татах зорилготойгоор боловсруулан гаргасан боловч тодорхой нааштай үр дүнг бий болгож чадаагүй бөгөөд суурь шалтгаан нь уг хуулийн үзэл баримтлал нь Үндсэн хуулийн үзэл баримтлалаас ялгаатай байсанд оршиж байна гэж үзэж байна.




Зураг 7. 1994 оны Ашигт малтмалын тухай хуулийг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн шүүлт (Бүтэн зургийг Хавсралт 6-аас үзнэ үү)

№	Ашигт малтмаын нөөцийг хайх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулдаг доголдолтой заалтууд	ҮЗАМ-51 зарчмуудын нийцлийн дүгнэлт
1	2 дахь үе шатын 2.2 заалт “Тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлийг хүлээн авах, бүртгэх, хянан шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид нийцүүлэн Засгийн газраас баталсан тусгай зөвшөөрөл олгох журмаар тодорхойлно . АМтХ10.2”	журмаар тодорхойлно гэдгийг ҮЗАМ шүүж үзэж тодруулах гэсэн боловч журмыг нь олж чадаагүй.
2	2 дахь үе шатын 2.4 заалт “Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага, албан тушаалтан ашигт малтмалын хайгуул хийх сонирхогчийн өргөдлийг хүлээн авмагц түүний бүрдлийг хянан үзэж хуулийн шаардлага хангасан эсэхийг тогтооно . АМтХ11.1”	Тус заалт нь “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхээ эдлэх орчин нөхцөлийг төрөөс бүрдүүлэх ёстой \МҮХ16.1.17-19.1\ зарчимд нийцсэн тодорхой шалгуураар биш төрийн нэрийн өмнөөс үүргээ гүйцэтгэж байгаа албан хаагчийн үзэмжээр шийдэж болох нөхцлийг үүсгэж байна.
3	2 дахь үе шатын 2.5 заалт “Өргөдөл заасан шаардлага хангасан бол түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэж , хариу өгнө. Харин ийнхүү шаардлага хангаагүй нь тогтоогдвол түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор буцаана. АМтХ 11.2”	Тус заалтын <ul style="list-style-type: none"> • шаардлага нь “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхээ эдлэх орчин нөхцөлийг төрөөс бүрдүүлэх ёстой \МҮХ16.1.17-19.1\ зарчим, • олгох эсэхийг шийдвэрлэж гэдэг нь “Төр нь иргэний төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхээ эдлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой \ҮХ16.1.12-19.1\ гэсэн зарчимд нийцсэн тодорхой шалгуурыг тогтоогоогүй байгаа тул иргэд 16 дугаар зүйлд заасан эрхээ эдлэх нөхцөл бүрдүүлж чадаагүй байна.
4	2 дахь үе шатын 2.6 заалт “Улсын төсвөөр хайгуул хийсэн ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл, мөн үндэсний аж үйлдвэрийг хөгжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой гэж үзвэл сонирхогчдыг өрсөлдүүлэн ашигт малтмалын хайгуул хийх тусгай зөвшөөрлийг шалгаруулалтын замаар олгож болно . Өрсөлдүүлэн шалгаруулах журмыг эцсийн шалгаруулалт хийх өдрөөс 90-ээс дээшгүй хоногийн өмнө зарласан байвал зохино. АМтХ11.4”	нэн чухал ач холбогдолтой гэж үзвэл гэдэг нь ҮЗАМ шалгуурын “Төр нь зөвхөн “үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилго”-д нийцүүлэн эдийн засгийн зохицуулалтыг хийх ёстой.” \МҮХ5.4\ мөн “Төр иргэний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хуульзүйн болон бусад баталгаатай орчин нөхцлийг бий болгох \МҮХ16.1-19.1\ зарчмуудын дагуу тодорхойлсон зорилтууд байгаад, тэрхүү зорилтын дагуу сонирхогчдыг өрсөлдүүлж, олгож болно гэдэг нь “Иргэн, аж ахуйн нэгж аливаа аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төрөөс олгохдоо үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”

		<p>\МУХ14.2\ зарчимтай зөрчилдөж, мөн олгохгүй тохиолдолд ямар нөхцлөөр олгохгүйг тодорхой болгоогүй байна.</p> <p><u>шалгаруулах журмыг</u> гэдгийн журмыг шалгах гэж АМГТГ-ын архиваас шаардлагатай материалыг авахаар хүсэлт гаргасан боловч журмыг олж чадаагүй.</p>
--	--	---

Хүснэгт 5. 1994 оны АМТХ-д ҮЗАМ-51 зарчмуудын нийцлийн дүгнэлт

1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах, олгох үйл ажиллагааг зохицуулахтай шууд холбоотой заалтуудад нийцлийн шүүлт хийж үзэхэд нэг заалт нь ҮЗАМ-51 зарчмуудтай нийцэхгүй байгаа нь тогтоогдлоо. (Хавсралт 5. 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн шүүлт)




Зураг 8. 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн шүүлт (Бүтэн зургийг Хавсралт 7-оос үзнэ үү)

№	Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулж буй доголдолтой заалт	ҮЗАМ-51 зарчмын нийцлийн дүгнэлт
1	<p>2.7 Өргөдөл гаргасан этгээд хайгуулын лицензийн эхний жилийн төлбөрийг хийснээс хойш ажлын 3 өдрийн дотор Геологи, уул уурхайн кадастрын алба нь хайгуулын лицензийг 3 жилийн хугацаатайгаар олгож, хайгуулын лиценз болон олгогдсон талбайг лицензийн бүртгэл, лицензийн зураг зүйн бүртгэлд бүртгэж, тэмдэглэнэ. /АМТХ 14,12/</p> <p>3.1 Байгаль орчны байгууллагаас бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд хайгуулын үйл ажиллагаа эхлэхийг хориглоно. /АМТХ 28,2/</p>	<p>Энэхүү тусгай зөвшөөрөл олгож буй лицензийн төлбөрийг хийснээс хойш болон зөвшөөрөл аваагүй гэсэн заалтууд нь “Иргэн бүр хөдөлмөрлөх, байгаль орчноо хамгаалах ёстой. \МҮХ16.1-17.1.4\” гэсэн ҮЗАМ51 зарчмаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргүүдээр иргэний эрхийг баталгаажуулах заалтыг хангалттай тусгаагүй байна.</p>

Хүснэгт 6. 1997 оны АМТХ-ийн зарим заалтууд болон ҮЗАМ-51 зарчмуудын нийцлийн дүгнэлт

Мөн 2006 онд батлагдсан, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Ашигт малтмалын тухай хууль”д ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн үйлдэл/ үүргийн заалтуудад шүүлт хийж үзэхэд доорх хүснэгтэнд тусгасан 6 заалт нь ҮЗАМ-51 зарчмуудтай нийцэхгүй байна.

Ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагааны замын зураг



Зураглалд дурдсан хуулийн заалтуудын тайлбар:

AMTX-ийн 10.1.2 энэ хуулийн , 20.1, 24.2, 26.9, 60.9-д заасан сонгон шалгаруулах журмыг Засгийн газрын эрх олгосноор батлах;

AMTX-ийн 18.1 Энэ хуулийн 7.1-д заасан хуулийн этгээд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ энэ хуулийн 10.1.2-т заасан журмын дагуу төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд түүнд дараахь баримт бичгийг хавсаргана:

AMTX-ийн 18.1.1.тухайн хуулийн этгээдийн нэр, шуудангийн хаяг, утас, факсны дугаар, цахим шуудангийн хаяг;

AMTX-ийн 18.1.2.тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

AMTX-ийн 18.1.3.үйлчилгээний хөлс төлсөн баримт;

AMTX-ийн 18.1.4.мэргэжлийн боловсон хүчин болон техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан талаархи мэдээлэл, тухайн талбайд гүйцэтгэх хайгуулын ажлын төрөл, хэмжээ, хугацаа, өртөг болон байгаль орчныг хамгаалах ажилд зарцуулах зардал бүхий төсөл, төсөв болон холбогдох бусад баримт бичгийг нэгтгэсэн техникийн санал;

AMTX-ийн 18.1.5.төрийн захиргааны байгууллагын баталсан маягтын дагуу үйлдэж, битүүмжилж ирүүлсэн үнийн санал;

AMTX-ийн 18.1.6.Монгол Улсад татвар төлөгчөөр бүртгүүлсэн тухай татварын албаны тодорхойлолт;

AMTX-ийн 18.1.7.Энэ хуулийн 10.1.2-д заасан журамд заасан бусад шаардлагатай баримт бичиг.

AMTX-н 34.1 Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 20.3, 26.3.2, 26.3.3-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлнө.

Зураглалд дурдсан хуулийн заалтуудын тайлбар:

AMTX-ийн 48.1.1 айгуулын ажлын төлөвлөгөөг хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон өдрөөс хойш 30 хоногийн, дараагийн жилүүдэд тухайн оны төлөвлөгөөг 04 дүгээр сарын 15-ны дотор;

AMTX-ийн 48.1.2 хайгуулын ажлын жилийн тайланг төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу гаргаж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

AMTX-ийн 48.1.3 энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан авуулгүй ажиллагааны талаархи мэдээг жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор.


Зураг 9. 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн шүүлт (Бүтэн зургийг Хавсралт 8-аас үзнэ үү)

№	Ашигт малтмаын нөөцийг хайх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулдаг хуулийн доголдолтой заалтууд	ҮЗАМ-51 зарчмуудын нийцлийн дүгнэлт
1	1.2 Төрийн захиргааны төв байгууллага нь ашигт малтмалын тойм судалгаа хийх хүсэлтийг хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх (АМТХ 11.1.7)	АМТХ 11.1.7-д заасан тус үүрэгт <i>“иргэний төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхээ эдлэх баталгаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой” /МҮХ16.1.12/</i> гэсэн зарчмын дагуу хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхой заагаагүй байгаа нь төрийн албан хаагчийн тухайн хүсэлтийг үзэмжээрээ шийдвэрлэх нөхцөл байдлыг үүсгэж байна.
2	2.4 Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 17.1-д заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч, 45 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ. Аймаг, нийслэлийн Засаг дарга хуульд заасан үндэслэлээр татгалзсан хариу өгч болно.	Тус үүрэгт ИТХ-аас санал авах хугацаа болон саналыг гаргах зарчим, шалгуурыг тодорхойлоогүй байгаа учраас <i>“Иргэний гаргасан өргөдөл, гомдлыг төрийн байгууллага, албан тушаалтан шийдвэрлэх ёстой” /МҮХ16.1.12/</i> зарчим зөрчигдөх тохиолдолууд элбэг гардаг.
3	2.3.2 Хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 18.1-д заасан шаардлага (АМТХ-ийн 18.1.4. мэргэжлийн боловсон хүчин болон техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан талаархи мэдээлэл, тухайн талбайд гүйцэтгэх хайгуулын ажлын төрөл, хэмжээ, хугацаа, өртөг болон байгаль орчныг хамгаалах ажилд зарцуулах зардал бүхий төсөл, төсөв болон холбогдох бусад баримт бичгийг нэгтгэсэн техникийн санал; АМТХ-ийн 18.1.5. төрийн захиргааны байгууллагын баталсан маягтын дагуу үйлдэж, битүүмжилж ирүүлсэн үнийн санал) хангаагүй бол АМГТГ сонгон шалгаруулалтад	Энэхүү үүрэг нь ҮЗАМ-51ын <i>“Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхээ эдлэх орчин нөхцөлийг төрөөс бүрдүүлэх ёстой” /МҮХ16.1.17/</i> зарчмыг хангахгүй байна. Мөн үүрэгт туссан АМТХ-ын 18.1. 4 болон АМТХ-ын 5 дахь заалт нь ҮЗАМ-51 зарчмуудын нэг болох <i>“Иргэн, аж ахуйн нэгж аливаа аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төрөөс олгоходоо үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахгүй байх ёстой” /МҮХ14.2/</i> зарчмыг хангахгүй байна.

	оролцох боломжгүй үндэслэл, шалтгааныг хүсэлтэд хавсаргасан баримт бичгийн хамт хүсэлт гаргасан хуулийн этгээдэд хүргүүлнэ. (АМТХ 20.4)	
4	4.3 АМГТГ нь өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан зохих шийдвэрийг АМТХ-ийн 21.1.3-т заасны дагуу буюу “энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасны үндсэн дээр хайгуулын талбайн аль ч хэсэгт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг онцгой эрхийнхээ дагуу авах” гаргаж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.	Тус үүрэгт дурдсан АМТХ-ийн 21.1.3 гэсэн заалтад тусгагдсан нөхцөл, шаардлагыг хангах эсэхийг шалгах шалгуур нь тодорхойгүй байгаа учраас ҮЗАМ-51 зарчмуудын нэг болох <i>“Иргэн, хуулийн этгээдий өөрийн нөөцөө зарцуулан бий болгосон өгөгдөл түүнд суурилсан мэдлэг нь тухайн иргэн, хуулийн этгээдийн өмч байх ёстой” /МҮХ16.1.17/ болон “Төр нь иргэний эрх чөлөө, өмч хөрөнгө халдашгүй байх эрхээ эдлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой”</i> гэдэг зарчмуудтай харшилж байна.
5	4.4.2 Зөвшөөрөл олгохоос татгалзсан бол шалтгаан, хуулийн үндэслэлийг дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ.	Хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах шалтгааны үндэслэлийн шалгуур нь ерөнхий, шалгах боломжгүй байна. Энэ нь ҮЗАМ-51 зарчмуудын нэг болох <i>“Төр нь иргэн бүр оюуны болон биеийн хөдөлмөрлөх эрхлэх замаар хөрөнгө олж авах, эзэмших, өмчлөх эрхээ эдлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой” /МҮХ16.1.3/ болон “Иргэний гаргасан өргөдөл, гомдлыг төрийн байгууллага, албан тушаалтан шийдвэрлэх ёстой” /МҮХ16.1.12/ зарчмыг хангахгүй байх сөрөг үр дагаврыг бий болгож болзошгүй.</i>
6	5.6 Төрийн захиргааны байгууллага нь АМТХ-ийн 48.3-т заасан тайлан, 48.6.1-д заасан техник-эдийн засгийн үндэслэлд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс мэргэшсэн мэргэжилтнийг шинжээчээр 30 хоногт багтаан томилуулж, 90 хоногт багтаан хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсны үндсэн дээр уг нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх, хүлээн авах, тайлан, техник, эдийн засгийн үндэслэлийг анхдагч материалын хамт мэдээллийн санд бүртгэх тухай шийдвэр гаргана. (АМТХ 48.4) (АМТХ 21.1.3)	Тус үүрэг нь утга найруулгын хувьд алдаа байгаагаас гадна хэлэлцүүлэгт оролцох этгээдүүдийн ур чадвар болон шийдвэр гаргах шалгуурыг нарийвчлан тодорхойлоогүй байна. Энэ нь ҮЗАМ-51 зарчмуудын нэг болох <i>“Төр нь иргэн бүр оюуны болон биеийн хөдөлмөрлөх эрхлэх замаар хөрөнгө олж авах, эзэмших, өмчлөх эрхээ эдлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой” /МҮХ16.1.4-19.1/ зарчмыг хангахгүй байна.</i>

Хүснэгт 7.2006 оны АМТХ-д ҮЗАМ-51 зарчмуудын нийцлийн дүгнэлт

2020 онд батлагдсан “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-аар тогтоосон ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах, олгох үйл ажиллагаанд оролцогч талуудын гүйцэтгэх үүргүүдийн заалтуудад шүүлт хийж үзэхэд 4 заалт нь ҮЗАМ-51 зарчмуудтай нийцэхгүй байна. (Хавсралт 7. ТЗОСШЖ-ыг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн шүүлт)



Зураг 10. ТЗОСШЖ-ыг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн шүүлт /Хавсралтаас том зургийг харна уу/

№	Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулдаг журмын доголдолтой заалтууд	ҮЗАМ-51 зарчмуудын нийцлийн дүгнэлт
1	1.3 Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 17.1-д заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч, 45 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ. (АМТХ 17.2)	ИТХ-нас авах саналын агуулгыг нарийвчлан тодорхойлоогүйн улмаас тодорхойгүй нөхцөл үүсч төр нь иргэндээ баталгаатай орчин нөхцөл бүрдүүлэх зарчим зөрчигддөг.
2	2.4.2 Стратегийн ач холбогдол бүхий ордын талбайн хил заагт хамаарсан талбайд тусгай зөвшөөрөл олгох асуудлыг төрийн захиргааны төв байгууллага нь Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогод нийцүүлэн Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газарт уламжлан шийдвэрлүүлнэ. (ТЗОСШЖ	Тус үүрэг туссан “стратегийн ач холбогдол бүхий ордын талбайн хил заагт хамаарсан талбайд” гэдэг заалт нь - хайгуулын ажил гүйцэтгээгүй байхад стратегийн ач холбогдол бүхий орд гэдгийг тодорхойлох боломжгүй -стратегийн ач холбогдол бүхий ордыг тодорхойлох нарийн, үзэмжийн бус шалгуурыг тогтоох боломжгүй зэрэг шалтгааны улмаас логикийн зөрчилийг агуулж байгаа бөгөөд энэ нь төрийн байгууллагын үйл ажиллагааны зарчимтай зөрчилдөж байна.

	1.4)	
3	3.8 Сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга нь үнийн саналыг нээхдээ сонгон шалгаруулалтад оролцогчийн гүйцэтгэх захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг үнийн санал нээх ажиллагаанд оролцох боломжоор хангана. (ТЗОСШЖ 4.4.2)	Тус үүрэгт оролцох боломжоор хангана гэдэг заалт нь үзэмжээс хамааралтай бөгөөд оролцох боломжоор хангах арга замыг нарийвчлан тодорхойлоогүй байгаа учраас <i>“Иргэний гаргасан өргөдөл, гомдлыг төрийн байгууллага, албан тушаалтан шийдвэрлэх ёстой”/МҮХ16.1.12/</i> зарчмыг хангахгүй байна.


Хүснэгт 8. ТЗОСШЖ-ыг ҮЗАМ-51 зарчмуудын нийцлийн дүгнэлт

11. ОХУ, Австрали, Канадад мөрдөгддөг Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг зохицуулдаг ижил төстэй хуулиудаар тогтоосон шалгуур нөхцөл болзлуудын хэв шинжүүдэд ҮЗАМ-51-зарчмуудыг шалгуур болгон хийсэн шүүлт

Уул уурхайн үйлдвэрлэлээр ихээхэн туршлагатай зарим орнуудад ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрөл олгодог тогтолцооны хэв шинжүүдийг загвар болгон ашиглах боломжийг судлах зорилгоор ҮЗАМ-51-ийг шүүлтүүр болгон Австрали, Канад, ОХУ-д мөрдөгддөг ижил төстэй хуулиудаар тогтоосон үүргүүд/үйлдлүүдийн хэв шинжүүдэд мөн шүүлт хийв. Мэдээлэл хайх, цуглуулах, орчуулахад үлэмж их цагийн нөөцийг зарцуулах шаардлагатай, судалгааны багт цаг хугацаа хязгаарлагдмал байсан зэрэг шалтгаануудын улмаас шүүлтийг тоймлон хийж гүйцэтгэлээ.

ОХУ-ын холбогдох хуулиар ашигт малтмалын нөөцийг хайх лицензийг дуудлага худалдаа явуулах үйл ажиллагаанд хэрэглэдэг шалгуур, нөхцөл болзлуудыг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн дүгнэлт

ОХУ-ын Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааг зохицуулдаг хууль, дүрмүүд нь холбооны улсын суурь хэв шинжүүдэд суурилсан байдгаас гадна тэдний ашигт малтмал хайгуулын зөвшөөрөл олгодог процесс нь олон шат дамжлагатай, мөн шалгуурууд нь ҮЗАМ-51 зарчмуудын заримд нь харшилж байна. Иймд ОХУ-д ашигладаг загвар нь Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал болон нийгмийн тогтолцоонд тохирохгүй гэдэг дүгнэлтийг хийж байна.



Зураг 11. ОХУ-ын дуудлага худалдаа явуулах үйл ажиллагаанд хэрэглэдэг шалгуур, нөхцөл болзлуудыг **ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн шүүлт /Хавсралтаас том зургийг харна уу/**

№	Дуудлага худалдаа явуулах үйл ажиллагааны доголдолтой заалт	Монгол Улсын ҮЗАМ-51 зарчмын нийцлэл дүгнэлт
1	1.1 Дуудлага худалдаанд оролцох өргөдөл гаргахаас өмнө өргөдөл гаргагч нь дуудлага худалдааны журам, нөхцлийн 1-р хавсралтын дагуу хоёр хувь эхлээрээр тухайн мужийн газрын хэвлийн ашиглалтын газартай /Приволжскнедратай/ гэрээ байгуулна.	Энэ үе шатанд өргөдөл гаргагч нь дуудлага худалдааны журам, нөхцлийн 1-р хавсралтын дагуу гэрээ байгуулна гэдэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн ҮЗАМ51 зарчмын “ <i>Төр нь иргэний төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж, шийдвэрлүүлэх эрхээ эдлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх эстэй. МҮХ16.1.12-19.1\” зөрчилдөж байна.</i> Иргэний гаргаж буй өргөдөл гомдлыг ямар нэгэн шалгуур, нөхцөлтэйгээр хүлээн авах нь иргэний үндсэн эрхийг зөрчиж буй юм.
2	2.2 Дуудлага худалдаанд оролцох өргөдлийг дуудлага худалдааны комисс хүлээж авсан өдрөөс хойш ажлын 15 хоногт багтаам дуудлага худалдаанд оролцохыг хүссэн	● санхүүгийн, боловсон хүчин, техникийн чадавхийг шалгах мөн хүлээн авсан, эсхүл хүлээн авахаас татгалзах гэдэг нь МҮХ14.2\ эрх зөрчигдөж, нөгөөтэйгээр төрийн байгууллага, төрийн албан хаагчаар

	<p>өргөдөл гаргагчийн <u>санхүүгийн, боловсон хүчин, техникийн чадавхийг шалгах зорилгоор</u> өргөдлийн материалыг хянана. Өргөдлийг <u>хүлээн авсан, эсхүл хүлээн авахаас татгалзах</u> шийдвэрийг дуудлага худалдааны комиссын хуралдааны тэмдэглэлд хөтлөнө.</p>	<p>өргөдлөө шийдвэрлүүлж чадахгүйгээс мөн \МҮХ16.1.12-19.1\ төрийн үүргээ биелүүлэхгүй, иргэний эрхийг зөрчсөн үйл явц бий болж байна.</p>
3	<p>3.4 Хэрэв нэг удаагийн төлбөрийн дараагийн үнийг гурван удаа зарласны дараа дуудлага худалдаанд оролцогчдын хэн нь ч регистрийн дугаартай хавтангаа өргөөгүй бол дуудлага худалдаа дуусна. Дуудлага худалдаанд оролцогч нь <u>газрын хэвлий ашигласны төлбөрийн хамгийн өндөр хэмжээг санал болгосноор</u> дуудлага худалдааны ялагчаар тодорно.</p>	<p><u>газрын хэвлий ашигласны төлбөрийн хамгийн өндөр хэмжээг санал болгосноор</u> Энэ үйл явц нь төр иргэнээ “хүн хөрөнгө чинээгээрээ ялгаварлан гадуурхагдахгүй байх \МҮХ14.2.8\” эрхийг зөрчиж, мөн “Төр нь иргэн бүр оюуны болон биеийн хөдөлмөр эрхлэх замаар хөрөнгө олж авах, эзэмших, өмчлөх эрхээ эдлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой. \МҮХ16.1.3-19.1\” төр иргэний бизнес эрхлэх орчин нөхцлийг бүрдүүлэх үүргээ хангагдахгүй байна.</p>

Хүснэгт 9. ОХУ-ын Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тогтолцооны хэв шинжүүдэд хийсэн дүгнэлт

Австралийн холбооны улсад мөрдөгддөг Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг зохицуулдаг ижил төстэй хуулиудаар тогтоосон шалгуур нөхцөл болзлуудын хэв шинжүүдэд ҮЗАМ-51-ийг шалгуур болгон хийсэн шүүлт

Ашигт малтмалын хайгуулын ажилд ихээхэн хөрөнгө оруулалтыг тогтвортой татаж чадаж байгаа Австрали улсын зарим мужуудын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход тавигддаг шалгуур, нөхцөл, болзлууд нь ҮЗАМ-51 зарчмуудад байна. Австралийн Холбооны Улсын Викториа мужийн 2019 оны (Тогтвортой хөгжил) (Ашигт малтмалын салбар) ашигт малтмалын тухай хуулийн хайгуулын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргах, шийдвэрлэх шатанд хэрэглэдэг шалгуур, нөхцлийн хэв шинжүүдийг шүүж үзэхэд ҮЗАМ-51 зарчмуудад бүрэн нийцэхгүй байна гэдэг дүгнэлтэд хүрэв.

1	<p>9. Сайд (эсвэл төлөөлөгч) дараах шаардлагын дагуу өргөдлийг шийдвэрлэнэ. Үүнд: 1. Өргөдөл гаргагчийн ажлын туршилага, хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулсан байдал; 2. Ажлын хөтөлбөр; 3. Санал болгож буй ажил, нөхөн сэргээлтийн ажлыг санхүүжүүлэх боломжийг тус тус харгалзан үзэж шийдвэр гаргана.</p>	<p>1. “Өргөдөл гаргагчийн ажлын туршилага, санхүүжүүлэх боломж” гэх шаардлагууд нь тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн 14.2-т заасан “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”/ \МҮХ14.2.-19.1/ мөн 16.1.4-т заасан “хувийн аж ахуй эрхлэх” /\МҮХ16.1.4-19.1/ гэх зарчмуудтай нийцэхгүй харшилж байна.</p>
---	---	---

Австралийн Холбооны Улсын баруун Австрали мужийн Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох зохицуулалт ба ҮЗАМ-51 зарчмын нийцлийн дүгнэлт

Австралийн Холбооны Улсын Баруун Австрали мужийн 1978 оны ашигт малтмалын тухай хуулийн хайгуулын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргах, шийдвэрлэх шатанд хэрэглэдэг шалгуур, нөхцлүүдийн хэв шинжүүдэд шүүлт хийхэд ҮЗАМ-51 зарчмуудад бүрэн нийцэхгүй байна гэдэг дүгнэлтийг хийв.

Зураг 13. Баруун Австрали мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тогтолцооны хэв шинжүүдэд хийсэн шүүлт

№	Ашигт малтмал хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаагны ҮЗАМ-51-д харшилж буй заалт	ҮЗАМ-51 зарчмын нийцлийн дүгнэлт
3.	<p>“Ашигт малтмал, үйлдвэрлэл болон аюулгүй байдлын газар”-т хайгуулын тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл гаргах. Үүнд:</p> <p>Хайгуулын тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдлийн бүрдүүлбэр баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> • Санал болгож буй хайгуулын арга • Санал болгож буй ажлын хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл • Хайгуулын зардлын тооцоолол • Өргөдөл гаргагчийн техникийн болон санхүүгийн эх үүсвэр 	<p>1. “Өргөдөл гаргагчийн техникийн болон санхүүгийн эх үүсвэр” гэх шаардлагууд нь тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн 14.2-т заасан “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”/ \МҮХ14.2.-19.1/ мөн 16.1.4-т заасан “хувийн аж ахуй эрхлэх” /\МҮХ16.1.4-19.1/ гэх зарчмуудтай нийцэхгүй харшилж байна.</p>
6.	<p>(2) Тодорхой хугацаанд татгалзсан мэдэгдэл өгөөгүй, эсхүл татгалзсан мэдэгдлийг буцааж татсан тохиолдолд уул уурхайн бүртгэлийн ажилтан сайдад тусгай зөвшөөрлийг олгох эсвэл татгалзлыг санал болгосон тайланг</p>	<p>1. “Зөвшөөрлийг олгох эсвэл татгалзлыг санал болгосон тайлан”–гийн шалгуур үзүүлэлт хуульд тодорхойгүй мөн “Сайд (2) эсвэл (5) дэд хэсгийн тайланг хүлээн авч хянан үзээд хайгуулын тусгай зөвшөөрөл</p>


<p>хүргүүлнэ. Хайгуулын тусгай зөвшөөрлийн талаарх зөвлөмжийн шалтгааныг тодорхойлсон байна.</p> <p>(6) Сайд (2) эсвэл (5) дэд хэсгийн тайланг хүлээн авч хянан үзээд хайгуулын тусгай зөвшөөрөл олгож, татгалзаж болно.</p>	<p>олгож, татгалзаж болно” гэсэн нь эрх бүхий этгээд үзэмжээрээ шийдвэр гаргах үндэстэй байна. Иймд дээрх тодорхойгүй байдал нь 16.1.4-т заасан “хувийн аж ахуй эрхлэх” /МҮХ16.1.4-19.1/ болон 19.1-т заасан “хууль зүйн баталгааг бүрдүүлэх” гэх зарчмуудтай нийцэхгүй харшилж байна.</p>
--	---

Хүснэгт 11. Баруун Австрали мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тогтолцооны хэв шинжүүдэд хийсэн дүгнэлт

Австралийн Холбооны Улсын Викториа, Баруун Австрали мужуудын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомж нь холбооны улсын суурь хэв шинжүүдэд суурилсан байдгаас гадна ашигт малтмал хайгуулын зөвшөөрөл олгодог процессын шийдвэр гаргах үе шатууд дахь шалгуур нь Монгол Улсын Үндсэн Хуулийн зарчимуудтай бүрэн нийцэхгүй байна. Иймд Австралийн Холбооны Улсын Баруун Австрали мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох эрх зүйн зохицуулалтын загварыг Монгол Улсад шууд авч хэрэгжүүлэх нь оновчтой бус харин тохируулгуудыг хийж, зарим нэг оновчтой санаануудыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн үзэж байна.

Канад улсад мөрдөгддөг Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг зохицуулдаг ижил төстэй хуулиудаар тогтоосон шалгуур нөхцөл болзлуудын хэв шинжүүдэд ҮЗАМ-51-ийг шалгуур болгон хийсэн шүүлт

Канад улсын мужуудаас бидний судалгаанд оновчтой тохирох мужийг сонгохдоо хайгуулд зарцуулж буй хөрөнгө, ордын үнэлгээний хэмжээ хамгийн өндөр болон хөрөнгө оруулалтын орчны таатай байдлыг судлан Саскачеван мужийг сонгосон. Саскачеван мужийн ашигт малтмалын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулдаг хууль, журмуудад үндэслэн дараах зураглалыг боловсруулсан. Канадын Саскачеван мужийн газар нутагт ашигт малтмалын үйл ажиллагаа явуулахын тулд тухайн ажлын зорилго, үүргээс хамаарч эрлийн тусгай зөвшөөрөл, хайгуулын тусгай зөвшөөрөл, олборлолтын тусгай зөвшөөрөл гэсэн 3 тусгай зөвшөөрлөөс аль нэгийг авах шаардлагатай. Хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэгч этгээд нь Эрчим хүч, байгалийн баялагийн яаманд “Subsurface mineral tenure regulation”-н дагуу өргөдөл гаргаж, тендерт оролцож олж авдаг. Саскачеван мужийн эрлийн тусгай зөвшөөрөл болон хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад судлагдсан талбай эсвэл судлагдаагүй талбайгаас хамаарч бүрдүүлэх материал нь өөр өөр байдаг.



Зураг 14. Канад улсын Саскачеван мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тогтолцооны хэв шинжүүдэд хийсэн шүүлт /Хавсралтаас том зургийг харна уу/

№	Саскачеван мужийн ашигт малтмал эрэх, хайх, олборлох тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны зохицуулалтын доголдолтой үүргүүд	ҮЗАМ-51 зарчмуудын нийцлийн дүгнэлт
1	1.5.1 Эрлийн тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл нь хууль, журамд нийцсэн байвал Сайд зөвшөөрөл олгоно	Тус үүрэгт хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхой заагаагүй байгаа нь төрийн албан хаагчийн үзэмжээрээ шийдвэрлэх нөхцөл байдлыг үүсгэж байна. Мөн ҮЗАМ-51 зарчмуудын нэг болох <i>“иргэний төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхээ эдлэх баталгаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой” /МҮХ16.1.12/</i> гэсэн зарчимтай зөрчилдөж байна.
2	1.5.1 Эрлийн тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл нь хууль, журамд нийцээгүй бол	Энэхүү үүрэг нь эрлийн тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тухай мэдээллийг тусгай зөвшөөрөл хүсэгч

	Сайд зөвшөөрөл олгохоос татгалзаж болно	этгээдэд мэдээллэнэ гэсэн үүрэг тусгагдаагүй тул ҮЗАМ-51 зарчмуудын нэг болох <i>“Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхээ эдлэх орчин нөхцөлийг төрөөс бүрдүүлэх ёстой” /МҮХ16.1.17/ зарчмыг хангахгүй байна.</i>
3	2.8.2 Хэрвээ хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл нь хууль, журамд нийцээгүй бол Сайд зөвшөөрөл олгохоос татгалзаж болно	Энэхүү үүрэг нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тухай мэдээллийг тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд мэдээллэнэ гэсэн үүрэг тусгагдаагүй байгаа тул ҮЗАМ-51 зарчмуудын нэг болох <i>“Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхээ эдлэх орчин нөхцөлийг төрөөс бүрдүүлэх ёстой” /МҮХ16.1.17/ зарчмыг хангахгүй байна.</i>
4	3.3 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаа эрхлэхдээ хууль, журмаар хүлээсэн үүргээ биелүүлсэн байвал Сайд олборлолтын тусгай зөвшөөрөл олгоно.	Тус үүрэгт олборлолтын тусгай зөвшөөрөл хүсэгч этгээд нь хайгуулын үйл ажиллагаа эрхлэхдээ үүргээ биелүүлсэн эсхийг тогтоох шалгуурыг нарийвчлан тодорхойлоогүй байгаа нь төрийн албан хаагчийн үзэмжээрээ шийдвэрлэх нөхцөл байдлыг үүсгэж байна. ҮЗАМ-51 зарчмуудын нэг болох <i>“иргэний төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхээ эдлэх баталгаатай орчин нөхцөлийг бүрдүүлэх ёстой” /МҮХ16.1.12/ гэсэн зарчимтай зөрчилдөж байна.</i>

Хүснэгт 12. Канад улсын Саскачеван мужийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тогтолцооны хэв шинжүүдэд хийсэн дүгнэлт

Канад улсын Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааг зохицуулдаг хууль, дүрмүүд нь холбооны улсын суурь хэв шинжүүдэд суурилсан байдгаас гадна тэдний ашигт малтмал хайгуулын зөвшөөрөл олгодог процессын шийдвэр гаргах үе шатуудад хэрэглэдэг шалгуур, нөхцлүүд нь ҮЗАМ-51 зарчимуудад нийцэхгүй байгаа тул Канад улсын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох эрх зүйн зохицуулалтын загварыг Монгол улсад шууд хэрэгжүүлэх нь оновчтой бус харин тохируулгуудыг хийж, зарим нэг оновчтой санаануудыг авч хэрэгжүүлэх боломжтой.

12. Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааны онцлогууд ба ҮЗАМ-51 хоорондын харилцан уялдааг хангах хэрэгцээ шаардлага

Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг зохицуулахдаа түүний мөн чанараас үүдэн гардаг онцлог хэв шинжүүдийг харгалзан үзэж шаардлагатай шийдлүүдийг боловсруулан хууль, дүрэм, журамдаа тусгах зайлшгүй шаардлагатай. Ийм шийдлүүд нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах, нэмэгдүүлэх чухал хөшүүрэг болдог. Нөгөө талаасаа хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх хэрэгцээ шаардлага Монгол улсын нийгмийн зорилгоос урган гарч байна. Ингэж хоёр талаасаа ашиг сонирхлоо нэгтгэн нэгдмэл зорилготой болох нь системийн нарийн төвөгтэй оюуны шийдлүүдийг шаарддаг. Цаг хугацаа болон бусад нөөцийн хязгаарлагдмал байдлын улмаас судалгааны баг системийн нарийн шийдлүүдийг гаргах боломжгүй байсан бөгөөд энэ удаад хөрөнгө оруулагчдын эрх ашгийг нийгмийн эрх ашигтай нийцүүлэх шийдлүүдийг хөгжүүлэн гаргахад дэм болохуйц дараах ерөнхий санаануудыг боловсруулан бэлдэв.

Үүнд:

1. Хайгуулын ажлын улмаас байгаль орчин болон, нийгмийн гишүүдийн эрх ашигт сөрөг нөлөө үзүүлсэн тохиолдолд нэгэнт олгосон хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцалдаг практикаас татгалзаж, харин хайгуулын ажлыг түдгэлзүүлэх, зогсоох, торгох зэрэг арга хэлбэрүүдийг уян хатан хослуулж хэрэглэдэг болох.
2. Татвар төлөгчдийн хөрөнгийг ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаа шиг өндөр эрсдэлтэй, үнийн хэлбэлзлээс хамаарал ихтэй бизнесийн төслүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулдаг практикаас татгалзах.
3. Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг тухайн талбайд геологийн суурь судалгааны ажлуудыг заавал гүйцэтгэдэг, түүний үр дүнд хуримтлуулсан өгөгдөл, мэдээллийг үнэ төлбөргүйгээр Улсын Геологийн мэдээллийн санд хүлээлгэн өгдөг болзолтойгоор олгодог болох.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн суурь судалгааны ажлын үр дүнд бий болгосон мэдээллийг нэгтгэн шуурхай нэгтгэн цэгцэлж олон нийтэд нээлтэй болгох ажлыг төр хариуцан гүйцэтгэх.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүч, хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнд ашигт малтмалын ордын талаар бий болгосон өгөгдөл, мэдлэг нь тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувийн өмч гэдгийг хүлээн зөвшөөрч, уг өмчөө тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ҮЗАМ-49 зарчимд нийцсэн арга, хэлбэрээр бусдад чөлөөтэй шилжүүлэх боломжийг хуульчлан тогтоох.
5. Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаанд оролцогч талуудын хоорондын харилцааны бүхий л шат дамжлагуудад ҮЗАМ-51 зарчмыг хэлбэрэлтгүй мөрдүүлэхэд шаардлагатай, хүний үзэмжээс хамааралгүй хэмжүүр, шалгуур, стандартуудыг нарийвчлан тодорхойлж албажуулах зэрэг болно.

13. Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгоход хэрэглэдэг шалгуур, нөхцөл, болзлуудыг ҮЗАМ-51 болон төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын тулгуур зорилтуудад нийцүүлэх шийдлүүдийн ерөнхий санаа

Улам бүр хумигдаж байгаа ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх бодит хэрэгцээ шаардлага байгаа нь энэхүү судалгаа болон бусад судалгаануудаар нотлогдож байна. Хайгуулын ажилд хөрөнгө оруулалтыг дэмжих, идэвхжүүлэхэд чиглэсэн, аль ч улс орны онцлогт шууд тохирдог бэлэн шийдлүүд байхгүй бөгөөд тийм шийдлүүдийг боловсруулан гаргах шаардлагатай. Мэдээж бусад орнуудын амжилтанд хүрсэн загвар, туршлагыг судлах нь зүйтэй боловч гадаад орнуудын ямар ч загвар Монголын нөхцөлд яв цав тохирохгүй нь ойлгомжтой. Монголын нөхцөлд тохирох шийдэл нь юуны өмнө Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалдаг хэв шинжүүдийг агуулсан байх учиртай. Ийм шийдлийг олон талт, нарийвчилсан судалгааны үндсэн дээр боловсруулан гаргах боломжтой бөгөөд энэхүү судалгааны хүрээнд судалгааны баг нь ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг олгоход баримтлах ҮЗАМ-51 зарчмуудад нийцсэн шалгуур, нөхцөл, болзлуудын жишиг ерөнхий хэв шинжүүдийг системийн инженерчлэлийн аргыг ашиглан дараахи байдлаар тодорхойлж гаргав.

Хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагаа нь дараах 3 үе шатнаас бүрддэг байна. Үүнд:

- Ашигт малтмалын нөөцийг хайх эрхийг бүртгэх, баталгаажуулах
- Хайгуулын эрх эзэмшигчийн нийгмийн хариуцлагын чадамжийг бэхжүүлэх

- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийг үүсгэх, баталгаажуулах
1. **Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагаа эрхлэх эрхийг бүртгэх, баталгаажуулах** үе шатыг дараах зарчмууд дээр суурилсан аргаар хэрэгжүүлэх нь оновчтой гэж үзэж байна.
 - А. Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааг эрхлэх эрх нь Үндсэн хуулийн 16-р зүйлд зааснаар нэгэнт баталгаажсан эрхүүдэд хамаарах эрх мөн тул тийм хүсэлт гаргаж өргөдөл ирүүлсэн тухай бүрд тухайн талбайд ашигт малтмалын нөөцийг хайх эрхийг нь шууд хүлээн зөвшөөрч албан ёсны бүртгэлд бүртгэх.
 - В. Тодорхой байршил бүхий талбайд хэд хэдэн иргэн, хуулийн этгээдүүд ашигт малтмалын нөөцийг хайх хүсэлт гаргасан тохиолдолд Үндсэн хуулийн 14-р зүйлд заасан зарчимд харшлахгүй шалгуураар аль нэг иргэн/байгууллагыг сонгож тухайн талбайд ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагаа эрхлэх онцгой эрхийг нь хүлээн зөвшөөрч баталгаажуулдаг байх. Тухайлбал, хүсэлтийг ирүүлсэн цаг хугацааг шалгуур болгон цаг хугацааны хувьд түрүүлж өргөдлийг ирүүлсэн иргэн, хуулийн этгээдэд онцгой эрхийг үүсгэж болох юм.
 2. **Хайгуулын эрх эзэмшигчийн нийгмийн хариуцлагын чадамж, зөвшилцлийг бий болгох** үе шатны үйл ажиллагаа нь ашигт малтмалын нөөцийг хайх эрхийг эзэмшигч иргэн/хуулийн этгээд нь ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагаа эрхлэхдээ Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд заасан нийтлэг үүргүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай чадамжтай болгоход чиглэх юм.
 - А. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага нь нийгмийн хариуцлагын удирдлагын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг нэвтрүүлж баталгаажуулсан байх
 - В. Тусгай зөвшөөрлөөр ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн нутаг дэвсгэр амьдардаг иргэдийн өөрөө удирдах байгууллагатай /сумын ИТХ/ Нийгмийн хариуцлагын харилцан зөвшилцлийн гэрээг /НХХЗГ/ байгуулсан байх
 - С. НХХЗГ-ний загварыг Монгол улсын Засгийн газраас баталж мөрдүүлдэг байх
 - Д. НХХЗГ-г байгуулах үйл ажиллагааг ил тод явуулах, талуудын хүлээх үүргүүдийг нарийвчлан тодорхойлох, зохицуулах журмыг Монгол улсын Засгийн газраас баталж мөрдүүлэх
 3. **Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагаа эрхлэх эрхийг хэрэгжүүлснээр үүсэх үүргүүдийг тодорхой болгох, баталгаажуулах үе шатны үйл ажиллагаа нь дараах нэгдсэн ойлголтуудыг оролцогч талуудын дунд бий болгох, түүнийг баталгаажуулахад чиглэнэ.**
 - А. Ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан иргэн/байгууллагын удирдах албан тушаалтнуудыг ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагааны зорилго, нийгэмд өгөөжтэй олборлох үйлдвэрийн зарчим, хүлээх үүргүүдийн талаар цогц сургалтад хамруулах
 - В. Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийг авсанаар үүсэх үүргүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, мэргэжил, санхүү, эд хөрөнгийн нөөцийг бүрдүүлэх нөхцөл, болзлуудтай танилцуулж хүлээн зөвшөөрч байгааг нь илэрхийлсэн баталгааг гаргуулах
 - С. Энэхүү баталгааны загварыг Засгийн газраас баталж мөрдүүлнэ.

- D. Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрөл олгосныг гэрчлэх баримт/гэрчилгээг албан ёсоор олгох
- E. Ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийн тухай олон нийтэд мэдээлэх
- F. Тухайн тусгай зөвшөөрлийг улсын бүртгэлд бүртгэж үүргийн гүйцэтгэлийн бүртгэлийг үүсгэх зэрэг болно.

Дээрх 3 шаттай тусгай зөвшөөрлийн тогтолцооны ерөнхий санааг нарийвчлан үүрэг/үйлдлийн хэмжээнд задалж хооронд нь уялдуулах, ашигт малтмалын нөөцийг хайх тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа, тусгай зөвшөөрлөөр олгох талбайн хэмжээ, тусгай зөвшөөрлийн жил бүрийн төлбөр зэрэг бусад шийдлүүдтэй болон Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох үйл ажиллагааг зохицуулдаг бусад хуулиудаар тогтоосон үүргүүдтэй уялдуулах зайлшгүй шаардлагатай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Хууль эрх зүйн баримт бичгүүд

1. Агаарын тухай хууль, (2012)
2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, (2001)
3. Ашигт малтмалын тухай хууль, (2006)
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, (2012)
5. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, (1994)
6. Газрын тухай хууль, (2002)
7. Газрын хэвлийн тухай хууль, (1988)
8. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай, (2009)
9. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, (2009)
10. Монгол Улсын Үндсэн хууль, (1992)
11. Монгол улсын Ашигт малтмалын хуулиуд, (1910-2010, 2010)
12. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, (2011)
13. Ойн тухай хууль, (2012)
14. Төрийн болон албаны нууцын тухай хууль, (2016)
15. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, (2014)
16. Усны тухай хууль, (2012)
17. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, (2001)
18. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай, (2020)
19. Хөрөнгө оруулалтын тухай хууль, (2013)

Төрөөс баримтлах бодлогууд

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай, (2020)
2. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (2014-2025) батлах тухай, (2014)
3. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай, (2015)

Тогтоол, дүрэм, журмууд

1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам, (2017)

2. Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах, журам, (2018)
3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын "Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам батлах тухай" 2018 оны А\19 дугаар тушаал, (2018)
4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын "Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам батлах тухай" 2018 оны А\20 дугаар тушаал, (2018)
5. Үндэсний геомэдээллийн сан хөтөлбөр батлах тухай, (2019)
6. Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журам, Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам, (2017)
7. Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам батлах тухай", (2012)

Ном зүй

1. Б.Чимид. (2017). *Үндсэн хуулийн үзэл баримтлал*. Улаанбаатар.
2. Д.Бадарч, Б. (2014). *Системийн сэтгэлгээ*. Улаанбаатар.
3. М.Литвак, Н. Т. (2019). *Учир шалтгааны ухаан ба амьдрал*. Улаанбаатар.
4. Б.Чимид. (2004 он). *Үндсэн хуулийн үзэл баримтлал*. УБ: Чимид сан.
5. Прист, Г. (2019 он). *Логик*. УБ: Монгол эрх, Непко паблишинг.
6. С.Цэдэндорж, Д. М. (2003 он). *Уул уурхайн Монгол, Орос, Англи, Герман толь*. УБ.
7. *Монгол улсын Ашигт малтмалын хуулиуд 1910-2010*. (2010 он). УБ: Уул уурхайн эрх зүй судлалын хүрээлэн ТББ.
8. Добэлли, Р. (2020 он). *Цэгцтэй сэтгэх урлаг*. УБ: Непко паблишинг.
9. *Буддын шашины Шинжлэх ухаан ба үзэл онолын хураангуй*. (2016 оны). УБ: Гандан Повран.
10. К.Рой, Р. (2019 он). *Төрийн захиргаа*. УБ: Непко паблишинг.

Цахим хуудас

1. *Analysis of results*. (n.d.). Retrieved from Australian Bureau of Statistics: <https://www.abs.gov.au/statistics/economy/national-accounts/australian-national-accounts-state-accounts/latest-release#victoria>
2. Annual, F. I. (2020). SURVEY OF MINING COMPANIES 2020.
3. *Bidding on Crown Public Offering Parcels*. (n.d.). Retrieved from Saskatchewan: <https://www.saskatchewan.ca/business/agriculture-natural-resources-and-industry/oil-and-gas/crown-land-sales-dispositions-and-tenure/public-offerings/bidding-on-crown-public-offering-parcels>
4. *Canada one of only 5 universal healthcare countries that fails to pay hospitals based on actual patient services*. (n.d.). Retrieved from Fraser Institute: <https://www.fraserinstitute.org/>
5. *Canadian Mineral Exploration Information Bulletin*. (2018, March 16). Retrieved from Government of Canada: <https://www.nrcan.gc.ca/science-data/science-research/earth-sciences/earth-sciences-resources/earth-sciences-federal-programs/canadian-mineral-exploration-information-bulletin/17762>
6. *European Bank for Reconstruction and Development (EBRD)*. (n.d.). Retrieved from Bankwatch Network: https://bankwatch.org/ebrd?gclid=Cj0KCQjw1a6EBhC0ARIsAOiTkREqOyW_k2_wbj_nolDffNyz83d40q7fCZKYSMD05XSi5DeN0Qc_vdgaAoOhEALw_wcB

7. *Finland becomes most attractive jurisdiction for mining investment.* (n.d.). Retrieved from Mining: <https://miningglobe.com/supply-chain-and-operations/finland-becomes-most-attractive-jurisdiction-mining-investment>
8. MacMillan, K. A.-B. (2020, September 15). *Canada: Mining Laws & Regulations 2021.* Retrieved from Mondaq: <https://www.mondaq.com/canada/mining/984932/mining-laws-regulations-2021>
9. *Mineral Exploration and Mining.* (n.d.). Retrieved from Saskatchewan: <https://www.saskatchewan.ca/business/agriculture-natural-resources-and-industry/mineral-exploration-and-mining>
10. *Minerals and Mining .* (n.d.). Retrieved from Government of Western Australia Department of Mines, Industry, Regulation and Safety: <http://www.dmp.wa.gov.au/Minerals/How-do-I-Minerals-8044.aspx>
11. *Mining & Minerals.* (2019, October 18). Retrieved from Government of Canada: <https://www.nrcan.gc.ca/maps-tools-publications/tools/geodetic-reference-systems/mining-minerals/16878>
12. *Mining Act 1978.* (n.d.). Retrieved from Government of Western Australia Department of Justice Parliamentary Counsel's office: https://www.legislation.wa.gov.au/legislation/statutes.nsf/main_mrtitle_604_homepage.html
13. *Mining Laws and Regulation.* (n.d.). Retrieved from IGLG: <https://iclg.com/practice-areas/mining-laws-and-regulations/canada>
14. *Saskatchewan Announces First Subsurface Mineral Rights Public Offering Schedule.* (2018, June 29). Retrieved from Saskatchewan: <https://www.saskatchewan.ca/government/news-and-media/2018/june/29/subsurface-mineral-rights>
15. *The Atlas of Canada - Minerals and Mining.* (2021, 01 26). Retrieved from Government of Canada : <https://atlas.gc.ca/mins/en/index.html>
16. *The Prospectors & Developers Association of Canada.* (n.d.). Retrieved from <https://www.pdac.ca/about-pdac>
17. *Towards Sustainable Mining.* (n.d.). Retrieved from The Mining Association of Canada: <https://mining.ca/towards-sustainable-mining/>
18. *Закон "О недрах".* (n.d.). Retrieved from ИНТЕЛЛЕКТУАЛЬНАЯ: <http://base.garant.ru/10104313/#friends>
19. *ПОЛОЖЕНИЕ О ПОРЯДКЕ ЛИЦЕНЗИРОВАНИЯ ПОЛЬЗОВАНИЯ НЕДРАМИ.* (2016, 5 4). Retrieved from Консультант Плюс: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_852/e6eb88606fa78338ffe171a5841f25b33d3183d7/
20. *Правительство поддержало переход на электронное лицензирование бизнеса.* (n.d.). Retrieved from РИА Новости: <https://ria.ru/20210430/foto-1730514944.html>
21. *ПРАВИТЕЛЬСТВО РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ.* (2012, 5 3). Retrieved from Электронный фонд: <https://docs.cntd.ru/document/902344986>
22. *Система выбора претендентов на получение лицензии.* (2016, 5 4). Retrieved from Консультант Плюс: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_852/b71fe76299bd17a1f4f45b93bb15505555fd12ce/
23. *Условия и порядок проведения аукционов.* (n.d.). Retrieved from Роснедра: <https://pfo.rosnedra.gov.ru/page/195.html>

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Хөрөнгө оруулагчийн зүгээс тавих шаардлага, нөхцөл, болзол

№	Хөрөнгө оруулагчийн зүгээс тавих шаардлага, нөхцөл, болзол	Ашигт малтмалын нөөцийг хайх, тогтоох үйл ажиллагааны онцлог хэв шинжүүдийн тайлбар
---	--	---

1	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь түүгээр зөвшөөрөгдсөн ашигт малтмалын үйл ажиллагааг эрхлэх цорын ганц бөгөөд онцгой эрхтэй байх ёстой.	Тодорхой цаг хугацаа, санхүү, мэдлэг, хөдөлмөрийн нөөц зарцуулдаг тул эрсдэлийг бууруулах үүднээс хөрөнгө оруулалтын орчин нөхцлийн суурь баталгаа болгож тухайн тусгай зөвшөөрлийн талбайд түүгээр зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулах цор ганц бөгөөд онцгой эрх эдлэх.
2	Лицензийг эхний өргөдөл гаргагчид өгөх ёстой. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийг хадгалахын тулд зөвхөн тухайн жилийн зардлын ерөнхий шаардлагыг хангасан байх ёстой.	Тодорхой цаг хугацаа, санхүү, мэдлэг, хөдөлмөрийн нөөц зарцуулсны дүнд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл авах хэмжүүр нь ил тод, шударга байх.
3	Тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгох нь хөрөнгө оруулагчдад саад болж болзошгүй юм.	Худалдаж авч буй эрхэд агуулагдаж байгаа үнэ цэнэ тодорхойгүй байна.
4	Тусгай зөвшөөрөл нь түүний талбайн хэмжээнд байгаа бүх ашигт малтмалынх байх ёстой.	Ашигт малтмал нь зонхилох тохиолдолд олон химийн элементүүдээс бүрддэг тул түүнийг хайх, олборлох үйл ажиллагааг нэг хуулийн зохицуулалтаар явуулах сонирхолтой байдаг.
5	Хөрөнгө оруулагч нь үйл ажиллагаагаа удирдах бүрэн хяналтаа чөлөөтэй хадгалж үлдэхийг хязгаарлаж, өөрийн оруулсан хөрөнгийн 50 % ба түүнээс бага хувийг эзэмшихийг хязгаарлахгүй байх ёстой.	Тодорхой цаг хугацаа, санхүү, мэдлэг, хөдөлмөрийн нөөц зарцуулдаг бөгөөд мөн эрсдэл маш өндөр буюу ашигт малтмалын орд илрүүлэх магадлал маш бага /1:1000/ байдаг тул ашигт малтмалын орд илрүүлсэн тохиолдолд өөрийн зарцуулсан зардлыг нөхөх, улмаар ашиг орлого олох хэмжээнд тухай ордын хувь хэмжээг эзэмших.
6	Тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд эрхийнхээ бүрэн буюу зарим хэсгийг чөлөөтэй шилжүүлэхийг зөвшөөрнө.	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн тодорхой цаг хугацаа, санхүү, мэдлэг, хөдөлмөрийн нөөцийг зарцуулж тодорхой өгөгдөл, мэдлэг буюу өөрийн өмчийг бүтээсэн тул түүнийгээ чөлөөтэй захиран зарцуулдаг байх.
7	Хууль тогтоомж хэрэглэхдээ ил тод байх ёстой бөгөөд сайдын болон захиргааны үзэмж, удирдамж, зан заншил, хязгаарлалтыг ашиглах нь хамгийн бага байх ёстой.	Тодорхой цаг хугацаа, санхүү, мэдлэг, хөдөлмөрийн нөөцийг зарцуулж, өндөр эрсдэл хүлээж байдаг тул хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын тогтвортой орчинтой байхыг чухалчилдаг.
8	Хууль тогтоомж нь хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид бүрэн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад шаардлагатай бол тусгай зөвшөөрлийн хугацааг боломжийн хугацаагаар сунгах боломжийг олгох ёстой.	Урьдчилан төлөвлөх боломжгүй эрсдэл үүсдэг тул зарцуулсан нөөцийг хүндэтгэх, оруулсан хөрөнгө оруулалтыг хамгаалах зорилгоор боломжит хугацаагаар эрхийг нь сунгадаг байх.
9	Ашигт малтмалын хайгуул нь зөвхөн газар ашиглах түр зуурын хэлбэр гэдгийг хүлээн зөвшөөрч, нэмэлт зохицуулалтын зөвшөөрөл авах шаардлагагүйгээр тусгай зөвшөөрөл	Тухайн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн газрын гадаргыг зөвхөн ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагааны хүрээнд эзэмшиж буй тул ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөс тусдаа зөвшөөрөл авдаггүй байх.

	<p>эзэмшигчид тусгай зөвшөөрлийн талбай руу нэвтрэх эрхийг зөвшөөрөх ёстой.</p>	
10	<p>Тусгай зөвшөөрөл эзэмшигчид албан ёсоор мэдэгдэж, учир шалтгааны гэм бурууг арилгах, яагаад хураах, цуцлахгүй байх үндэслэлтэй шалтгааныг харуулах хангалттай боломж, хугацааг санал болгохгүйгээр аливаа тусгай зөвшөөрлийг цуцлах ёсгүй.</p>	<p>Тодорхой цаг хугацаа, санхүү, мэдлэг, хөдөлмөрийн нөөц зарцуулдаг тул ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг үндэслэлгүйгээр цуцлахгүй байх.</p>

№	Оролцогч талууд	Тухайн оролцогч тал, түүний бүрдүүлэгч иргэдийн хүртэх үр шим	Тухайн оролцогч талын хүлээх үүрэг, хариуцлага, дагаж мөрдөх хэм хэмжээ	Нийгмийн өгөөж / тухайн үйл ажиллагааны онцлогоос хамаарч бусад оролцогчдод бий болгох харьцангуй давуу тал /
1	Тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгжийн эзэмшигч иргэн	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар баталгаажсан эрхээ эдэлнэ.</p> <p>-5.2.Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.</p> <p>-7.2.Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн.</p> <p>-16.1.3 Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх.</p> <p>-16.1.4 Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хувийн аж ахуй эрхлэх эрх.</p> <p>-16.1.8 Шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй.</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>-17.1.1 Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх,</p> <p>-17.1.2 Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх,</p> <p>-17.1.3 Хуулиар ногдуулсан албан татвар төлөх,</p> <p>-17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, байгаль орчноо хамгаалах,</p> <p>-19.3 Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.</p>	<p>Монгол Улсын иргэдийн хүртэх өгөөж:</p> <p>-Тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгжийн эзэмшигч иргэн нь Үндсэн хуулийн 17.1.3 дугаар зүйлд заасан татвар төлөх үүргээ биелүүлснээр Монгол Улсын иргэдийн үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан эрх, эрх чөлөө хангахад шаардлагатай орчныг бүрдүүлэхэд санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.</p> <p>Шууд тогтвортой хамааралтай оролцогчдын хүртэх өгөөж:</p> <p>1. Ажилтан: Үндсэн хуулийн 16.1.4-т заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, 16.1.8-д заасан шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхийг хэрэгжүүлэхэд шаардагдах ажлын байрыг бий болгоно.</p> <p>2. Ханган нийлүүлэгч: Үндсэн хуулийн 16.1.8 соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх</p> <p>16.1.3 хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах</p> <p>16.1.4 ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэмэлт зах зээлийг бий болгож худалдан авалт хийнэ.</p>

				<p>3. Төр: Үндсэн хуулийн 5.4-т заасан Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна гэсэн үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гадаадын валютын нэмэлт эх үүсвэрийг бий болгоно.</p> <p>4. Үндэсний баялгийн сан: Үндсэн хуулийн 6.2.2-т заасан Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ гэж заасныг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хэлбэрээр төвлөрүүлнэ.</p> <p>5. Хөрөнгө оруулагч: Үндсэн хуулийн 16.1.3-т заасан хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрхээ хэрэгжүүлэх харьцангуй давуу талтай боломжийг бий болгоно.</p>
2	Хөрөнгө оруулагч	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар баталгаажсан эрхээ эдэлнэ.</p> <p>-16.1.3 Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх.</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>-17.1.1 Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх,</p> <p>-17.1.2 Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх,</p> <p>-17.1.3 Хуулиар ногдуулсан албан татвар төлөх,</p> <p>-17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, байгаль орчноо хамгаалах,</p>	<p>Монгол Улсын иргэдийн хүртэх өгөөж:</p> <p>Тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгжийн эзэмшигч иргэн нь үндсэн хуулийн 17.1.3 дугаар зүйлд заасан татвар төлөх үүргээ биелүүлснээр Монгол Улсын иргэдийн үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан дараах эрх, эрх чөлөө хангахад шаардлагатай орчныг бүрдүүлэхэд санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх хувь нэмрээ оруулдаг.</p>

			-19.3 Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.	
3	Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн ажилтнууд	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар баталгаажсан эрхээ эдэлнэ.</p> <p>-16.4 ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хувийн аж ахуй эрхлэх эрх.</p> <p>-16.5 өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрх;</p> <p>-16.8-д заасан шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхийн хэрэгжилт хангагдана.</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>-17.1.1 Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх,</p> <p>-17.1.2 Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх,</p> <p>-17.1.3 Хуулиар ногдуулсан албан татвар төлөх,</p> <p>-17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах,</p> <p>-19.3 Хүн эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн үүргүүдийг хүлээнэ.</p>	<p>Монгол Улсын иргэдийн хүртэх өгөөж:</p> <p>Тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгжийн эзэмшигч иргэн нь Үндсэн хуулийн 17.1.3 дугаар зүйлд заасан татвар төлөх үүргээ биелүүлснээр Монгол Улсын иргэдийн үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан эрх, эрх чөлөө хангахад шаардлагатай орчныг бүрдүүлэхэд санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.</p> <p>Шууд хамааралтай оролцогчдын хүртэх өгөөж:</p> <p>Тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн буюу ажил олгогч:</p> <p>Үндсэн хуулийн 16.1.3 Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх. 16.1.8 шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхийг хэрэгжүүлэхэд мэдлэгийн нөөц болон бүтээмжээр хувь нэмрээ оруулна.</p> <p>Гэр бүлдээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох эрхээ эдлэх боломжийг бүрдүүлнэ.</p>

4	Орон нутгийн, төрөлжсөн, дагнасан, гадаадын ханган нийлүүлэгч / банк санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, ханган нийлүүлэгч /	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар баталгаажсан эрхээ эдэлнэ.</p> <p>-16.3 хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх.</p> <p>-16.4 ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хувийн аж ахуй эрхлэх эрх.</p> <p>-16.8 бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхүүд хангагдана.</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>-17.1.1 Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх,</p> <p>-17.1.2 Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх,</p> <p>-17.1.3 Хуулиар ногдуулсан албан татвар төлөх,</p> <p>-17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, байгаль орчноо хамгаалах,</p> <p>-19.3 Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн үүргүүдийг хүлээнэ.</p>	<p>Монгол Улсын нийт иргэдийн хүртэх өгөөж:</p> <p>Орон нутгийн, төрөлжсөн, дагнасан, гадаадын ханган нийлүүлэгч нь Үндсэн хуулийн 17.1.3 дугаар зүйлд заасан татвар төлөх үүргээ биелүүлснээр Монгол Улсын иргэдийн үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан эрх, эрх чөлөө хангахад шаардлагатай орчныг бүрдүүлэхэд санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.</p> <p>Шууд хамааралтай иргэдийн хүртэх өгөөж:</p> <p>Үндсэн хуульд заасан дараах эрхүүдийг эдлэхэд шаардлагатай орчныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулна.</p> <p>16.2, 16.3, 16.4, 16.6, 16.8, 16.18 Тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-д хүртэх өгөөж:</p> <p>16.1.3 Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөхөд чанартай бараа, ажил, үйлчилгээгээр ханган нийлүүлж хувь нэмэр оруулна</p>
5	Нийтлэг байгалийн нөөц ашигладаг / газар, ус, агаар / орон нутгийн иргэд	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар баталгаажсан эрхээ эдэлнэ.</p> <p>-6.2 Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх,</p> <p>-16.1.2 эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах</p> <p>-16.1.14 эрх, эрх чөлөө</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>-17.1.1 Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх,</p> <p>-17.1.2 Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх,</p> <p>-17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах,</p> <p>-19.3 Хүн эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн үүргүүдийг хүлээнэ.</p>	<p>Шууд хамааралтай оролцогчдын хүртэх өгөөж:</p> <p>1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн: Үндсэн хуулийн 17.2 байгаль орчноо хамгаалах үүргийг хэрэгжүүлэхэд орон нутгийн иргэд, олон нийтийн хяналтыг бий болгоно.</p> <p>2. Төр: Үндсэн хуулийн 7.1 Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж, үзэл бодлоо илэрхийлж оролцсоноор олон нийтийн хяналтыг бий болгоно.</p>

		<p>зөрчигдсөн гэж үзвэл эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, эрхүүдийг баталгаажуулан эдлэх давуу тал өөрийн үүргүүдийг биелүүлснээр харьцангуй давуу тал бий болно.</p>		
6	Байгаль орчныг хамгаалах ТББ	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар баталгаажсан эрхээ эдэлнэ.</p> <p>-6.2 Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх,</p> <p>-16.1.2 эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах,</p> <p>-16.1.8 бүтээл туурвих, үр шимийг хүртэх,</p> <p>-16.1.10 нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс олон нийтийн байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх,</p> <p>-16.1.14 эрх, эрх чөлөө зөрчигдсөн гэж үзвэл эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, эрхүүдийг баталгаажуулан эдэлснээр байгаль орчны сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>-17.1.1 Үндсэн хууль бусад хуулиудыг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх,</p> <p>-17.1.2 хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх,</p> <p>-17.1.3 Хуулиар ногдуулсан албан татвар төлөх,</p> <p>-17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах,</p> <p>-19.3 эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн үүргүүдийг хүлээнэ.</p>	<p>Шууд хамааралтай оролцогчдын хүртэх өгөөж:</p> <p>1. Иргэд: Үндсэн хуулийн 6.2 Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх, 16.1.2 эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах</p> <p>2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн: Үндсэн хуулийн 17.2 байгаль орчноо хамгаалах үүргийг хэрэгжүүлэхэд орон нутгийн иргэд, олон нийтийн хяналтыг бий болгоно.</p> <p>3. Төр: Үндсэн хуулийн 7.1 Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж, үзэл бодлоо илэрхийлж оролцсоноор олон нийтийн хяналтыг бий болгоно.</p>

		талаар үзэл бодлоо илэрхийлж, эрүүл, аюулгүй орчинд амьдрах харьцангуй давуу тал бий болно.		
7	Ажилтнуудын эрх ашгийг хамгаалах ТББ	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар баталгаажсан эрхээ эдэлнэ.</p> <p>-16.1.10 нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс олон нийтийн байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх,</p> <p>-16.1.4 ажил мэргэжлээ сонгох,</p> <p>-16.1.8 бүтээл туурвих, үр шимийг хүртэх, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах,</p> <p>-16.1.14 эрх, эрх чөлөө зөрчигдсөн гэж үзвэл эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах,</p> <p>-16.1.16 итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхүүдээр хөдөлмөрийн харилцаан дахь харьцангуй давуу тал бий болно.</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>-17.1.1 Үндсэн хууль бусад хуулиудыг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх,</p> <p>-17.1.2 хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх,</p> <p>-17.1.3 Хуулиар ногдуулсан албан татвар төлөх,</p> <p>-17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах,</p> <p>-19.3 эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн үүргүүдийг хүлээнэ.</p>	<p>Шууд хамааралтай оролцогчдын хүртэх өгөөж:</p> <p>1. Ажилтан: Үндсэн хуулийн 14.2 Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.</p> <p>16.1.4 ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;</p> <p>16.1.5 өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;</p> <p>16.1.11 улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй.</p> <p>16.12 төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхүүдийг баталгаажуулахад үзэл бодол, ашиг сонирхолоо нэгтгэж хувь нэмрээ оруулна.</p> <p>2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн: Үндсэн хуулийн 16.1.3</p>

				<p>хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, 16.1.8 шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхээ баталгаажуулах орчин, нөхцлийг бүрдүүлэхэд үзэл бодол, ашиг сонирхолоо нэгтгэж хувь нэмрээ оруулна.</p> <p>3. Төр: Үндсэн хуулийн 19.1 Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнөх хариуцах заалтыг хэрэгжүүлэхэд үзэл бодлоо илэрхийлж, хөдөлмөрийн харилцааг зохицуулахад хувь нэмрээ оруулж оролцоно.</p>
8	<p>Бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллага ТББ</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар баталгаажсан эрхээ эдэлнэ.</p> <p>-16.1.4 ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй.</p> <p>-16.1.10 нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.</p> <p>-16.8 соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй.</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>-17.1.1 Үндсэн хууль бусад хуулиудыг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх,</p> <p>-17.1.2 хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх,</p> <p>-17.2 Хөдөлмөрлөх,</p> <p>-19.3 эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн үүргүүдийг хүлээнэ.</p>	<p>Шууд хамааралтай оролцогчдын хүртэх өгөөж:</p> <p>16.8 соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй.</p> <p>Нэгдсэн дуу хоолой болно.</p>

9	Улс төрийн намууд	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар баталгаажсан эрхээ эдэлнэ.</p> <p>-16.4 ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй.</p> <p>-16.9 шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй.</p> <p>Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй.</p> <p>-16.10 нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.</p> <p>-16.8 соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй.</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>Нийтлэг үүрэг:</p> <p>-17.1.1 Үндсэн хууль бусад хуулиудыг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх,</p> <p>-17.1.2 хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх,</p> <p>-17.1.3 Хуулиар ногдуулсан албан татвар төлөх,</p> <p>-17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах,</p> <p>-19.3 эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн үүргүүдийг хүлээнэ.</p> <p>Тусгайлсан үүрэг:</p> <p>-Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхүүдийг баталгаатай эдлүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.</p> <p>-19.1 нэмэлт 1- Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.</p> <p>-19.1 нэмэлт 3- Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна.</p>	<p>Нийт иргэдийн хүртэх өгөөж:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үндсэн хуулийн 14 дугаар зүйл, 16 дүгээр зүйл, 17 дугаар зүйл, 19 дүгээр зүйлд баталгаажуулж өгсөн эрхийг нь хэрэгжүүлэх арга замуудыг судалж боловсруулахад оролцох боломж бүрдэнэ. 2. Үндсэн хуулийн 19.1 дүгээр зүйлд заасан үүргийг хэрэгжүүлэх бодлогын олон хувилбартай болж иргэд сонголт хийх нөхцөл бүрдэнэ. 3. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд заасан үүргээ хэрэгжүүлэх эрхийг авсан улс төрийн намуудын үйл ажиллагаанд хяналт тавих нөхцөл бүрдэнэ.
---	-------------------	--	--	---

10	Ерөнхийлөгч	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар баталгаажсан эрхээ эдэлнэ.</p> <p>-16.4 ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй.</p> <p>-16.8 соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй</p> <p>-16.9 шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй.</p> <p>Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй.</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>Нийтлэг үүрэг:</p> <p>-17.1.1 Үндсэн хууль бусад хуулиудыг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх,</p> <p>-17.1.2 хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх,</p> <p>-17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах,</p> <p>-19.3 эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн үүргүүдийг хүлээнэ.</p> <p>Тусгайлсан үүрэг:</p> <p>-11.1 Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах,</p> <p>-19.1 төрөөс хүний эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг гүйцэтгэх</p> <p>-30.1 Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.</p> <p>-32.2.2 Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая” хэмээн өргөсөн тангаргаа биелүүлж оролцоно.</p>	<p>Нийт иргэдийн хүртэх өгөөж: Ерөнхийлөгч Үндсэн хуулиар үндэсний эв нэгдэл, нийгмийн дэг журмыг хангах үүргээ хэрэгжүүлсэнээр иргэд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан эрх, эрх чөлөөгөө эдлэхэд шаардлагатай тогтвортой орчин бүрдэнэ.</p>
----	-------------	---	--	--

11	Хууль тогтоох байгууллага /УИХ/	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар баталгаажсан эрхээ эдэлнэ.</p> <p>-16.1.4 Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй.</p> <p>-16.1.9 Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй.</p> <p>Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй.</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>-19.1 Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.</p> <p>-16 дугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх эрхийг хангах.</p> <p>-20.1 Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.</p> <p>Үндсэн хуулиар тусгайлсан ногдуулсан үүрэг: 5.2.Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.</p>	<p>Монгол Улсын иргэдийн хүртэх өгөөж: Үндсэн хуулийн 16-т заасан иргэний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх хууль эрх зүйн үндэслэлийг бүрдүүлнэ.</p>
12	Засгийн газар	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар баталгаажсан эрхээ эдэлнэ.</p> <p>-16.1.4 Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хувийн аж ахуй эрхлэх эрх.</p> <p>-16.1.9 Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй.</p> <p>Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй.</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>-17. 1.Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараахь үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ: -17.1.1 Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; -17.1.2 хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх; -17.1.3 хуулиар ногдуулсан албан татвар төлөх; -17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо</p>	<p>Монгол Улсын иргэдийн хүртэх өгөөж: Иргэд Үндсэн хуулийн 16-т заасан иргэний эрх, эрх чөлөөг эдлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгмийн болон бусад баталгаатай орчин нөхцөлтэй болно.</p>

			<p>хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.</p> <p>-19.3 3.Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.</p> <p>Үндсэн хуулиар УИХ-д тусгайлсан ноогдуулсан үүрэг:</p> <p>-5.4 Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.</p> <p>-19.1 Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.</p> <p>-38.1 Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.</p> <p>-38.2 Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>	
13	Үндсэн хуулийн цэц	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар баталгаажсан эрхээ эдэлнэ.</p> <p>-16.1.4 Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хувийн аж ахуй эрхлэх эрх.</p> <p>-16.1.8 Соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>Нийтлэг үүрэг:</p> <p>-17.1.1 Үндсэн хууль бусад хуулиудыг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх,</p> <p>-17.1.2 хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх,</p> <p>-17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах,</p> <p>-19.3 эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэсэн үүргүүдийг</p>	<p>Монгол Улсын иргэдийн хүртэх өгөөж:</p> <p>Иргэд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрхээ эдлэхэд саад, тотгор учруулж буй хуулиудын заалтыг хөндлөнгийн хяналтын институтээр магадлуулах боломжтой болно.</p>

			<p>хүлээнэ.</p> <p>Тусгайлсан үүрэг:</p> <p>1. Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1-т заасан Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа үүргийг хэрэгжүүлэх.</p> <p>2. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасан үүргийг хэрэгжүүлэх.</p>	
14	Шүүх байгууллага	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>Нийтлэг үүрэг:</p> <p>-17.1.1 Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх</p> <p>-17.1.2 Хүний нэр төр, алдар хүнд, эрх хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх</p> <p>-17.1.3 Хуулиар ногдуулсан албан татвар төлөх</p> <p>-17.1.4 Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах</p> <p>-17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн</p> <p>-19.3 Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй</p> <p>Үндсэн хуулийн тусгайлсан үүргүүд:</p> <p>-19.1 Төрөөс хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх</p> <p>-47.1 Монгол Улсын шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж оролцоно.</p>	<p>Монгол Улсын нийт иргэдийн хүртэх өгөөж:</p> <p>Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдсөн тохиолдолд хянан шийдвэрлүүлэх, зөрчигдсөн эрхээ сэргээн эдэлнэ.</p>	

15	Прокурор ын байгуулла га	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар баталгаажсан эрхээ эдэлнэ.</p> <p>-16.4 ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй</p> <p>-16.8 соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>Нийтлэг үүргүүд:</p> <p>-17.1.1 Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх</p> <p>-17.1.2 Хүний нэр төр, алдар хүнд, эрх хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх</p> <p>-17.1.3 Хуулиар ногдуулсан албан татвар төлөх</p> <p>-17.1.4 Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах</p> <p>-17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн</p> <p>-19.3 Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй</p> <p>Тусгайлсан үүргүүд:</p> <p>-19.1 төрөөс хүний эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг гүйцэтгэх</p> <p>-56.1 Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.</p>	<p>Монгол Улсын нийт иргэдийн хүртэх өгөөж:</p> <p>Прокурор 19.1, 56.1-д заасан үүргүүдээ хэрэгжүүлснээр иргэд Үндсэн хуулийн 16.12, 16.13 дугаар заалтад заасан эрхүүдийг баталгаатай эдлэх орчин бүрдэнэ.</p>
----	-----------------------------------	---	---	---

16	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар баталгаажсан эрхээ эдэлнэ.</p> <p>-16.4 ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй</p> <p>-16.9 шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй.</p> <p>Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй.</p>	<p>Үндсэн хуулийн дараах заалтуудаар тогтоосон үүргүүдийг сахин биелүүлнэ.</p> <p>Нийтлэг үүрэг:</p> <p>-17.1.1 Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх</p> <p>-17.1.2 Хүний нэр төр, алдар хүнд, эрх хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх</p> <p>-17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн</p> <p>-19.3 Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй</p> <p>Тусгайлсан үүргүүд:</p> <p>-19.1 төрөөс хүний эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх,</p> <p>-59.1 Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжүүлж,</p> <p>-62.1 Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.</p>	<p>Монгол Улсын нийт иргэдийн хүртэх өгөөж:</p> <p>Тухайн нутаг дэвсгэр дээр ажиллаж, амьдарч байгаа иргэд болон ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн Үндсэн хуулийн 16-т заасан иргэний эрх, эрх чөлөөг эдлэхэд зайлшгүй шаардлагатай тухайн орон нутгийн онцлогт тохирсон, зохицсон эдийн засаг, нийгмийн болон бусад баталгаатай орчин нөхцөлтэй болно.</p>
----	--	---	---	--

Хавсралт 3. Монгол Улсын Үндсэн хуулийн тулгуур зарчмуудын хоорондын учир шалтгааны шүтэлцээ

1. Хамаарагч тулгуур заалт	2. Хамааруулагч тулгуур заалт	3. Тулгуур зарчмуудын харилцан хамаарал	4. Тулгуур зарчмуудын ёс зүйн код	5. Харилцан хамааралтай зарчмуудын шүтэлцээний мөрдлөг.
<p>16 дугаар зүйл. Монгол улсын иргэн үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ.</p>	<p>17 дугаар зүйл 17.1 Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ 17.1.1 Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; 17.1.2 Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх; 17.1.3 Хуулиар ногдуулсан албан татвар төлөх; 17.1.4 Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах. 17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.</p>	<p>1. Иргэн бүр 16 дугаар зүйлд заасан эрхээ эдлэхэд шаардлагатай баталгааг бүрдүүлэхэд үүрэг хүлээж Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх ёстой. 2. Иргэн бүр 16 дугаар зүйлд заасан эрхээ эдлэхэд шаардлагатай баталгааг бүрдүүлэхэд үүрэг хүлээж бусад хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыгсхүндэтгэх ёстой. 3. Иргэн бүр 16 дугаар зүйлд заасан эрхээ эдлэхэд шаардлагатай баталгааг бүрдүүлэхэд үүрэг хүлээж хуулиар ногдуулсан албан татвар төлөх ёстой. 4. Иргэн бүр 16 дугаар зүйлд заасан эрхээ эдлэхэд шаардлагатай баталгааг бүрдүүлэхэд үүрэг хүлээж эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах ёстой. 5. Иргэн бүр 16 дугаар зүйлд заасан эрхээ эдлэхэд шаардлагатай баталгааг бүрдүүлэхэд үүрэг хүлээж хөдөлмөрлөх ёстой. 6. Иргэн бүр 16 дугаар зүйлд заасан эрхээ эдлэхэд шаардлагатай баталгааг бүрдүүлэхэд үүрэг хүлээж эрүүл мэндээ хамгаалах ёстой. 7. Иргэн бүр 16 дугаар зүйлд заасан эрхээ эдлэхэд</p>	<p>1. ҮХ16.1-17.1.1 2. ҮХ16.1-17.1.2 3. ҮХ16.1-17.1.3 4. ҮХ16.1-17.1.4 5. ҮХ16.1-17.2.1 6. ҮХ16.1-17.2.2 7. ҮХ16.1-17.2.3 8. ҮХ16.1-17.2.4 9. ҮХ16.1-17.2.5 Нийт 1152 шүтэлцээ</p>	<p>1.Иргэн бүр Үндсэн хууль, бусад хуулийн хүрээнд өөрийн эрхээ эдлэх баталгааг бүрдүүлж, суурь хэрэгцээгээ хангах ёстой. 2. Иргэн бүр бусад хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүйгээр өөрийн эрхээ эдлэх баталгааг бүрдүүлж, суурь хэрэгцээгээ хангах ёстой. 3. Иргэн бүр хуулиар ногдуулсан албан татвар төлж өөрийн эрхээ эдлэх баталгааг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах хангах ёстой. 4. Иргэн бүр хөдөлмөрлөж суурь хэрэгцээгээ хангах ёстой. 5. Иргэн бүр эрүүл мэндээ хамгаалж, эрхээ эдлэх суурь нөхцлийг бүрдүүлэх ёстой. 6. Иргэн бүр үр хүүхдээ өсгөн, хүмүүжүүлж, тэдний эрхээ эдлэх суурь орчин нөхцлийг бүрдүүлэх ёстой. 7. Иргэн бүр байгаль орчноо бохирдуулахгүй арга замаар эрхээ эдлэх ёстой.</p>

		<p>шаардлагатай баталгааг бүрдүүлэхэд үүрэг хүлээж ҮР ХҮҮХДЭЭ ӨСГӨН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ёстой.</p> <p>8. Иргэн бүр 16 дугаар зүйлд заасан эрхээ эдлэхэд шаардлагатай баталгааг бүрдүүлэхэд үүрэг хүлээж байгаль орчноо хамгаалах ёстой.</p>		
--	--	---	--	--

<p>16 дугаар зүйл. Монгол улсын иргэн үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ.</p>	<p>19.1 Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.</p>	<p>1. Төр нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан үндсэн эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах ёстой.</p> <p>2. Төр нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан үндсэн эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засгийн баталгааг бүрдүүлэх ёстой.</p> <p>3. Төр нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан үндсэн эрх, эрх чөлөөг хангахуйц нийгмийн баталгааг бүрдүүлэх ёстой.</p> <p>4. Төр нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан үндсэн эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх ёстой.</p> <p>5. Төр нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан үндсэн эрх, эрх чөлөөг хангахуйц бусад баталгааг бүрдүүлэх ёстой.</p> <p>6. Төр нь үүргээ гүйцэтгэхдээ хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх ёстой.</p> <p>7. Төр нь иргэний хөндөгдсөн эрх, эрх чөлөөг сэргээн эдлүүлэх ёстой.</p>	<p>1.YX16.1.1-19.1 2. YX16.1.2-19.1 3. YX16.1.3-19.1 4. YX16.1.4-19.1 5. YX16.1.5-19.1 6. YX16.1.6-19.1 7. YX16.1.7-19.1 8. YX16.1.8-19.1 9. YX16.1.9-19.1 10. YX16.1.10-19.1 11. YX16.1.11-19.1 12. YX16.1.12-19.1 13. YX16.1.13-19.1 14. YX16.1.14-19.1 15. YX16.1.15-19.1 16. YX16.1.16-19.1 17. YX16.1.17-19.1</p>	<p>1. Төр эдийн засгийн тааламжтай орчин нөхцлийг бүрдүүлснээр иргэний эрх, эрх чөлөөг баталгаажих ёстой.</p> <p>2. Төр нийгмийн баталгаатай орчин нөхцлийг бүрдүүлснээр иргэний эрх, эрх чөлөөг баталгаажих ёстой.</p> <p>3. Төр хууль зүйн баталгаатай орчин нөхцлийг бүрдүүлснээр иргэний эрх, эрх чөлөөг баталгаажих ёстой.</p> <p>4. Төр бусад орчин нөхцлийг бүрдүүлснээр иргэний эрх, эрх чөлөөг баталгаажих ёстой.</p> <p>5. Төр иргэний эрх, эрх чөлөөг зөрчихгүй орчин нөхцлийг бүрдүүлснээр иргэний эрх, эрх чөлөөг баталгаажих ёстой.</p> <p>6. Төр иргэний хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргээ биелүүлснээр иргэний эрх, эрх чөлөөг баталгаажих ёстой.</p>
---	--	--	--	---

			18. ҮХ16.1. 18-19.1 Нийт 864	
--	--	--	--	--

<p>17 дугаар зүйл 17.1 Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараахь үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ 17.1.1 Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; 17.1.2 Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх; 17.1.3 Хуулиар ногдуулсан албан татвар төлөх; 17.1.4 Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах. 17.2 Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль</p>	<p>19.1 Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.</p>	<p>1. Иргэн Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлснээр төрөөс хүний эрх эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх орчин нөхцөл бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах ёстой. 2. Иргэн хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэснээр төрөөс хүний эрх эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх орчин нөхцөл бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах ёстой. 3. Иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлснөөр төрөөс хүний эрх эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх орчин нөхцөл бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах ёстой. 4. Иргэн эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах үүргээ биелүүснээр төрөөс хүний эрх эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх орчин нөхцөл бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах ёстой. 5. Иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлснээр төрөөс хүний эрх эрх чөлөөг хангахуйц эдийн</p>	<p>1. Иргэн нь төрөөс тогтоосон хуулийг дагаж мөрдсөнөөр бусдын эрх ашгийг зөрчихгүйгээр өөрийн эрх, эрх чөлөөг эдлэх орчин нөхцөл бүрдэхэд хувь нэмрээ оруулах ёстой. 2. Иргэн бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэж, зөрчихгүй байх нөхцлийг төрөөс бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах ёстой. 3. Иргэн төрөөс хуулиар ногдуулсан албан татварыг төлснөөр бусдад өгөөж, өөрт үр шимийг хүртэх орчин нөхцөл бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах ёстой. 4. Иргэн бусдын эрх ашгийг зөрчихгүй, хөндөхгүйгээр хөдөлмөрлөж өөрийн болон бусдын эрх, эрх чөлөөг хангахуйц орчин нөхцлийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах ёстой. 5. Иргэн эрүүл мэндээ хамгаалж, эрүүл иргэн байж иргэний эрхээ эдлэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах ёстой. 6. Иргэн үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлж тэдний болон бусдын эрхээ эдлэх орчин нөхцөл бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах ёстой. 7. Иргэн бүр байгаль орчноо хамгаалж, өөрийн болон бусдын эрхээ эдлэх орчин нөхцөл бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах ёстой.</p>
---	--	---	--

<p>орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.</p>		<p>засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх орчин нөхцөл бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах ёстой.</p> <p>6. Иргэн эрүүл мэндээ хамгаалах үүргээ биелүүлснээр төрөөс хүний эрх эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх орчин нөхцөл бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах ёстой.</p> <p>7. Иргэн үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээ биелүүлснээр төрөөс хүний эрх эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх орчин нөхцөл бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах ёстой.</p> <p>8. Иргэн байгаль орчноо хамгаалах үүргээ биелүүлснээр төрөөс хүний эрх эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх орчин нөхцөл бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах ёстой.</p>	
--	--	--	--

Хавсралт 4. ОХУ-ын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох зохицуулалт

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХ ЗОХИЦУУЛАЛТ

ОХУ-ын нутаг дэвсгэр дэх уул уурхайн үйл ажиллагаа 1992 онд баталсан Газрын хэвлийн тухай хууль /2017 онд шинэчилсэн/, 2012 оны Байгалийн нөөцийн хил хязгаарыг тогтоох болон өөрчлөх, ашиглах тухай журам, Газрын хэвлийн баялгийг ашиглах тусгай зөвшөөрлийг зохицуулах журмаар тус тус зохицуулдаг.

ОХУ-ын уул уурхайн салбарын үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн эрх бүхий дараахь байгууллагууд байдаг. Байгалийн нөөц, экологийн яам (“Минприроды-Министерство природных ресурсов и экологии”) нь уул уурхайн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг удирдаж, уул уурхайн салбарыг зохицуулдаг агентлагууд болон бусад байгууллагуудын ажилд хяналт тавина.

1. Газрын хэвлийн ашиглалтын холбооны агентлаг ("Роснедра") нь газрын хэвлий ашиглах эрхийн улсын геологийн судалгаа, дуудлага худалдааг зохион байгуулж, газрын хэвлийд тусгай зөвшөөрөл олгож, хүчингүй болгож, улсын кадастр, геологийн мэдээллийн холбооны болон нутаг дэвсгэрийн санг хөтөлдөг.
2. Байгалийн менежментийн холбооны хяналтын алба ("Росприроднадзор") Газрын хэвлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн Газрын хэвлийн тусгай зөвшөөрлийн нөхцлийг дагаж мөрдөхөд хяналт тавьж, байгаль орчныг хамгаалах, газрын хэвлийг зохистой ашиглах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тогтмол хяналт шалгалт хийдэг.
3. Экологи, технологи, цөмийн хяналт шалгалтын холбооны алба (“Ростехнадзор”) нь газрын хэвлий ашиглах чиглэлээр үйлдвэрлэлийн аюулгүй байдал, экологийн стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, экологийн шинжээчдийн дүгнэлтийг холбооны түвшинд хийж, газрын хэвлийд тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тогтмол шалгалт хийдэг.
4. ОХУ-ын бүрэлдэхүүн хэсгүүдийн гүйцэтгэх эрх мэдэл, орон нутгийн эрх бүхий байгууллагууд өөрсдийн эрх хэмжээний хүрээнд газрын хэвлийг ашиглах асуудлыг зохицуулдаг.

Ашигт малтмалын нөөцийг хайх, олборлох тусгай зөвшөөрлийг дараахь 3 төрлөөр олгодог.

1. Геологи судалгааны тусгай зөвшөөрлийг хайгуулын үйл ажиллагаа явуулах, ордын нөөцийг тогтоох хүрээнд 5 жил, далайн бүс нутагт /далайн гүнд/ 10 жилийн хугацаатай олгоно. Энэ төрлийн тусгай зөвшөөрөлд зөвхөн тодорхой заасан ашигт малтмалын төрлийг судлах эрхтэй. Өөрөөр хэлбэл, судалгаа явуулж буй талбайд тусгай зөвшөөрөлд заагаагүй өөр төрлийн ашигт малтмал илрүүлсэн тохиолдолд тухайн төрлийн ашигт малтмалд шинээр тусгай зөвшөөрөл авах ёстой. Лицензийн нөхцлийн хүрээнд хийх геологийн судалгааны ажлын төлөвлөгөө, хэмжээ, нөхцөлийг тусдаа төсөл эсвэл техникийн төслөөр батлуулах ёстой бөгөөд түүнийг лиценз эзэмшигч боловсруулж, Роснедра батлана. Ерөнхий дүрмийн дагуу Судалгааны тусгай зөвшөөрлийг нэр дэвшигчийн өргөдлийг үндэслэн тендерийн дуудлага худалдаагүйгээр олгож

болох ба хэд хэдэн тусгай зөвшөөрөл хүсэгч байгаа тохиолдолд дуудлага худалдааг явуулдаг байна.

2. Ордын нарийвчилсан хайгуулын тусгай зөвшөөрлийг дангаар нь бус олборлолтын тусгай зөвшөөрлийн хамт олгодог.
3. Олборлолтын тусгай зөвшөөрөл нь тухайн эдэлбэр газарт хайгуул хийх, нөөцийг олборлох, түүнчлэн уурхайн хаягдлыг боловсруулах эрхийн хамт давхар олгогддог. Энэ төрлийн тусгай зөвшөөрөл 20 жил, аль эсвэл ашигт малтмалын ордын олборлолтын хугацаанд хүчинтэй.

Тусгай зөвшөөрлийг дуудлага худалдааны зарчмаар олгодог бөгөөд эрхийг шилжүүлэх нь нээлттэй.

1. Дуудлага худалдаанд оролцох өргөдөл гаргах, бүртгүүлэх дараалал

1. Дуудлага худалдаанд оролцох өргөдөл гаргахаас өмнө өргөдөл гаргагч нь дуудлага худалдааны журам, нөхцлийн 1-р хавсралтын дагуу хоёр хувь хэлбэрээр тухайн мужийн газрын хэвлийн ашиглалтын газартай /Приволжскнедратай /гэрээ байгуулна.
2. Өргөдөл гаргагчаас газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдаанд оролцсоны төлбөрийг авдаг бөгөөд энэ нь өргөдлийг бүртгэх нөхцлүүдийн нэг юм.
3. Башнедрагийн эрх бүхий албан тушаалтан ирүүлсэн өргөдлийг бүртгэлд бүртгэж, түүний дугаар, огноо, хүлээн авсан орон нутгийн цаг, хугацааг зааж өгнө.
4. Башнедрагийн эрх бүхий албан тушаалтан бүртгэгдсэн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг битүүмжилсэн дугтуйнд хийж, газрын хэвлий ашиглах эрхийн тендер, дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэгт хүргүүлнэ.
5. Өргөдөлд хавсаргасан дугтуйг нээх ажлыг өргөдөл хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш ажлын эхний өдөр ажлын хэсэг гүйцэтгэдэг. Өргөдөлд хавсаргасан дугтуйг нээх үр дүнг нэгтгэсэн тэмдэглэлд дараахь зүйлийг тусгана:
 1. ажлын хэсгийн хуралдааны өдөр, цаг, газар;
 2. өргөдөл гаргагчдын тухай мэдээлэл, ажлын хэсэгт нээсэн өргөдөлд хавсаргасан дугтуй;
 3. түүнд хавсаргасан өргөдөл, баримт бичгийн жагсаалт;
 4. тооллогод заасан баримт бичиг байгаа эсэх тухай мэдээлэл;
 5. өргөдөл ирээгүй тухай мэдээлэл
 6. газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдаанд оролцох нэг өргөдлийг хүлээн тэмдэглэл авсан тухай мэдээлэл;
 7. ажлын хэсгээс шийдвэрлэсэн бусад мэдээлэл.Хуралдаанд оролцсон ажлын хэсгийн бүх гишүүд тэмдэглэлд нэг өдөр гарын үсэг зурна.
6. Башнедрагийн албан тушаалтан, өргөдөлд хавсаргасан дугтуйг нээх, үр дүнг нэгтгэх тэмдэглэлд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 2 хоногийн дотор (баримт бичгийн иж бүрдэл байгаа бол эсвэл хүссэн баримт бичгийг хүлээн авсан төрийн байгууллагуудаас), хүлээн авсан өргөдлийн материал, ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлийг дуудлага худалдааны комисст илгээж, ирүүлсэн өргөдлийг хэлэлцэж, хүлээн авах, хүлээн авахаас татгалзах шийдвэр гаргана.

2. Дуудлага худалдаанд оролцох өргөдлийг хэлэлцэн хүлээн авах

1. Дуудлага худалдаанд оролцох өргөдлийг дуудлага худалдааны комисс хүлээж авсан өдрөөс хойш ажлын 15 хоногт багтаан дуудлага худалдаанд оролцохыг хүссэн өргөдөл гаргагчийн санхүүгийн, боловсон хүчин, техникийн чадавхийг шалгах зорилгоор өргөдлийн материалыг хянана. Өргөдлийг хүлээн авсан, эсхүл хүлээн авахаас татгалзах шийдвэрийг дуудлага худалдааны комиссын хуралдааны тэмдэглэлд хөтлөнө.
2. Өргөдлийг хэлэлцсэн тэмдэглэлд:
 1. дуудлага худалдааны комиссын хуралдааны өдөр, цаг, газар;
 2. өргөдөлд хавсаргасан өргөдлийн материал бүхий дугтуйг ажлын хэсэг нээсэн өргөдөл гаргагчдын нэрсийн жагсаалт;
 3. өргөдлийг буцааж татсан өргөдөл гаргагчдын жагсаалт;
 4. дуудлага худалдаанд оролцохыг хүлээн зөвшөөрсөн өргөдөл гаргагчдын нэрсийн жагсаалт;
 5. өргөдлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг харуулсан дуудлага худалдаанд оролцохыг хүсэлтийг хүлээн аваагүй өргөдөл гаргагчдын нэрсийн жагсаалт;
 6. дуудлага худалдаанд оролцох журам, нөхцлөөр тогтоосон хэмжээ, хугацаанд хадгаламж эзэмшигчид хадгаламж, дуудлага худалдаанд оролцсоны төлбөрийг төлсөн болохыг баталгаажуулсан баримт бичгийн дэлгэрэнгүй мэдээлэл;
 7. дуудлага худалдааны комиссоос шийдвэрлэсэн бусад мэдээлэл. Өргөдлийг хэлэлцэх тэмдэглэлийг комиссын нарийн бичгийн дарга боловсруулж, хуралд оролцсон дуудлага худалдааны комиссын бүх гишүүд гарын үсэг зурна.

Өргөдлийг хүлээн авахаас татгалзах нь дараахь тохиолдолд үүсч болно:

1. өргөдөл нь тогтоосон шаардлагыг зөрчсөн, түүний агуулга нь зарлагдсан журам, газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдаа зохион байгуулах нөхцөлтэй нийцэхгүй байдал гаргасан;
 2. өргөдөл гаргагч өөрийн тухай буруу мэдээлэл санаатайгаар өгсөн;
 3. өргөдөл гаргагч нь мэргэшсэн мэргэжилтэн, үр дүнтэй ажиллахад шаардагдах санхүүгийн болон техникийн хэрэгслийг эзэмшсэн, эсвэл эзэмшиж буйгаа нотолж өгөөгүй бөгөөд нотлох баримт гаргаж чадахгүй.
3. Приволжскнедрагийн албан тушаалтан дуудлага худалдааны комисс тэмдэглэлд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор өргөдөл гаргагчдад өргөдлийг хүлээн авах, эсхүл хүлээн авахаас татгалзсан шийдвэрийг өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.
 4. Газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдаанд оролцох өргөдлийг хүлээн авах шийдвэр гаргасан дуудлага худалдааны комисс тэмдэглэлд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн өргөдлийг нь хүлээн авсан өргөдөл гаргагчид дуудлага худалдааны оролцогч болно.

3. Дуудлага худалдааны комиссын ажлын дараалал ба дуудлага худалдаа

1. Газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдааг дуудлага худалдааны комисс зохион байгуулдаг. Дуудлага худалдааны комисс нь комиссын дарга, орлогч дарга болон бусад гишүүдээс бүрдэнэ. Дуудлага худалдааны комиссын дарга нь комиссын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, комиссын хуралдааныг даргалдаг. Комиссын дарга байхгүй тохиолдолд түүний чиг үүргийг комиссын орлогч дарга гүйцэтгэдэг.

2. Газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдаа болох өдөр дуудлага худалдааны комиссын гишүүдийн нэг нь дуудлага худалдаанд оролцогчдын төлөөлөгчдийг бүртгэдэг. Бүртгэл нь газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдаа эхлэхээс нэг цагийн өмнө эхэлж, дуудлага худалдаа эхлэхээс таван минутын өмнө дуусна. Дуудлага худалдаанд оролцогчдын бүртгэгдсэн төлөөлөгчдийн жагсаалтыг дуудлага худалдааны комиссын даргад өгнө.
3. Газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдааг дуудлага худалдаанд оролцогчид газрын хэвлийг ашигласны төлбөрийн нэг удаагийн саналыг зарлаж нээлттэй хэлбэрээр явуулдаг. Дуудлага худалдааны үе шатны хэмжээг нэг удаагийн төлбөрийн эхлэх хэмжээнээс 10 (арван) хувиар тогтоосон.

Газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдааг дараахь тохиолдолд хүчингүйд тооцно:

- 3.1. дуудлага худалдаанд оролцох өргөдөл ирээгүй тохиолдолд;
 - 3.2. дуудлага худалдаанд оролцохоор нэг өргөдөл бүртгүүлсэн;
 - 3.3. дуудлага худалдаанд зөвхөн нэг өргөдөл гаргагч оролцох эрхтэй;
 - 3.4. бүх өргөдөл гаргагчийг дуудлага худалдаанд оролцохыг хориглосон;
 - 3.5. дуудлага худалдаанд оролцогчид анхны дүнгээс дээш нэг удаагийн төлбөр санал болгоогүй;
 - 3.6. дуудлага худалдааны комиссын эцсийн хуралдаанд хоёроос цөөн оролцогч бүртгүүлсэн
4. Хэрэв нэг удаагийн төлбөрийн дараагийн үнийг гурван удаа зарласны дараа дуудлага худалдаанд оролцогчдын хэн нь ч регистрийн дугаартай хавтангаа өргөөгүй бол дуудлага худалдаа дуусна. Дуудлага худалдаанд оролцогч нь газрын хэвлий ашигласны төлбөрийн хамгийн өндөр хэмжээг санал болгосон бол дуудлага худалдааны ялагчаар тодорно.

4. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааг дүгнэх, олон нийтэд нийтлэх

1. Газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдааны дүнг дуудлага худалдааны комисс нэгтгэн гаргаж, газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдааны үр дүнгийн тэмдэглэлээр гаргана.
2. Газрын хэвлийг ашиглах эрхийн дуудлага худалдааны үр дүнгийн тэмдэглэлийг дуудлага худалдаа явагдах өдөр 3 хувь үйлдэж, дуудлага худалдааны комиссын бүх гишүүд гарын үсэг зурна.
3. Газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдааны үр дүнг батлах, дуудлага худалдааг хүчингүйд тооцох шийдвэрийг газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдаа явагдсан өдрөөс хойш 30-аас доошгүй хоногийн дараа гаргаж, Приволжскнедрагийн тушаалаар батлана.
4. Приволжскнедра нь газрын хэвлий ашиглах эрхийн дуудлага худалдааны үр дүнгийн талаар ОХУ-ын албан ёсны вэбсайт дахь мэдээлэл, харилцаа холбооны "Интернет" сүлжээнд: www.torgi.gov.ru үр дүнг батлах шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10-аас доошгүй хоногийн хугацаанд мэдээллээр хангадаг.

Хавсралт 5. Канад Улсын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох зохицуулалт

Тойм судалгаа

№	Үзүүлэлт	Мэдээлэл
1	Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт	Тийм
2	Орон нутгийн талуудын өмчлөлийн шаардлага	Байхгүй
3	Уугуул болон орон нутгийн иргэдийн эрх, оролцоо	Тийм
4	Газар эзэмших	Олборлох эрх нь газар эзэмших эрхээс тусдаа байдаг
5	Байгаль орчныг хамгаалах зохицуулалт	Өндөр
6	Нөхөн сэргээлтийн бонд эсвэл баталгаа	Тийм
7	Хайгуулын тусгай зөвшөөрөл	Ихэвчлэн 1-24 жил, хэрэв үйл ажиллагаа явуулсан бол хугацааг сунгах
8	Ашиглалтын тусгай зөвшөөрөл	Ерөнхийдөө 15-30 жил
9	Засгийн газарт төлөх роялти	Тийм. Хэмжээ нь эрдэс бодис, мужаас хамаарна

Эх үүсвэр: Global mining guide, 2020, Baker McKenzie

Канад бол үндсэн хуульт хаант болон парламентын засаглалтай ардчилсан улс бөгөөд 10 муж, гурван нутаг дэвсгэрээс бүрдсэн холбооны улс юм. Энэхүү ардчилсан бүтцэд хамаарах чиг үүргүүдийг парламентын засаглалын холбооны системээр дамжуулан хуваарилдаг.

Канадын уул уурхайн салбарын давамгайлсан олборлолтод Баруун хойд нутаг дэвсгэр багтдаг бөгөөд тус улсын алмаазын зонхилох эх үүсвэр нь Онтарио, Квебек, Саскачеван нь Канадын бүх ураныг үйлдвэрлэдэг бөгөөд дэлхийн хэмжээний калийн нөөцтэй, Британийн Колумб нь металлургийн нүүрсний үйлдвэрлэл, Ньюфаундленд, Лабрадор, Квебек зэрэг нь Канадын бараг бүх төмрийн хүдрийг үйлдвэрлэдэг.

Канад улс нь ашигт малтмалын үйл ажиллагаатай холбоотой дараах гурван төрлийн тусгай зөвшөөрлийн олгодог.

1. Эрлийн тусгай зөвшөөрөл
2. Хайгуулын тусгай зөвшөөрөл
3. Олборлолтын тусгай зөвшөөрөл

Баруун хойд нутаг, Нунавут, Британийн Колумб, Манитоба, Нью Брансвик, Принц Эдвард зэрэг газруудад хувь хүмүүс болон компаниуд ашигт малтмалын нөөцийг хайх үйл ажиллагаа эрхлэхийн тулд эрлийн тусгай зөршөөрлийг /prospector's license/ холбогдох муж, нутаг дэвсгэрийн засгийн газраас авах шаардлагатай байдаг. Эрлийн тусгай зөвшөөрлийг холбогдох муж, нутаг

дэвсгэрийн засгийн газартай холбоо барьж, шаардлагатай маягтыг бөглөж, бага хэмжээний төлбөр төлснөөр ихэнх харьяаллын дагуу авах боломжтой. Ихэнх мужид хайгуулын лицензийн хугацаа нь тодорхой хугацааны дараа дуусдаг.

Ашигт малтмалын хайгуул хийх эрхийг ашигт малтмалын "тусгай зөвшөөрөл" эсвэл "зөвшөөрөл"-ыг хүсэлт гаргах тендерээр олж авдаг. Хүсэлт гаргахын өмнө холбогдох төлбөр, баримт бичиг шаардлагатай бөгөөд зарим мужуудад (жишээлбэл, Юкон) бүртгэл хийхээс өмнө эсвэл хайгуулын хөтөлбөр зохион байгуулахаас өмнө уугуул оршин суугчдын холбоонд мэдэгдэж, холбоо тогтоох шаардлагатай байдаг. Ашигт малтмалын эрхийг хадгалахын тулд тогтоосон хэмжээгээр ажил гүйцэтгэх ёстой. Эрх эзэмших хугацаа нь муж бүрт ялгаатай байдаг. Мөн ашигт малтмалын эрх эзэмшигч нь хайгуул хийхэд нэвтрэх эрхтэй байдаг боловч тухайн газар нь хувийн өмч байвал газар эзэмшигчид мэдэгдэх эсвэл гэрээ байгуулах шаардлагатай.

Канад улсын мужуудаас бидний судалгаанд оновчтой тохирох мужийг сонгохдоо хайгуулд зарцуулж буй хөрөнгө, ордын үнэлгээний хэмжээ хамгийн өндөр болон хөрөнгө оруулалтын орчны таатай байдлыг судлан Саскачеван мужийг сонгов.

"Fraser Institute"-н 2020 онд хийсэн уул уурхайн салбарын судалгаанд уул уурхай болон хайгуулын үйл ажиллагааны бий болгож буй үр өгөөж, хөрөнгө оруулалтын орчноор нь улс орнууд, тэдгээрийн мужуудыг эрэмблэн жагсаасан. Тус судалгаанд Хөрөнгө оруулалтын сонирхол татахуйц индексээр нэгдүгээр байранд Невада орсон бөгөөд Канад улсын мужуудаас **Саскачеван муж** 3 дугаар байранд орсон юм.

Саскачеван мужийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох системийн тухай мэдээллүүд

Уул уурхайн ашигт малтмалын үйл ажиллагаа эрхлэхэд дагаж мөрдөх эрх зүйн бичиг баримт, удирдамжууд:

1. Subsurface mineral tenure regulation, 2015
2. Mineral resource act, 1985
3. Mines regulation, 2018
4. Mineral tenure registry regulation, 2012
5. Mineral disposition regulation, 1986

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгож буй арга:

Канад улсын Саскачеван муж нь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгохдоо **олон нийтийн тендерийн** аргыг ашигладаг. Ашигт малтмалын хайгуулын эрхийг олон нийтэд нээлттэй тендер хэлбэрээр өгөх тохиолдолд сайд холбогдох зөвлөлтэй зөвлөлдсөний дараа тендерийн тухай мэдэгдэл бэлтгэх ёстой. Сайд тендерийн тухай зарласан саналын хувийг хэвлэхээсээ өмнө зөвлөлд танилцуулж, албан ёсны вебсайтад хэвлэн нийтлэх ёстой.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагаанд оролцогч талууд:



Канадын Саскачеван мужийн газар нутагт тусгай зөвшөөрөл хүсэгч этгээд нь Эрчим хүч, байгалийн баялагийн яаманд “Subsurface mineral tenure regulation”-н дагуу өргөдөл гаргаж, тендерт оролцож олж авдаг.

Саскачеван муж нь ашигт малтмалын үйл ажиллагаатай холбоотой дараах гурван төрлийн зөвшөөрөл олгодог.

Канад улсын Саскачеван мужийн ашигт малтмалын зөвшөөрлийн төрөл, дэлгэрэнгүй мэдээлэл

Үзүүлэлт	Эрлийн тусгай зөвшөөрөл /prospecting license/	Хайгуулын тусгай зөвшөөрөл /mineral claim/	Олборлолтын тусгай зөвшөөрөл /Mining lease/
Хугацаа	2 жил	1 жил /хамгийн ихдээ 8 жил/	10 жил
Дахин олгогдох боломж	Үгүй	Хайгуулын ажлын шаардлагатай зардлыг зарцуулж, холбогдох журмыг дагах мөрдсөн бол жил бүр сунгагдана	Журмын дагаж мөрдсөн тохиолдолд дахиад 10 жилийн хугацаатай олгоно
Төлбөр	Нэг га тутамд 0.30 доллар, хамгийн багадаа 3000 доллар	Нэг га-д 0.60 доллар, хамгийн багадаа 300 доллар	Нэг га тутамд 10 доллар, хамгийн багадаа 1,600 доллар
Талбайн хэмжээ	10,000-аас 50,000 га-ийн хооронд	6000 га-аас ихгүй	-
Зардлын шаардлага	Олгогдсон хугацаанд га тутамд 5.25 доллар	Хоёр жилийн хугацаанд 15-аас 25 долларын хооронд хэлбэлздэг бөгөөд хамгийн багадаа 240-400 долларын хооронд байна.	Хоёр жилийн хугацаанд 25-75 долларын хооронд хэлбэлздэг бөгөөд хамгийн багадаа 400-1200 доллар байдаг

Тусгай зөвшөөрлөөр олгох эрх

1. Шинжилгээ, туршилт;
2.Металлургийн, эрдэс судлалын болон бусад шинжлэх ухааны судалгаа хийх
3.Журамд заасан шаардлагыг хангасан тохиолдолд зөвшөөрлөө бусдад шилжүүлэх
4.Сайдад мэдэгдсэний үндсэн дээр бөөнөөр түүвэрлэлт хийх
5.Эрлийн тусгай зөвшөөрлөө хайгуулын тусгай зөвшөөрөл рүү шилжүүлэх

1. Шинжилгээ, туршилт;
2.Металлургийн, эрдэс судлалын болон бусад шинжлэх ухааны судалгаа хийх
3.Журамд заасан шаардлагыг хангасан тохиолдолд зөвшөөрлөө бусдад шилжүүлэх
4.Сайдад мэдэгдсэний үндсэн дээр бөөнөөр түүвэрлэлт хийх
5.Эрлийн тусгай зөвшөөрлөө хайгуулын тусгай зөвшөөрөл рүү шилжүүлэх

Хайх, олборлох, нийлүүлэх, ажиллах, зөөвөрлөх, ашиглах, сэргээх;

Эх үүсвэр: Global mining guide, 2020, Baker McKenzie

Газрын доорхи ашигт малтмалын ашиглалтын журмын дагуу олон нийтэд санал болгох үйл явц нь газрын тос, байгалийн хийн олголтын процесстой ижил төстэй явагддаг.

Хавсралт 6. 1994 оны Ашигт малтмалын тухай хуулийг ҮЗАМ-51 зарчмуудаар шүүсэн шүүлт.

